



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**



---

# **“МОНГОЛ МАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН II ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

---

**Гүйцэтгэгч: “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ**

**Захиалагч: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**



**2019 оны 11-р сарын 1-ний өдөр**



Энэхүү тайлан нь Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгат зөвлөх үйлчилгээний ажлын үр дүнг эмхэтгэсэн бүтээл бөгөөд тус ажлыг 190820/10-304 тоот гэрээний дагуу “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” төрийн бус байгууллага (ТББ) гүйцэтгэв.

## **ЗОХИОГЧИД**

Гончигсумлаагийн Ганзориг (Доктор, PhD)

Гүржавын Энх-Амгалан (Магистр, MSc)

Цабатширын Батнаран (Магистр, MSc)

## **ЗОХИОГЧИЙН ЭРХ**

© Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ, 2019 он

## **САНАМЖ**

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II шатны хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайлангийн агуулга нь захиалагч байгууллагын бодлого, үзэл бодлыг илэрхийлээгүй болно. Боловсролын болон бусад арилжааны бус зориулалтаар энэхүү материалыг хуулбарлахыг бүрэн хүлээн зөвшөөрсөн бөгөөд эх сурвалжийг заавал дурдах шаардлагатай болно.

## **ТАЛАРХАЛ**

Тус тайланг боловсруулах ажлыг санхүүжүүлсэн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, үнэтэй саналаа хуваалцсан орон нутгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, мэргэжилтнүүд, эрдэмтэн, судлаачид болон санал асуулгад оролцсон малчдад гүн талархлаа илэрхийлж байна.

## **ХОЛБОО БАРИХ ХАЯГ**

“Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ  
Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул Дүүрэг, 11-р хороо  
ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн байрны 215 тоот  
Имэйл хаяг: ganzorig.g@muls.edu.mn



## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	6
НЭГ. УДИРТГАЛ .....	7
1.1 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА .....	7
1.2 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО .....	8
1.3 АЖЛЫН ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОЙМ .....	8
1.4 ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	10
1.4.1 Хөтөлбөрийн зорилго .....	10
1.4.2 Тэргүүлэх чиглэл .....	10
1.4.3 Тэргүүлэх чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн зорилт .....	10
1.4.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат .....	12
1.4.5 Хөтөлбөрийн II үе шат хэрэгжсэнээр бий болох хүлээгдэж байгаа үр дүн ....	12
ХОЁР. АРГА ЗҮЙ .....	13
2.1 АРГА ЗҮЙН ТОЙМ .....	13
2.2 ХАМРАХ ХҮРЭЭ .....	13
2.3 ТОО МЭДЭЭ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ.....	13
ГУРАВ. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	15
3.1 ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ .....	15
3.1.1 Хийгдсэн ажил .....	15
3.1.2 Хэрэгжсэн болон хэрэгжээгүй ажлууд .....	17
3.1.3 Зарцуулагдсан төсөв.....	23
3.2 ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН .....	26
3.2.1 Хөтөлбөр хэрэгжүүлснээр гарсан үр дүн (Ерөнхий).....	26
3.2.2 Хүлээгдэж байсан үр дүнд хүрсэн эсэх (Шалгуур үзүүлэлтээр).....	56



3.2.3 Орон нутгаас “Монгол мал” үндэсний хөтөлбөрт өгсөн санал, шүүмж.....	72
3.3 МАЛЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ҮР ДҮН.....	79
3.3.1 Ерөнхий мэдээлэл.....	79
3.3.2 Хөтөлбөрийн талаар малчдын ойлголт, үнэлгээ.....	80
3.3.3 Малчдын санал.....	81
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.....	82
ТАВ. ЗӨВЛӨМЖ.....	84
ЗУРГАА. АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	87
ДОЛОО. ХАВСРАЛТ.....	88
7.1 ХАВСРАЛТ 1. БҮХ АЙМГУУДЫН ХХААГ-Т ХҮРГҮҮЛСЭН АЛБАН БИЧИГ.....	88
7.2 ХАВСРАЛТ 2. УВС АЙМАГТ АЖИЛЛАСАН ИЛТГЭХ ХУУДАС.....	91
7.3 ХАВСРАЛТ 3. АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭС ММҮХ-Т ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ.....	93
7.4 ХАВСРАЛТ 4. МАЛЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН МАЯГТ.....	104
7.5 ХАВСРАЛТ 5. ГУРВАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ.....	105



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	– Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮХС	– Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ИТХ	– Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАА	– Мал аж ахуй
МУЗГ	– Монгол Улсын засгийн газар
ММҮХ	– “Монгол мал” үндэсний хөтөлбөр
МЭГ	– Мал эмнэлгийн газар
МЭҮН	– Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
МЭҮТ	– Мал эмнэлэг, үржлийн тасаг
ОУБ	– Олон улсын байгууллага
ТББ	– Төрийн бус байгууллага
ТМТББ	– Төрөөс малчдын талаар баримтлах бодлого
УИХ	– Улсын их хурал
ҮСХ	– Үндэсний статистикийн хороо
ХХААГ	– Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	– Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮ	– Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХШҮДАГ	– Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ЭМГ	– Эрүүл мэндийн газар
ХХААБ	– НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийсэн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын гүйцэтгэлийн тойм.....	9
Хүснэгт 2. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил (хоёр дахь үе шатны явц буюу 2016-2018 онд).....	15
Хүснэгт 3. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатыг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн орон нутгийн төсвийн зардал (21 аймаг, нийслэлийн хэмжээнд) .....	24
Хүснэгт 4. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд улсын хэмжээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн.....	26
Хүснэгт 5. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 1-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин .....	57
Хүснэгт 6. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 1.1 дүгээр шалгуур үзүүлэлтийн үнэлгээ .....	57
Хүснэгт 7. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин .....	59
Хүснэгт 8. Малчдад олгосон ноосны урамшуулал .....	66
Хүснэгт 9. Малчдад олгосон арьс, ширний урамшуулал .....	67
Хүснэгт 10. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2016-2018 оны хэрэгжилтэд шалгуур үзүүлэлтийн дагуу өгсөн үнэлгээ .....	68
Хүснэгт 11. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд малчдын өгсөн үнэлгээ .....	81



## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн үндсэн 5 чиглэл .....	7
Зураг 2. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилт .....	18
Зураг 3. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны үнэлэх хугацаа нь болоогүй ажлын эхэлсэн ба дуусах он.....	18
Зураг 4. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатыг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн болон зарцуулсан улсын төсөв .....	23
Зураг 5. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд зарцуулсан орон нутгийн төсвийн зардлын бүтэц (%) .....	24
Зураг 6. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд зарцуулсан орон нутгийн зардал (Сая төгрөг) .....	25
Зураг 7. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд зарцуулсан зардал .....	26
Зураг 8. Дотоодод үйлдвэрлэсэн малын үр, хөврөл (тун) .....	61
Зураг 9. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээ, тэргүүлэх чиглэлээр.....	71
Зураг 10. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн талаар малчдын ойлголт, насны бүлгээр.....	80
Зураг 11. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн малчдад үзүүлж буй нөлөө.....	81

## НЭГ. УДИРТГАЛ

Мал аж ахуйн салбар нь 2018 оны байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 10%, ХАА-н салбарын нийт үйлдвэрлэлийн 84%, экспортын орлогын 7.6%-ийг тус тус бүрдүүлж, нийт ажиллах хүчний 23%-ийг ажлын байраар хангасан байна (ҮСХ, 2019). Мал аж ахуйн салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүд дундаас “Монгол мал” үндэсний хөтөлбөр нь томоохон баримт бичгүүдийн нэг юм (УИХ, 2010).

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг УИХ-ын 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан бөгөөд үүнд үндсэн 5 чиглэл, түүнийг хангах 109 арга хэмжээг тусгасан. Үндсэн 5 чиглэлийг доорх диаграммд харуулав.

**Зураг 1.** “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн үндсэн 5 чиглэл



Эх сурвалж: УИХ (2010)

Тус баримт бичиг батлагдсанаар мал аж ахуйн салбарт хэрэгжих урт хугацааны төрийн бодлого өмнөх үеийнхээс илүү тодорхой болсон, үүний үр дүнд төр засгаас тодорхой ажлууд хийгдэж байна.

### 1.1 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтийн явцад ХХААХҮЯ-наас хэд хэдэн төрлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-г хагас жил, жилийн давтамжтай хийж байсан байна. Үүнд:

1. ХХААХҮЯ-ны 2016-2018 онд хийсэн тус хөтөлбөрийн хэрэгжилтийн ХШҮ,
2. “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ний 2016-2018 онд ХХААХҮЯ-ны санхүүжилттэйгээр хийсэн “Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа”,



3. ХХААХҮЯ-ны 2016-2018 онд хийсэн “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ХШҮ”,
4. 2016-2018 онд хийгдсэн “ХХААХҮЯ-ны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн ХШҮ”,
5. ХХААХҮЯ-ны 2016-2018 онд хийсэн “Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийсэн ХШҮ-ний танилцуулга (2018 оны жилийн эцсийн байдлаар)”,
6. ХХААХҮЯ-ны 2016-2018 онд хийсэн “Аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн ХШҮ-ний ажлын товч танилцуулга”.

Одоогоор тус хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтийн явцад **хөндлөнгийн үнэлгээ хийгдээгүй байна**. МУЗГ (2017)-аас баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2.1.5-д <<“хөндлөнгийн үнэлгээ” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчдийн хийсэн ХШҮ-г хэлнэ>> гэж заасан.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-д “Төрийн захиргааны төв байгууллага жил бүр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд ХШҮ хийж, **шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газарт танилцуулна**” гэж заасан байдаг боловч “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2-р шатны хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ огт хийгдээгүй байна.

ХХААХҮЯ 2019 оны төсөвт “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх төсвийг суулгаж, өдгөө энэ ажлыг “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” төрийн бус байгууллага (ТББ) гүйцэтгэж, энэхүү тайланд үнэлгээний үр дүнг танилцуулж байна.

## 1.2 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэх, зөвлөмж боловсруулах нь тус зөвлөх үйлчилгээний зорилго болно.

## 1.3 АЖЛЫН ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОЙМ

Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг хэрхэн гүйцэтгэсэн талаар доорх хүснэгтэд тоймлон оруулав.



**Хүснэгт 1. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийсэн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын гүйцэтгэлийн тойм**

№	Захиалагчийн шаардлага	Гүйцэтгэсэн байдал	Ажил гүйцэтгэхэд оролцсон зөвлөхийн тоо
1	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд шинжилгээ хийх - Эхний үе шат (2010-2015) - Хоёр дахь үе шат (2016-2021)	ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-аас “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн ХШҮ-ний 2016-2018 оны тайлангууд дээр шинжилгээ хийв. Хийсэн шинжилгээг тус тайлангийн 3.1, 3.2 дугаар хэсэгт оруулсан болно.	3
2	Хэрэгжилтийн тайланд шинжилгээ хийсэн явцын мэдээлэл танилцуулах	ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-т тус хөтөлбөрийн ХШҮ-ний тайланд хийсэн шинжилгээний урьдчилсан үр дүнг 2019 оны 9-р сарын 10, 10-р сарын 20-нд 2 удаа танилцуулж, санал, зөвлөмжийг авсан болно.	2
3	Шаардлагатай тохиолдолд Увс, Дундговь, Сүхбаатар аймгуудад ажиллаж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, үр дүнтэй танилцах	2019 оны 8-р сарын 28-30-ны өдрүүдэд Увс аймагт томилолтоор ажиллаж аймгийн ХХААГ-ын дарга Д.Төмөр-Очир, Мал аж ахуйн албаны дарга н.Лантуу нартай уулзаж “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, тулгарч буй бэрхшээлийн талаар судалгаа хийж, зохих уулзалт зохион байгуулсан. Томилолтоор ажилласан үр дүнг тус тайлангийн Хавсралт 2-т оруулсан болно. Мөн Төв аймгийн Алтанбулаг сумын Алтан-Овоо багийн 22 малчин өрхөөс “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн талаарх ойлголт, тус хөтөлбөрийн хэрэгжилт, малчдад өгч байгаа үр дүнг тандан судлах зорилгоор санал асуулга авсан болно. Санал асуулгын үр дүнг 3.3 дугаар хэсэгт оруулсан болно.	3
4	Тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл, тодруулгыг ХШҮДАГ-с тодруулна	Орон нутгаас нэмэлт мэдээлэл цуглуулах талаар ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-аас тодруулга авсны үндсэн дээр 21 аймаг, нийслэлийн ХХААГ-аас тоо мэдээ цуглуулах ажлыг ХШҮДАГ-тай хамтран зохион байгуулсан. Ингэхийн тулд ХХААХҮЯ-ны ТЗУГ-ын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Жамбалцэрэнгээс 21 аймаг, нийслэлийн ХХААГ-т тоо мэдээ цуглуулах тухай тоот 01/3581 тоот албан бичгийг 2019 оны 9-р сарын 18-ны өдөр хүргүүлж мэдээлэл цуглуулсан болно (Хавсралт 1). Аймаг, нийслэлээс ирсэн тоо мэдээнд үндэслэсэн судалгааны үр дүнг тус тайлангийн 3.1, 3.2 дугаар хэсэгт оруулав.	1
5	Үнэлгээ хийх аргачлал	“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн боловсруулсан аргачлалыг тус тайлангийн 2-р бүлэгт оруулсан болно.	3
6	Цаашид хөтөлбөр арга хэмжээний талаар баримтлах төр засгийн бодлогод тусгах зөвлөмж боловсруулах	Хөндлөнгийн үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид энэ төрлийн бодлогын баримт бичигт тусгах зөвлөмжийг тус тайлангийн 5-р бүлэгт оруулсан.	3
7	Хөндлөнгийн үнэлгээний ажлын явцыг захиалагчид 2 удаа, үр дүнг эцсийн байдлаар 1 удаа хэлэлцүүлэн дүгнүүлэх	Хөндлөнгийн үнэлгээний ажлын явцыг ХХААХҮЯ-ны байранд 2019 оны 09-р сарын 10-нд, 2019 оны 10-р сарын 20-нд ХХААХҮЯ-ны 4 давхрын 401 тоот өрөөнд ХШҮДАГ-ын дарга Ч.Тавинжил, ахлах мэргэжилтэн С.Сонгууль, мэргэжилтэн П.Түмэнбаяр, Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Ц.Мөнхнасан, Б.Төгс-Эрдэнэ нарт танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулав. Эцсийн хэлэлцүүлгийг 2019 оны 10-р сарын 22-нд ХХААХҮЯ-ны 8 давхрын хурлын танхимд зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлэгт ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-ын дарга Ч.Тавинжил, ахлах мэргэжилтэн Д.Батхуяг, ахлах мэргэжилтэн С.Сонгууль, мэргэжилтэн П.Түмэнбаяр, Г.Мөнхмаргад, МААХБЗГ-ын мэргэжилтэн Д.Мөнхгэрэл, Б.Төгс-Эрдэнэ, Д.Хүрэлбаатар, МГНХ-ийн мэргэжилтэн П.Баясгалан нар оролцов (Хавсралт 5). Эдгээр хэлэлцүүлгүүдээс гарсан саналыг тайланд тусгаж, эцсийн тайланг хүлээлгэн өгөв. Эцсийн хэлэлцүүлэгт ХХААХҮЯ-ны ТЗУГ, НБТГ-ын мэргэжилтнүүдийг урьсан боловч бусад ажилтай давхацсан тул ирээгүй.	3
8	Ижил төстэй ажлын гүйцэтгэсэн туршлагын талаар мэдээлэл ирүүлэх	Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн (БОХААЭЗХ) ТББ-ын захирал Т.Эрдэнэчулуун, гишүүн Г.Ганзориг нар 2018 онд “Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөө”-г НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилттэйгээр боловсруулж ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлуулсан болно. Мөн тус ТББ-ын гишүүн Г.Энх-Амгалан нь “Баруун бүсийн хувийн хэвшлийг дэмжих төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийн төслийн саналыг Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэйгээр гүйцэтгэж, Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт 2018 оны 11-р сард хүлээлгэн өгсөн. БОХААЭЗХ ТББ-ын гишүүн Г.Ганзориг нь 2019 оны 4-р сараас эхлэн “НҮБ-ын бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна. Мөн тэрээр 2014-2015 онд “Ногоон хөгжлийн бодлогын 4-р стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах” ажлын хэсгийн 4-р багийн ахлагчаар, 2014 онд “Ногоон хөгжлийн бодлогыг боловсруулах нь” ажлын хэсгийн гишүүнээр тус тус ажилласан.	3



## 1.4 ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.4.1 Хөтөлбөрийн зорилго

УИХ-ын 2010 оны 05-р сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн зорилго нь мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэхэд оршиж байна.

### 1.4.2 Тэргүүлэх чиглэл

- Монгол улсын эдийн засгийн тулгуур салбар болох мал аж ахуйг төрөөс онцгой анхаарч, эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын нэн таатай орчин бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангаж, сайн засаглалыг хөгжүүлэх,
- Малын үржлийн ажил, үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх,
- Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах,
- Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхтай мал аж ахуйг хөгжүүлэх,
- Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах.

### 1.4.3 Тэргүүлэх чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн зорилт

**Зорилт 1.** Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.

- Мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох,
- Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх, анхан шатны нэгжийг бэхжүүлэх,
- Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх.

**Зорилт 2.** Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлж, малын үржлийн ажил, үйлчилгээг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.

- Монгол малын ашигтай онцлог шинж чанарыг тухайн үүлдэр, омог хэвшлийн баталгаажсан цөм сүргээр бататган сайжруулж, удам зүй, сонгон үржүүлгийн

ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, биологийн боломжийг бүрэн ашиглах,

- Малын удмын санг хамгаалж, биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэн малын бүтээмжийг нэмэгдүүлэх,
- Малын үржлийн ажил, үйлчилгээний чадавхыг сайжруулж, хүртээмж үр дүнг дээшлүүлэх,
- Малын бүртгэл, мэдээллийн сан, сүлжээг бий болгох.

**Зорилт 3.** Эрүүл малаас цэвэр, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх нөхцөл бүрдэнэ.

- Олон улсын худалдааны хориг бүхий малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэрэмжлүүлэх, тэмцэх арга хэмжээний бэлэн байдлыг өндөржүүлж, зооноз халдварт зарим өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх,
- Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, мал эмнэлгийн ажил, үйлчилгээг эдийн засаг, нийгмийн шаардлага, эрэлт хэрэгцээг бүрэн хангах түвшинд хүргэн сайжруулах,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын стандартын түвшинд хүргэх.

**Зорилт 4.** Уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан Монгол Улсад бэлчээрийн мал аж ахуйг зонхилон, эрчимжсэн мал аж ахуйг тодорхой бүс нутагт хязгаарлагдмал хүрээнд эрхлэн, бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, тэжээл үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах замаар мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.

- Бэлчээрийн менежментийг сайжруулах,
- Хадлан, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Малын усны хангамжийг сайжруулах,
- Мал аж ахуйн эрсдэлийг бууруулах чадавх бий болгох.

**Зорилт 5.** Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгож түүний чанараас хамаарсан эдийн засгийн хөшүүрэг бий болгон зорилтот зах зээлийг хөгжүүлнэ.

- Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгох,
- Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанараас хамаарсан эдийн засгийн урамшуулал бий болгон хэрэгжүүлэх,
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийг сайжруулах, зорилтот зах зээлийг хөгжүүлэх.



#### 1.4.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

- Эхний үе шат буюу 2010-2015 он,
- Хоёрдугаар үе шат буюу 2016-2021 он

#### 1.4.5 Хөтөлбөрийн II үе шат хэрэгжсэнээр бий болох хүлээгдэж байгаа үр дүн

- Мал аж ахуйн хөгжлийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, урамшууллын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ,
- Нийт мал сүргийг бүртгэлжүүлж, мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгож түүнд бүртгэлээр тавих хяналтын тогтолцоог бүрдүүлж, хүн амыг эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах, экспортлох боломжтой болно. Малын удмын санг баяжуулах, хадгалах, хамгаалах, зохистой ашиглах нөхцөл сайжирч, импортыг орлох үржүүлгийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн хэрэгцээг бүрэн хангана,
- Байгалийн голомтот болон шинээр дахин сэргэж байгаа малын өвчний тархвар, голомтыг бүртгэн мэдээлэх газар зүйн мэдээллийн систем нэвтэрч, малын эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх сүлжээ бий болж, лабораториудын үйл ажиллагааны чадавхыг сайжруулан, био аюулгүй байдлыг ханган гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, оношлуурыг дотооддоо үйлдвэрлэж, бруцеллёзоор тайван орны статусыг хангана,
- Уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлэх хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэн байгалийн эрсдэлд автагдах явдлыг бууруулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ,
- Малын гаралтай түүхий эдийн нөөцийг дотооддоо бүрэн боловсруулж, экспортын баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжинө. Малчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд 100 хувь хамрагдаж, төрөөс үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэх болно.

## ХОЁР. АРГА ЗҮЙ

### 2.1 АРГА ЗҮЙН ТОЙМ

“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II шатны хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээг гүйцэтгэв (УИХ, 2015; МУЗГ, 2017).

Үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ эхлээд ХХААХҮЯ-ны хяналт-шинжилгээ үнэлгээ (ХШҮ)-ний тайлангууд, “Монгол мал” үндэсний хөтөлбөр, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны буюу 2016-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг эх материалыг судлав (ХХААХҮЯ, 2016). Мөн Увс, Төв аймгуудад томилолтоор ажиллан аймгийн тамгын газар болон орон нутгийн удирдлагуудтай уулзан ярилцаж, малчин өрхүүдээс түүвэр судалгаа авлаа.

Түүнээс гадна ХХААХҮЯ-ны мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтнүүд, болон мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачидтай уулзалт ярилцлага зохион байгуулав.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд зарцуулсан улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын талаар тоо мэдээ цуглуулж, зохих тоон судалгааг гүйцэтгэв.

### 2.2 ХАМРАХ ХҮРЭЭ

“Монгол мал” үндэсний хөтөлбөр нь орон даяар хэрэгждэг, тиймээс судалгааны хамрах хүрээ нь нэгдүгээрт Монгол Улсын хэмжээнд, хоёрдугаарт 21 аймаг, нийслэлийн түвшинд хийгдэв. Хавсралт 1-д 21 аймаг, нийслэлд явуулсан албан бичгийг оруулав.

### 2.3 ТОО МЭДЭЭ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Хөндлөнгийн үнэлгээнд ашиглагдсан тоо мэдээг үндсэнд нь 4 ангилав. Үүнд:

1. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд өнөөг хүртэл хийсэн ХШҮ-ний тайлангууд, хууль, эрх зүйн орчин, бодлогын баримт бичгийн судалгаа хийв.
2. Увс аймгийн ХХААГ-ын дарга Д.Төмөр-Очир, МЭГ-ын дарга н.Лантуу нартай томилолтоор очиж уулзсан (Томилолтоор ажилласан илтгэх хуудсыг Хавсралт 2-т оруулав). Мөн “Бодлого судлалын төв”-ийн захирал А.Энх-Амгалан, ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ц.Мөнхнасан нартай уулзалт ярилцлага хийв.



3. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан орон нутгийн төсөв, мөн тус хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн, дутагдалтай тал, сайжруулах арга зам зэрэг мэдээллийг агуулсан тоо мэдээг 21 аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (ХХААГ)-аас гаргуулан авав (Хавсралт 1, 3).
4. Төв аймгийн Алтанбулаг сумын Алтан-Овоо багийн 22 малчин өрхөөс “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар санал асуулга авлаа (Хавсралт 4-өөс малчдаас авсан санал асуулгын маягтыг үзнэ үү). Санал асуулгын маягтад тус хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн, мөн малчдын тус бодлогод өгөх хувь хүний үнэлгээ, цаашид сайжруулах арга зам, зөвлөмж зэргийг тусгасан болно.

Бид анхдагч болон хоёрдогч тоо мэдээллийг шинжлэхдээ аналитик шинжилгээний арга зүй, харьцуулалтын аргыг ашиглав.

ХХААХҮЯ-аас “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2016, 2017, 2018 оны тайлангууд дээр үндэслэн тус хөтөлбөрийн хүрээнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлснийг судалсан бөгөөд гүйцэтгэлийг үнэлэхдээ тухай ажил хэрэгжээгүй бол 0%, хэрэгжиж дууссан бол 100%-иар, бусад тохиолдолд хэрэгжих шатандаа явж байгаа хэмээн үнэлсэн (ХХААХҮЯ, 2019).



## ГУРАВ. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

### 3.1 ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ

#### 3.1.1 Хийгдсэн ажил

Доорх хүснэгтэд тус хөтөлбөрийн II шатанд хийгдсэн ажлыг үндсэн болон дэд зорилтын хүрээнд авч үзлээ.

**Хүснэгт 2.** “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил (хоёр дахь үе шатны явц буюу 2016-2018 онд)

Үндсэн зорилт	Дэд зорилтууд	Хийсэн ажил
<b>Нэг.</b> Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	1.1 Мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох	Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулж, батлуулах
		Хуулийн төсөл боловсруулж, хэлэлцүүлэх
		Бусад эрх зүйн баримт бичиг боловсруулж, батлуулах
		Хөтөлбөр боловсруулж, батлуулах
	1.2 Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх, анхан шатны нэгжийг бэхжүүлэх	Дэд хөтөлбөр боловсруулах
		Хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ
		Тусгай дунд мэргэжлийн мал зүйчдэд бакалаврын зэрэг олгох эчнээ сургалтыг зохион байгуулах
		Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааг стандартын шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох
	1.3 Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	Мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах
		Чадавхжуулах сургалт
		Мал аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэд технологи нэвтрүүлэх ажлыг сургалт хэлбэрээр зохион байгуулсан
		Цахим хуудас ажиллуулах
Мэдээ мэдээллийг боловсруулж, түгээх		
Стандартын шаардлага хангасан малын зураг авах		
Адуу, тэмээ, үхэр, хонь, ямаа ангилах зааврыг орон нутгийн түвшинд ашиглах боломжтой, хялбаршуулсан байдлаар боловсруулж, батлуулсан		
Телевизийн хэлэлцүүлэг, радиогийн нэвтрүүлгээр олон нийтэд мэдээлэл хүргэх		
<b>Хоёр.</b> Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлж, малын үржлийн ажил, үйлчилгээг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажлын үр дүн	2.1 Монгол малын ашигтай онцлог шинж чанарыг тухайн үүлдэр, омог хэвшлийн баталгаажсан цөм сүргээр бататган сайжруулж, удам зүй, сонгон үржүүлгийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, биологийн боломжийг бүрэн ашиглах	Малын үүлдэр, омог батлах
		Малын үзлэг ангилалт
		Үржил, селекцийн ажлыг хянан магадлах
		Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр аж ахуй байгуулах
	2.2 Малын удмын санг хамгаалж, биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэн малын бүтээмжийг нэмэгдүүлэх	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх
		Аж ахуйн нэгжүүдийн маркетинг, техникийн чадавхыг дээшлүүлж, бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэх
		Онол үйлдвэрлэлийн бага хурал зохион байгуулав
		Малын удмын сангийн үндэсний цогцолборын эхний ээлжийг ашиглалтанд оруулах, малын генийн санг хамгаалах, баяжуулах, үр, хөврөл үрийг үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах
		Үржлийн мал амьтан, тэдгээрийн генетикийн материалыг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг нэгдсэн бүртгэл, хяналттай болгох
		Хөврөл үрийг шилжүүлэн суулгах технологийн сургалт
		Цөм сүргийн аж ахуйг Чадавхжуулах
		Орон нутаг дахь Цөм сүргийн салбар нэгжүүдийн менежментийг боловсронгуй болгож, цөм сүргийн малын тоо толгойг өсгөж, үржлийн чанарыг сайжруулах
2.3 Малын бүртгэл,	Дотооддоо үр үйлдвэрлэх, импортоор үр авах	
	Зохиомол хээлтүүлгийн ажил зохион байгуулах	
	Үрийг генийн санд хадгалах	
	Мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, генийн санг арвижуулах	
		Орон нутгийн зохиомол хээлтүүлгийн салбаруудын чадавхыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах
		Мал хээлтүүлгийн ажил, үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх чиглэлээр сургалт явуулах, мэдээллээр хангах
		Малын эмэгжүүлэлтийн ажил зохион байгуулах





	<p>мэдээллийн сан, сүлжээг бий болгох</p>	<p>Малыг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг сайжруулах, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах “Сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийн сан”-г бүрдүүлэх “Сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийн сан”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах Малын бүртгэл мэдээллийн системийн техник хэрэгсэл, сүлжээг сайжруулах Малын бүртгэл мэдээллийн чиглэлийн сургалт хийх Баталгаажсан үүлдэр, омгийн малыг ялган тэмдэглэх, нэгдсэн санд оруулах ажлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний загвар бий болгох</p>
<p><b>Гурав.</b> Эрүүл малаас цэвэр, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх нөхцөл бүрдүүлэх</p>	<p>3.1 Олон улсын худалдааны хориг бүхий малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сээрэмжлүүлэх, тэмцэх арга хэмжээний бэлэн байдлыг өндөржүүлж, зооноз халдварт зарим өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх</p> <p>3.2 Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, мал эмнэлгийн ажил, үйлчилгээг эдийн засаг, нийгмийн шаардлага, эрэлт хэрэгцээг бүрэн хангах түвшинд хүргэн сайжруулах</p> <p>3.3 Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын стандартын түвшинд хүргэх</p>	<p>Үхрийн цээж болон шүлхий өвчнөөр тайван орны статус авах баримт бичиг” боловсруулах Мал, амьтны гоц халдварт өвчнөөс эрүүлжүүлэх арга хэмжээг бүсчлэн хэрэгжүүлэх “Шүлхий өвчнийг хяналтанд авах хөтөлбөр”- ийг батлуулах Мал, амьтны халдварт, зооноз өвчинтэй тэмцэх Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ Гоц халдварт өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга Мал, амьтны гоц халдварт өвчний тандалт шинжилгээ Мал эмнэлгийн лабораторийн тандалт шинжилгээ Вакцины дээжинд сорилт баталгаажуулалт хийх Бог малын мялзан өвчний ийлдсийн тандалт судалгаа Үхэрт прион уургийг илрүүлэх тандалтын шинжилгээ Малаас хүнд халддаг өвчин, архаг халдварт өвчинтэй тэмцэх Паразиттах болон халдваргүй өвчнийг оношлох, тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ Сум, дүүрэгт мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн магадлан шинжилгээ хийх чадавхтай болох Экспортлох үеийн дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл Импортлох үеийн дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл Малын өвчний оношлогооны явуулын үйлчилгээ бий болгох Мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл мэндийн гэрчилгээ, нөхцөлийг харилцан тохиролцох Монгол улсаас Япон улсад экспортлох мал эмнэлгийн гэрчилгээ, зарим бүтээгдэхүүний эрүүл мэндийн гэрчилгээ “Traces” системд бүртгүүлэх Мал эмнэлэг, ариун цэврийн дотоодын хянан магадлааг явуулах, үйлдвэр, АА-д итгэмжлэлийн зэрэглэлийг олгох Мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг шалгалтыг хийх</p> <p>Малын эм, биобэлдмэлийг дотооддоо үйлдвэрлэх Мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд болон мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, мөн малын эмийн ханган нийлүүлэх сүлжээнд үнэлгээ, хяналт тавих</p>
<p><b>Дөрөв.</b> Уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан Монгол Улсад бэлчээрийн мал аж ахуйг зонхилон, эрчимжсэн мал аж ахуйг тодорхой бүс нутагт хязгаарлагдмал хүрээнд эрхлэн, бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, тэжээл үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах замаар мал аж ахуйн</p>	<p>4.1 Бэлчээрийн менежментийг сайжруулах</p> <p>4.2 Хадлан, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх</p> <p>4.3 Малын усны хангамжийг сайжруулах</p> <p>4.4 Мал аж ахуйн эрсдэлийг бууруулах, чадавх бий болгох</p>	<p>Улс, аймаг, сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтад авах бэлчээрийн хэмжээг тогтоох Дундын отрын бүс нутгийн тохижилт үйлчилгээг сайжруулах, сэргээн засварлах Бэлчээр сайжруулах арга хэмжээ Бэлчээрийн даац, хүрэлцээ хангамжийг тооцох Бэлчээр, бэлчээрийн менежментийг сайжруулах арга хэмжээ Хадлан, тэжээлийн бэлтгэл Хадлан, тэжээлийн техник хэрэгсэл нэмэгдүүлэх Өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх Тэжээлийн ургамал тариалах, хураах Инженерийн хийцтэй худаг шинээр ашиглалтад оруулсан Гар хийцийн худаг шинээр болон сэргээн засварлан ашиглалтад оруулсан Худаг сэргээн засварлаж, дахин ашиглалтад оруулах Сэргээгдэх эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулах Булаг шанд хашиж хамгаалах, хөв цөөрөм байгуулах Малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох Мал аж ахуйн эрсдэлийг үнэлэх, сэргийлэх Малын даатгалыг өргөжүүлэх, сурталчлах</p>

эрсдэлийг бууруулах		
Тав. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгож түүний чанараас хамаарсан эдийн засгийн хөшүүрэг бий болгон зорилтот зах зээлийг хөгжүүлэх	5.1 Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгох	Мал нядалгааны цех бий болгох Мах болон сүү бэлтгэл Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх
	5.2 Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанараас хамаарсан эдийн засгийн урамшуулал бий болгон хэрэгжүүлэх	Дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн, гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнд чанараас хамааран урамшуулал олгох
	5.3 Мал аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийг сайжруулах, зорилтот зах зээлийг хөгжүүлэх	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний биржийн сүлжээ бий болгох

Эх сурвалж: ХХААХҮЯ (2017, 2018, 2019)


### 3.1.2 Хэрэгжсэн болон хэрэгжээгүй ажлууд

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шат буюу 2016-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн 5 чиглэлийн хүрээнд нийт 109 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Нийт төлөвлөсөн үйл ажиллагааны 77.9% нь хугацаа нь болоогүй байна, харин 2016-2018 онд үлдсэн 22.1% буюу нийт 24 үйл ажиллагааг хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна. Эдгээр 24 үйл ажиллагааг Тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд авч үзвэл:

- Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд 15 үйл ажиллагааг,
- Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлж, малын үржлийн ажил, үйлчилгээг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд 2 үйл ажиллагааг,
- Эрүүл малаас цэвэр, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааг,
- Мал, малын гаралтай түүхий эдийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгож, түүний чанараас хамаарсан эдийн засгийн хөшүүрэг бий болгон зорилтот зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд 3 үйл ажиллагааг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2016-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хийж гүйцэтгэсэн, хэрэгжих шатандаа явж байгаа, хэрэгжээгүй, хугацаа болоогүй байгаа үйл ажиллагаа тус бүрийг үндсэн зорилтуудын хүрээнд авч үзсэн үр дүнг дараах зургаар харуулав.


## Зураг 2. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилт



Эх сурвалж: ХХААХҮЯ (2017, 2018, 2019)-ны тоо мэдээнд үндэслэсэн зохиогчдын тооцоо

Дээрх зургаас харахад 2016-2018 онд “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 109 арга хэмжээг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнээс хэрэгжээгүй 5 (4.6%), хэрэгжих шатандаа явж байгаа 12 (11.0%), хэрэгжиж дууссан 7 (6.4%), хугацаа нь болоогүй 85 (78.0%) ажил тус тус байна. Хачирхалтай нь нийт хийгдэхээр төлөвлөгдсөн ажлын 78% нь хяналт-шинжилгээ хийгдэх хугацаа болоогүй байна. Эдгээр 85 арга хэмжээний 44-ийг 2016 онд, 37-г нь 2017 онд, 3-ыг нь 2018 онд, 1-ийг нь 2019 онд эхлүүлсэн байна. Нийт эхлүүлсэн ажлуудын 67 буюу 79% нь 2021 онд дуусах бөгөөд энэ нь тус хөтөлбөр дуусах үетэй давхцаж байгаа юм (Зураг 3).

Зураг 3. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны үнэлэх хугацаа нь болоогүй ажлын эхэлсэн ба дуусах он



Эх сурвалж: Эх сурвалж: ХХААХҮЯ (2017, 2018, 2019)-ны тоо мэдээнд үндэслэсэн зохиогчдын зурсан зураг



Дээрх зургаас харахад “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө тус ажлын дуусах хугацаа нь хэт ойролцоо буюу төсөл дуусахын үед хийгдэхээр байна. Зүй нь бол үйл ажиллагаа тус бүрийг үе шаттай, дэс дараалалтай, нэг нэгтэй нь хэт их давхцуулалгүйгээр хэрэгжүүлэх ёстой байсан, ингэснээр эхний бодлогын үр нөлөө дараагийн бодлогоор дамжин нэмэгдэх, алдаан дээрээ суралцах, туршлага суух, ирээдүйд гарах бодлогын үр өгөөжийг урт хугацаанд хадгалах боломж бүрдэх учиртай.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II шатанд хэрэгжихээр төлөвлөгдсөн ажлуудаас 1, 2 дугаар зорилтын хүрээнд 7 ажил хэрэгжиж дууссан байна, гэтэл 3, 4, 5 дугаар зорилтын хүрээнд нэг ч арга хэмжээ хэрэгжиж дуусаагүй байна. Үүний гол шалтгаан нь маш олон ажлын гүйцэтгэлийг үнэлэх цаг хугацаа нь болоогүй тул магадгүй өнөөдөр үнэлэхэд эрт байж болох талтай. Нийт арга хэмжээнээс 5 ажил хэрэгжээгүй байгаагийн 4 нь МАА-н салбарын эрх зүйн орчныг сайжруулах (1-р зорилт)-тай холбоотой байна. Эндээс харахад хууль, эрх зүйн орчныг сайжруулах нь зарим тал дээр хэт их цаг бардаг, улс төрөөс хараат байдал ихтэй тул бодлого хэрэгжих боломжийг хааж байна. Тухайлбал, 20 гаруй жилийн түүхтэй “Бэлчээрийн тухай хууль”-ийн төслийг энд дурдаж болно.

Дээрх тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд хийхээр төлөвлөсөн ажлуудыг зорилт тус бүрээр 3 ангилан авч үзэв, үүнд: 1) хийж гүйцэтгэсэн, 2) хэрэгжих шатандаа явж байгаа, 3) хугацаандаа хэрэгжээгүй үйл ажиллагаанууд багтана.

### **Зорилт 1: Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх**

#### **1) Хэрэгжиж дууссан үйл ажиллагаа:**

- Малын генетик нөөцийн тухай хуулийг УИХ-ын 2017 оны 12-р сарын 14-ний өдрийн хурлаар баталсан.
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг УИХ-ын 2017 оны 12-р сарын 08-ны өдрийн хурлаар баталсан.
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 онд УИХ-аар баталсан.
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 онд УИХ-аар баталсан.
- Малаас хүнд дамжин халдварладаг бруцеллёз өвчнийг мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтанд оруулахад хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэсэн.

#### **2) Хэрэгжих шатандаа явж байгаа үйл ажиллагаа:**

- Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн заагийг тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа бүрэн хэрэгжээгүй байна. Тайлбар: “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрт эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг дэмжих эрх зүйн зохицуулалт бүрдсэн, мөн тариалангийн зарим бүс нутаг тогтоох тухай тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2019 онд батлах бөгөөд уг төлөвлөгөөнд бэлчээрийн болон эрчимжсэн МАА эрхлэх бүс нутгийн онцлогт тохируулан малын хөлийн татварыг тогтоож байх татварын багц хуулинд тусгах арга хэмжээг тусгасан.
- Бэлчээрийг хамгаалах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх ажил хэрэгжээгүй байна. Тайлбар: 2016 онд "Бэлчээрийг хамгаалах тухай" хуулийн төслийг эргүүлэн татаж, "Отрын бэлчээрийг хамгаалах тухай хууль" -ийн төсөл болгон өөрчилж, 2017 онд батлахаар төлөвлөсөн боловч, өнөөдрийг хүртэл хугацаанд хэлэлцүүлгийн шатанд явагдаж байна.
- Малын үржлийн ажил, үйлчилгээний стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах ажил хийгдэж байна. Тайлбар: Малын үржлийн ажил, үйлчилгээний стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.
- МАА-н салбарт шинээр батлагдсан хуульд нийцүүлэн холбогдох журам, заавар, стандарт, стратегийн баримт бичгийн төслийг шинэчлэн боловсруулж батлуулах ажил хэрэгжих шатандаа явж байна. Тайлбар: 2017 онд байгуулагдсан ажлын хэсэг нь "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын болон шилжилтийн үеийн бэлтгэл хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 онд батлуулан, 125 журам, заавар, стандартын төслийг боловсруулахаар тусгасан ба үүнээс 4 журам, 3 стандартыг шинэчлэн боловсруулж, яамны цахим хуудсанд байршуулж, журмын төсөлд санал авч байна.
- Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийг хянах үндэсний хөтөлбөр боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах ажил хийгдэж байна. Тайлбар: “Малын эмийн үлдэгдлийн хяналтын хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсгийг 2016 он баталж, энэ ажлын хүрээнд НҮБ-ын ХХААБ-ын шугамаар мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийг хянах үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд гадны мэргэжлийн экспертүүд 3 удаа ирж ажилласан ба үндэсний хөтөлбөрийг боловсруулж, 2017 онд багтан Засгийн газраар батлуулахаар төлөвлөсөн боловч хэрэгжиж дуусаагүй байна.
- Мал эмнэлгийн болон малын үржлийн нэг нэгжийн үйлчилгээнд ногдох малын тоо толгойг бүсийн ялгавартайгаар тогтоох, үйлчилгээг төрөлжүүлэх, цар хүрээ, хүртээмж, үр дүнг сайжруулах ажил хэрэгжих шатандаа явж байна. Тайлбар: Энэ ажлын хүрээнд 2017 онд “Мал эмнэлгийн гэрчилгээний систем”-ийг нэвтрүүлэх туршилтын төслийг

хэрэгжүүлсэн байна. Уг системээр дамжуулан мал, малын гаралтай түүхий эдийн мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуй, гарал үүслийн гэрчилгээ боловсронгуй болгох боломжтой.

### 3) Хугацаандаа хэрэгжээгүй үйл ажиллагаа:

- Газрын тухай, Газрын төлбөрийн тухай хуульд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалттай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах, хэлэлцүүлэх ажил хэрэгжээгүй байна.
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Мал хамгаалах сангийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах, хэлэлцүүлэх ажил хэрэгжээгүй.
- Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажил хэрэгжээгүй байна.
- Мал, амьтны эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа шинэ хууль батлагдах, хэрэгжих хүртэл хугацаанд хойшлогдоод байна.

**Зорилт 2: Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлж, малын үржлийн ажил, үйлчилгээг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх**

#### 1) Хэрэгжиж дууссан үйл ажиллагаа:

- Малын генетик нөөцийг ашиглах, хамгаалах чиглэлээр зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн болон үүлдрийн зөвлөлийг байгуулах
- Малын удмын сангийн үндэсний цогцолборын эхний ээлжийг ашиглалтанд оруулж малын генийн санг хамгаалах, баяжуулах, олон улсын стандартын шаардлага хангасан үр, хөврөл үрийг үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах

**Зорилт 3: Эрүүл малаас цэвэр, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх**

#### 2) Хэрэгжих шатандаа явж байгаа үйл ажиллагаа:

- Малын өвчний оношилгоо, шинжилгээнд олон улсын стандарт, цахим технологи нэвтрүүлэх, сүлжээгээр ажиллах эрх зүйн орчин, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, үндэсний лавлагаа лабораторийг төрөлжүүлэн хөгжүүлэх  
Тайлбар: Швейцарын Хөгжлийн Агентлагийн “Малын эрүүл мэнд” төслөөс санхүүжүүлэн “Малын өвчний оношлогоо, шинжилгээний програм хангамж”-ийг 2015 онд нэвтрүүлсэн ба аймаг, сумын түвшинд хөгжүүлэлтийг 2017-2018 онд хийсэн байна.
- Мал эмнэлгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулах

Тайлбар: "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 5 дугаар бүлгийн 28 дугаар зүйлд заасны дагуу улсын түвшинд Мал эмнэлгийн ерөнхий газар, аймаг, нийслэлд мал эмнэлгийн газар, сум дүүрэгт мал эмнэлгийн тасгийг байгуулах бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбоотой УИХ-ын тогтоолын 1 төсөл, Засгийн газрын тогтоолын 7 төслийг боловсруулж, хэлэлцүүлэх бэлтгэл ажил хангагдаад байна.

- Биокомбинат ТӨААТҮГ-ын техник, технологийг шинэчлэх ажлын хэрэгжүүлж дуусгах

Тайлбар: Уг ажлын хүрээнд тендер зарласан боловч, санхүүгийн саналын оролцогч болон захиалагч талын зөрүүтэй саналаас шалтгаалан дахин тендерийг зарлах, цаашид оролцогч (Унгар) талаас төсөвт өртгийг нэмэгдүүлэх боломжийг судлах талаар саналаа ирүүлээд байна.

### 3) Хугацаандаа хэрэгжээгүй үйл ажиллагаа:

- Мал, амьтны тэжээлийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоог нэвтрүүлэх

**Зорилт 5: Мал, малын гаралтай түүхий эдийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгож, түүний чанараас хамаарсан эдийн засгийн хөшүүрэг бий болгон зорилтот зах зээлийг хөгжүүлэх**

### 2) Хэрэгжих шатандаа явж байгаа үйл ажиллагаа:

- Түүхий эдийн борлуулалтын зах зээл дэх ченжийн тогтолцоог өөрчлөх, түүхий эдийн үнийг тогтворжуулах

Тайлбар: Малчид мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлийн бодит үнээр борлуулах, малчдад зах зээлийн бодит үнийн тухай мэдээллийг хүргэх ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн бирж үйл ажиллагаа явуулж байна. Малчид, хоршоодын биржийн арилжаанд оролцох идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор хоршоо арилжаанд оролцох гарын авлага, мал бэлтгэл болон хүлээлцэх зааварчилга боловсруулан хоршоодод хүргүүлж ажилласан байна. Малын гаралтай түүхий эдийн чанарыг сайжруулах, зах зээлд өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд боловсруулсан ноос, ноолуурын Монгол улсын стандартад өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулж, хүргүүлсэн байна.

- Түүхий эдийн нөөцийн хэмжээтэй уялдуулан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийн байршлыг шинэчлэн тогтоох, одоогийн үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх

Тайлбар: Орон нутагт түүхий эд, тордолтын цэг байгуулах, түүхий эд бэлтгэл, тээвэрлэлт, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх сургалт, судалгааны ажил хийгдсэн. АХБ-ны зээл тусламжаар 56 хоршооны түүхий эдийн агуулахыг бэлтгүүлж, итгэмжлэл олгосон, ШХА-ийн Ногоон алт-малын эрүүл мэнд төслийн хүрээнд Өвөрхангай аймагт 3, Хөвсгөл аймагт 3, Хэнтий аймагт 1, Баян-Өлгий аймагт 3 нийт 10 агуулахыг барьж, ашиглалтад оруулсан, Улсын төсвийн хөрөнгөөр 600.0

сая төгрөгөөр 1200 тн хүнсний ногооны зоорь байгуулах гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулсан.


- Малын шилжилт хөдөлгөөнийг журамлах, хяналтыг сайжруулах  
Тайлбар: “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 7.9-д мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам болон мах бэлтгэл, отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэлийг боловсруулж, батлуулах бэлтгэл ажил хангаж байна.

### 3.1.3 Зарцуулагдсан төсөв

#### Улсын төсвөөс

2010-2018 онд Улсын төсвөөс нийт 500 тэрбум төгрөг төсөвлөж 485.6 тэрбум төгрөг зарцуулсан байна, өөрөөр хэлбэл жилд дунджаар 55.6 тэрбум төгрөг төсөвлөж 54 тэрбум төгрөгийг зарцуулж байна. Төсвийн зарцуулалт жилд дунджаар 7.2 тэрбум төгрөгөөр буюу 36.3%-иар өссөн байна.

**Зураг 4.** “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатыг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн болон зарцуулсан улсын төсөв



Эх сурвалж: ХХААХҮЯ (2018)

Дээрх зургаас харахад тус хөтөлбөрт зарцуулах зардал 2010-2013 онд хурдтай өссөн ч 2013-2016 он хүртэл хугацаанд аажмаар буурч эргээд 2017 онд 91 тэрбум төгрөгт хүрсэн нь хамгийн өндөр зарцуулалтын дүн болж байна.

#### Орон нутгийн төсвөөс

“Монгол мал” үндэсний хөтөлбөрт зарцуулсан орон нутгийн төсвийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.




### Хүснэгт 3. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатыг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн орон нутгийн төсвийн зардал (21 аймаг, нийслэлийн хэмжээнд)

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 оны 9-р сарын байдлаар	Нийт	Дундаж
1	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулсан байдал (Сая.төг)	5,281.8	6,142.3	5,296.5	5,745.9	22,466.5	5,616.6
2	Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд (Сая.төг)	129.4	217.4	331.9	413.9	1,092.6	273.2
3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалтанд зориулан зарцуулсан зардал (Сая.төг)	102.8	463.7	565.3	643.6	1,775.4	443.9
4	Ус, худаг шинээр гаргах, хуучин сэргээн засварлахад зарцуулсан зардал (Сая.төг)	2,079.6	1,942.7	2,567.9	2,952.8	9,543.0	2,385.8
5	Хадлан бэлтгэлтэй холбоотой зардал (Сая.төг)	676.0	1,083.2	931.1	797.1	3,487.4	871.9
6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэлд зарцуулсан зардал (Сая.төг)	267.3	388.6	379.8	433.9	1,469.6	367.4
7	Малчдын эрүүл мэндэд зарцуулсан зардал (Сая.төг)	97.4	154.3	166.5	160.3	578.5	144.6
8	Малчдын боловсролд зарцуулсан зардал (Сая.төг)	100.8	105.5	143.9	199.6	549.8	137.5
9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардал (Сая.төг)	779.6	1,221.3	1,402.1	1,120.6	4,523.6	1,130.9
10	Дэд бүтцийн зардал (Зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт) (Сая.төг)	20.9	1,417.5	16,890.7	30,156.8	48,485.9	12,121.5
11	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулан зарцуулсан зардал (Сая.төг)	459.3	550.9	491.6	397.8	1,899.6	474.9
<b>Нийт (Сая.төг)</b>		<b>9,994.8</b>	<b>13,687.4</b>	<b>29,167.3</b>	<b>43,022.2</b>	<b>95,871.7</b>	<b>23,967.9</b>
<b>Өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувь (%)</b>			<b>37%</b>	<b>113%</b>	<b>48%</b>	-	<b>66%</b>

Эх сурвалж: 21 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ирсэн тоо мэдээ (өмнө нь хэвлэгдэж байгаагүй)

Эндээс харахад орон нутгийн төсвөөс 2016-2019 онд нийт 95.9 тэрбум төгрөг, жилд дунджаар 24 тэрбум төгрөгийг “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II шатны арга хэмжээнд зарцуулсан ба орон нутгийн төсвийн зарцуулалт жилд дунджаар 66%-иар өсч байна. Хавсралт 3-т орон нутгийн төсвөөс “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардлыг аймаг, нийслэл тус бүрээр задлан харуулав.

### Зураг 5. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд зарцуулсан орон нутгийн төсвийн зардлын бүтэц (%)




Эх сурвалж: 21 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ирсэн тоо мэдээ (өмнө нь хэвлэгдэж байгаагүй)-нд үндэслэсэн зохиогчдын тооцоолол

Дээрх зургаас харахад 2016-2019 онд “Монгол мал” үндэсний хөтөлбөрт зарцуулагдсан орон нутгийн нийт төсвийн 50.6%-ийг дэд бүтэц буюу зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт хөрөнгө оруулалтад, 23.4%-ийг малын эрүүл мэнд, 10%-ийг ус, худаг, 4.7%-ийг малчдын амьжиргааг дээшлүүлэхэд, 3.6%-ийг хадлан бэлтгэл, үлдсэн 7.7%-ийг бусад үйл ажиллагаанд зарцуулжээ.

2019 онд “Монгол мал” үндэсний хөтөлбөрт 43 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан нь өмнөх онуудаас хамгийн өндөр байна. Үүний гол шалтгаан нь 30 тэрбум төгрөгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын зардал 2019 онд гарсантай холбоотой.

Тухайлбал, Улаанбаатар хотод 2018, 2019 онд тус бүр 15 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэлийн баруун, зүүн хэсэгт мал, мах боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж байна. Мөн түүнчлэн, 2019 онд Баянхонгор аймгийн ЗДТГ зарим сумдад арьс нэхий боловсруулах, эсгий хийх, мал нядлах зэрэг үйлдвэр, цехүүдийг байгуулах, үйл ажиллагааг нь тогтворжуулахад 1 тэрбум төгрөг төсөвлөн зарцуулсан байна. Мөн Баян-Өлгий аймагт мах боловсруулах үйлдвэрүүд шинээр байгуулж байгаа бөгөөд үүнд 2019 онд 11 тэрбум төгрөгийн зардал гаргаж байна. Сүүлийн 4 жилд тус хөтөлбөрт зарцуулсан төсвийг дараах зурагт үзүүлэв.

**Зураг 6.** “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд зарцуулсан орон нутгийн зардал (Сая төгрөг)



Эх сурвалж: 21 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ирсэн тоо мэдээ (өмнө нь хэвлэгдэж байгаагүй), Зохиогчдын тооцоолол


Зургаас харахад сүүлийн 2 жилд “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд оруулсан нийт санхүүжилтийн 58-70%-ийг дэд бүтцэд зарцуулсан байна. Гэвч дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт нь шууд зөвхөн “Монгол мал” үндэсний хөтөлбөрт зориулан хөрөнгө оруулсан гэж үзэх үндэслэлгүй. Тиймээс яг ямар

төрлийн хөрөнгө оруулалтын зардлыг тус бодлогын үр дүнд оруулж тооцох талаар нарийвчилсан ХШҮ-ний заавар гаргах шаардлагатай.

### Нийт төсөв

2018 онд “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд 92.4 тэрбум төгрөгийг зарцуулсан ба үүнээс 63.2 тэрбум төгрөг нь улсын, 29.2 тэрбум төгрөг нь орон нутгийн төсвөөс санхүүжигдсэн байна. Сүүлийн 3 жилд тус хөтөлбөрт зарцуулсан төсвийг дараах зурагт үзүүлэв.

Зураг 7. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд зарцуулсан зардал



Эх сурвалж: 21 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ирсэн тоо мэдээ (өмнө нь хэвлэгдэж байгаагүй)-нд үндэслэсэн зохиогчдын тооцоолол

2016-2018 оны дунджаар улсын төсвийн санхүүжилт нийт санхүүжилтийн 79%-ийг, харин үлдсэн 21%-ийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

## 3.2 ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

### 3.2.1 Хөтөлбөр хэрэгжүүлснээр гарсан үр дүн (Ерөнхий)

#### Улсын хэмжээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн

Хүснэгт 4. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатанд улсын хэмжээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн

Үндсэн зорилт	Дэд зорилт	Хийсэн ажил	Үр дүн
Зорилт 1	Зорилт 1.1	Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулж, батлуулах	2016-2018 он: Шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль 13, УИХ-ын тогтоол 3, Засгийн газрын тогтоол 10, ХХААХҮ-ийн сайдын 33 тушаал батлуулсан байна.
		Хуулийн төсөл боловсруулж, хэлэлцүүлэх	2016 он: Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн хяналт шалгалтын тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл



		Бусад эрх зүйн баримт бичиг боловсруулж, батлуулах	2016 он: Малын үржлийн ажил, үйлчилгээний стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах ажил 2017 онд болсон. Мал аж ахуйн салбарт шинээр батлагдсан хуульд нийцүүлэн холбогдох журам, заавар, стандарт, стратегийн баримт бичгийн төслийг шинэчлэн боловсруулж батлуулах ажил Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг баталсны дараа хийхээр болсон. Мал, амьтны эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх ажил Шинэ хууль батлагдах хүртэл хойшлогдсон. Малаас хүнд дамжин халдварладаг бруцеллез өвчнийг мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтанд оруулахад шаардлагатай хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэх ажлыг 2017 оноос эхлэн хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.
		Хөтөлбөр боловсруулж, батлуулах	2016 он: Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийг хянах үндэсний хөтөлбөрийг 2017 онд батлуулахаар ажиллаж байна.
		Дэд хөтөлбөр боловсруулах	2017 он: “Малын чанар сайжруулах” дэд хөтөлбөр, “Монгол сарлаг” дэд хөтөлбөр
		Хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ	2018 он: Хуулийг сурталчлах, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажил зэрэг ажилд нийт 6260 хүнийг хамруулж, хураангуйлсан 2 төрлийн шторжийг 21 аймаг, нийслэлийн төрийн байгууллагын цахим хуудас, төвийн болон орон нутгийн нийт 42 телевизийн сувгаар гаргасан. 1 журам, 2 жагсаалт батлагдаж, 1 журам, 2 чиглэлийг батлуулахаар ЗГХЭГ-т, Сайдаар батлуулах 24 эрх зүйн баримт бичгээс 8 журам, 1 жагсаалт батлагдаж, 8 журмыг батлуулахаар оруулж, 4 журам, 3 төлөвлөгөөг боловсруулсан, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргаар батлуулах 87 эрх зүйн баримт бичгээс 2 журам, 3 нийтээр дагах заавар, 1 дүрэм, 1 стандарт, 67 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар, 1 төлөвлөгөө, нийт 75 эрх зүйн баримт бичгийг батлуулсан байна.
Зорилт 1.2	Тусгай дунд мэргэжлийн мал зүйчдэд бакалаврын зэрэг олгох эчнээ сургалтыг зохион байгуулах	2017 он: Тусгай дунд мэргэжлийн мал зүйчдэд бакалаврын зэрэг олгох эчнээ сургалтыг зохион байгуулж, 96 оюутан шинээр элсээд байна. 2018 он: “Мал зүйч бакалаврын боловсрол эзэмшүүлэх” сургалтыг тусгай дунд мэргэжлийн мал зүйчдэд 1,5 жил, мал зүйч болох сонирхолтой бакалаврын боловсролтой суралцагчдад 2,5 жил, бүрэн дунд боловсрол эзэмшсэн суралцагчдад 4-4.5 жилээр сургах чиглэлээр 2017-2018 оны хичээлийн жилд 1.5 жилээр 23, 2.5 жилээр 35, 4-4.5 жилээр 100 оюутан, 2018-2019 оны хичээлийн жилд 1.5 жилээр 21, 2.5 жилээр 13, 4-4.5 жилээр 68 оюутан элсэн суралцаж байна.	
	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааг стандартын шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох	2016 он: Улсын хэмжээнд 1006 нэгжид 779 их, 748 бага эмч, 170 мал зүйч ажиллаж, нэг МЭ-ийн үйлчилгээний нэгжид 61.1 мян, нэг малын эмчид 40.3 мянган мал ногдож байна. Нэгжүүдийн 80.0 хувь нь өөрсдийн ажлын байр, 94 хувь нь дуудлага, үйлчилгээний шаардлага хангасан унаатай байна. 2017 он: Улсын хэмжээнд 988 нэгжид 808 их, 697 бага эмч, 163 мал зүйч ажиллаж, нэг МЭ-ийн үйлчилгээний нэгжид 59.5 мян, нэг малын эмчид 39.2 мянган мал ногдож байна. 2018 он: мал эмнэлгийн үйлчилгээний 1006 нэгжид 829 малын их эмч, 645 малын бага эмч, 131 мал зүйч ажиллаж, нэг мал эмнэлгийн нэгжид 62.5 мянган толгой мал, нэг малын эмчид 41.9 мянган толгой мал ногдож байна. МЭҮН-ийн 82.0 хувь нь стандартын шаардлага хангасан ажлын байртай, 92.0 хувь нь дуудлага, үйлчилгээний шаардлага хангасан унаа хэрэгсэлтэй, “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны MNS5368:2011 стандарт”-ын шаардлагыг онц сайн хангасан нэгж 6.0 хувийг, сайн үнэлгээтэй нэгж 60.0 хувийг, дунд үнэлгээтэй нэгж 19.0 хувийг, шаардлага хангаагүй нэгж 15.0 хувийг тус тус бүрдүүлж байна.	
Зорилт 1.3	Мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах	2016 он: Булган аймгийн Хутаг-Өндөр суман дахь “Гуртын гүүр”-ийн Мал эмнэлгийн хорио цээрийн цэгийг төвийн цахилгаан дамжуулах шугамтай холбох ажлыг гүйцэтгүүлж ашиглалтанд оруулсан байна. Архангай Цахир, Булган Хутаг-Өндөр, Өвөрхангай Нарийнтээл, Төв Лүн сумдад ажиллаж байгаа мал эмнэлгийн хяналтын цэгүүдэд замын автомат хаалт, хурд хязгаарлагч, шалгах цэгийн барилга, хяналтын камер, сурталчилгааны самбар, суурин болон зөөврийн компьютероор хангасан байна.	
	Чадавхжуулах сургалт	2016 он: “Полимеразийн гинжин урвалын арга зүй эзэмшүүлэх” сургалтад орон нутгийн эмч нар, МЭАЦЛ-г ажлын байрны сургалтад 42 малын эмч, оношзүйч нар, “Шинэ болон дахин сэргэж байгаа хил дамжин халдварлах гоц халдварт өвчин” сургалтад 30 хүн тус тус хамрагдсан байна. Удирдлагын академид төрийн удирдлага мэргэжлээр 2 мал зүйч, богино хугацааны Англи хэлний чиглэлээр 4 мэргэжилтэн, Тайланд, Хятад, Япон, ОХУ, Австрали, Солонгос Шинэ Зеланд, зэрэг улсуудад 14-30 хоногийн хугацаатай мал эмнэлэг, мал үржил, шувууны томуу, мал угаалгын чиглэлийн сургалтад 14 мэргэжилтэн, Солонгос улсад 1, Бүгд найрамдах Чех улсад 7 мэргэжилтэн, дотоодын мэргэжлийн байгууллагын сургалтад 2 мэргэжилтэн тус тус хамруулсан байна. 2018 он: нийт 4 удаагийн сургалтаар 3958 хүн хамрагдсан.	
	Мал аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэд технологи нэвтрүүлэх ажлыг сургалт хэлбэрээр	2017 он: “Бог, бод малын ангилагч-шинжээч” бэлтгэх сургалтад 17 аймгийн 82 сумын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж буй 84 мал зүйч мэргэжилтнүүд, Малын удмын сангийн үндэсний төвийн 3 мэргэжилтэнг ХААИС-ийн МААБС-ийн Магистрын ангид, БНСУ-ын Мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарын үнэлгээний институт (КАРЕ) -д “Мал аж ахуйн	



		зохион байгуулсан	гаралтай бүтээгдэхүүний чанарын үнэлгээ ба мөрдөн мөшгих тогтолцоо” сургалтад төвийн албаны дарга болон 1 мэргэжилтэнг, БНЭУ-д “Орчин үеийн сүүний технологи ба менежмент” сургалтад 1 мэргэжилтэнг, БНХАУ-д “Хөгжиж буй улс орнуудад зориулсан өндөр ашиг шимтэй хонь, ямааны үржүүлэг” сургалтад 2 мэргэжилтэнг, БНСУ-ын AFACI-ийн төслийн хүрээнд Бүгд Найрамдах Лаос улсад “Малын генетик нөөцийг сайжруулах ашиг шимийг нэмэгдүүлэх” сургалтад 1 мэргэжилтэнг, “SUGARAAS English club”, “Jet school of English” сургалтын төвүүдийн Англи хэлний сургалтад 4 мэргэжилтэнг, Төрийн албаны зөвлөлд зохион байгуулагдсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ нэгтгэх” сургалтад 1 мэргэжилтэнг тус тус хамруулсан.
		Цахим хуудас ажиллуулах, Мэдээ мэдээллийг боловсруулж, түгээх	2017 он: “Цахим хуудас ажиллуулах журам”-ыг боловсруулан баталгаажуулж, малын үржил, бүртгэл мэдээллийн чиглэлээр байгууллагын вэб сайтад нийт 56 мэдээллийг байршуулсан байна. “Монгол малчин сэтгүүл”-тэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд улирал тутамд малын үржлийн чиглэлээр хийгдэж буй цаг үеийн мэдээ мэдээллийг боловсруулж, хэвлэлтэнд өгч ажилласан байна.
		Стандартын шаардлага хангасан малын зураг авах	2017 он: Стандартын шаардлага хангасан малын зураг авах зорилгоор нийт 5 ажлын хэсэг 17 аймгийн 37 сумдад зураг авалтыг зохион байгуулж баталгаажсан 45 үүлдэр, омгийн малын стандартын шаардлага хангасан 225 ширхэг зураг авах ажлыг зохион байгуулсан.
		Адуу, тэмээ, үхэр, хонь, ямаа ангилах зааврыг орон нутгийн түвшинд ашиглах боломжтой, хялбаршуулсан байдлаар боловсруулж, батлуулсан	2017 он: “Адуу, тэмээ, үхэр, хонь, ямаа ангилах заавар”-ыг орон нутгийн түвшинд ашиглах боломжтой, хялбаршуулсан байдлаар боловсруулж, батлуулсан байна.
		Телевизийн хэлэлцүүлэг, радиогийн нэвтрүүлгээр олон нийтэд мэдээлэл хүргэх	2018 он: 2018 онд телевизийн хэлэлцүүлэг, болон радиогийн нэвтрүүлэгт “Малын генетик нөөцийн тухай” хуулийн хэрэгжилт, мал бүртгэлжүүлэлт, удам зүйн үнэлгээний бүртгэлийн чиглэлээр мэдээлэл хийж, малчид, олон нийтэд мэдээлэл хүргэсэн.
		Монгол улсад үржүүлж буй үржлийн малын үнэт чанарыг үнэлэх, монгол малын үнэ цэнэ, бүтээмжийг нэмэгдүүлэх	2018 он: Үржлийн малын үнэт чанарыг үнэлэх, монгол малын үнэ цэнэ, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор малын удам зүйн үнэлгээний нэгдсэн систем болон muz.gov.mn хаяг бүхий цахим хуудсыг ажиллуулсан
Зорилт 2	Зорилт 2.1	Малын үүлдэр, омог батлах	2016 он: Хэнтий аймгийн “Галшар” омгийн адууг үүлдэрээр, Баянхонгор аймгийн “Бөмбөгөрийн улаан” ямааг омгоор, Ховд аймгийн “Алтай улаан” үүлдрийн хэсгийн ямааг тус бүр үүлдэрээр баталсан. 2017 он: Сүү-ноосны чиглэлийн “Ламын гэгээний улаан” тэмээг үржлийн хэсгээр, ноолуурын чиглэлийн “Эрчим хар” ямаа, мах-өөх-бүдүүвтэр ноосны чиглэлийн “Сутай” хонь, өөх-мах-бүдүүвтэр ноосны чиглэлийн Цагаан-Уул хонийг үүлдэрээр тус тус баталгаажуулав. Үүний дүнд Монгол улсад баталгаажсан үүлдэр, омгийн малын тоо 47 болж өссөн байна. 2018 он: 2018 он: 16 аймгийн 54 сумын 310.5 мянган бог, 64.4 мянган бод малд ангилалтанд хийж, нийт малын 21.4 хувь нь цөм сүрэг, 51.2 хувь нь үржлийн сүрэг, 27.3 хувь нь хэрэгцээний сүрэгт хамрагдаж, ангилалтанд хамрагдсан 6.6 мянган толгой хээлтүүлэгч мал цөм сүргийн шаардлага хангасан байна.
		Малын үзлэг ангилалт	2016 он: 10 аймгийн 22 сумдыг хамруулан 203.0 мянган малд үзлэг ангилалт хийж, нийт малын 27.6 мянган толгой мал шилмэл ангид, 66.2 мянган толгой мал үржлийн нэгдүгээр ангийн шаардлагыг хангасан байна. Улсын хэмжээнд нийт 279 өрх, 6 аж ахуйн нэгжид үржлийн мал бойжуулах эрх олгож, 26.9 мянган толгой хээлтэгчийг үржлийн бүртгэлд авсан байна. 2017 он: 13 аймгийн 45 сумын 286.1 мянган малын анги, чанарыг тогтоосон байна. Ангилалтанд хамрагдсан нийт малын 80.1 хувийг бог, 19.9 хувийг бод мал эзэлж байна. Үзлэг ангилалтын дүнгээр нийт малын 19.3 хувь буюу 55.1 мянга толгой мал нь цөм сүрэг, 52.2 хувь буюу 149.3 мянга толгой мал нь үржлийн сүрэг, 28.5 хувь буюу 81.5 мянган толгой мал нь хэрэгцээний сүрэгт бүртгэгдсэн байна. 2018 он: 16 аймгийн 54 сумын 310.5 мянган бог, 64.4 мянган бод малд ангилалтанд хийж, нийт малын 80.3 мянга буюу 21.4% цөм, 191.9 мянга буюу 51.2% үржлийн, 102.5 мянга буюу 27.3%-ийн хэрэгцээний сүрэгт хамрагдсан байна. Ангилалтанд хамрагдсан 17.8 мянган бог малын хээлтүүлэгчийн 6.6 мянга буюу 37.3% нь цөм сүргийн шаардлага хангасан бөгөөд 2.5 мянган өсвөр хээлтүүлэгч бойжуулж, бойжилтын явцад стандартын шаардлага хангасан 1,5 мянган хээлтүүлэгчийг Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэв.
		Үржил, селекцийн ажлыг хянан	2017 он: 2015-2016 оны хооронд баталгаажсан 12 үүлдэр, омгийн малын үржил, селекцийн ажлын хөтөлбөрийг шинээр боловсруулж батлуулах

		<p>магадлах</p>	<p>зорилгоор 2 омгийн хонь, 2 үүлдрийн ямааны 2018-2028 он хүртэлх үржил селекцийн ажлын хөтөлбөр, 1 үүлдрийн адуу, 3 үүлдрийн тэмээний 2018-2028 он хүртэлх үржил селекцийн ажлын хөтөлбөр, 1 үүлдрийн хонь, 2 үүлдрийн, 1 омгийн ямааны үржлийн ажлын хөтөлбөрийг тус тус хэлэлцүүлэн, батлуулсан байна. 2018 он: Увс аймгийн Өлгий суманд үржүүлж буй ноолуурын чиглэлийн Өлгийн улаан омгийн ямаа, Дорноговь аймгийн Дэлгэрэх суманд үржүүлж буй ноолуурын чиглэлийн нутгийн шилмэл ямааг хянан магадалсан.</p>
		<p>Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр аж ахуй байгуулах</p>	<p>2017 он: Жилийн эцсийн мал тооллогын дүнгээр улсын хэмжээнд 1727 аж ахуйн нэгжид 74.0 мянган толгой сүүний чиглэлийн үхэр, 236 аж ахуйн нэгжид 28.7 мянган толгой махны чиглэлийн үхэр, 1511 аж ахуйн нэгжид 353.1 мянган толгой мах, ноосны хонь, 34 фермд 13.1 мянган толгой гахай, 40 фермд 766.9 мянган толгой тахиа, 31 ферм, 397 өрхийн 11492 бүл зөгий тоологдсон байна. Сүү болон сүү-махны, махны чиглэлийн арвин ашиг шимт үхрийн үржлийн аж ахуй байгуулах төслийн хүрээнд 150 толгой махны чиглэлийн Геррефорд үүлдрийн үхэр, Лимүзэн үүлдрийн 60 толгой үхрийг тус тус импортлон 2 үржлийн аж ахуй байгуулсан байна. Махны болон сүүний чиглэлийн үхэр үржүүлж буй жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 11 аймаг, нийслэлийн ойролцоо, мах болон сүүний үхрийн аж ахуй эрхэлж буй 54 аж ахуйн нэгжид тус бүр 10.0-20.0 сая төгрөгийг жилийн 3.6 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, нийт 800.000.000.0 төгрөгийн зээлийг олгосон байна. Франц улсаас Махны чиглэлийн Суффолк үүлдрийн эм хонь 161, хуц 10, Меринос үүлдрийн эм хонь 205, хуц 10, Беришон душер үүлдрийн эм хонь 190, хуц 10, Романов үүлдрийн эм хонь 65, хуц 6 толгой, нийт 621 толгой үржлийн эм хонь, 36 толгой хуц импортлон үржлийн аж ахуй байгуулсан байна. “Ангус” үүлдрийн 140 толгой үхрээс ХХААХҮ-ийн сайдын А-146 тушаалаар хээлтүүлэгчийг аймгуудад, нэхэлтэгийг ААН, иргэдэд эргэж төлөгдөх хөдөлгөөр гэрээ байгуулан олгосон байна. МХС-ИЙН агуулахад байсан 22.7 сая төгрөгийн үнэ бүхий “Хүчит тэжээлийн цех”-ийг 1 аж ахуйн нэгжид түрээсээр, 5 ширхэг хаман боогчийг Дархан-Уул, Улаанбаатар, Хэнтий аймагт тус бүр 1, МУСҮТ-д 2 ширхгийг лизингээр олгосон. МХС-д байсан 53.3 сая төгрөгийн үнэ бүхий хадлангийн иж бүрдэл техникийг Завхан аймгийн Улиастай сумын ЭМАА эрхлэгч иргэнд 7 жилийн хугацаатай түрээсээр, Таримал тэжээл тариалах, тэжээлийн нөөц бий болгох төсийн хүрээнд 3 аж ахуйн нэгжид 300,0 сая төгрөгийн зээл олгосон байна. Мах болон сүүний чиглэлийн үхэр үржүүлж буй аж ахуйн нэгжүүдэд зээлийн дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд 44 аж ахуйн нэгжид 655.0 сая төгрөгийн зээлийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр, 60 эх зөгий, үүр хайрцгийн хамт 4 иргэн аж ахуйн нэгжид эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон байна. 2016 оны ноосны урамшуулал олгох ажлыг 2017 оны 2 дугаар сард зохион байгуулж, нийт 92.8 мянган малчинд 22.6 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон. Мөн 2017 оны ноосны урамшуулалд нийт 21 аймаг, нийслэлээс ирүүлсэн 87.0 мянган анхан шатны баримтаар 19.0 мянган тонн ноосны мэдээллийг хүлээн авч, хянан магадлаж, 86464 мянган малчны 20.1 мянган тн ноосонд 22.4 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна. 2016 оны арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгох мөнгөн урамшуулалд нийт 21 аймаг, нийслэлийн 64.2 мянган малчны бодын 178.2 мянган ширхэг ширэнд, богийн 2 846.7 мянган ширхэг арьсанд 11.4 тэрбум төгрөг урамшуулал олгосон байна.</p> <p>2018 он: Улсын төсвийн санхүүжилтээр Булган аймагт цэвэр үүлдрийн өндөр ашиг шимт бух, хуц, ухна, гүн хөлдөөсөн үр, зохиомол хээлтүүлгийн багаж тоног төхөөрөмж нийлүүлэх” тендерт зарлаж, “Геррефорд” үүлдрийн үржлийн өсвөр бух 25, Сэлэнгэ үүлдрийн үржлийн бух 100, Баяд үүлдрийн үржлийн өсвөр хуц 160, Дархад үүлдрийн үржлийн өсвөр хуц 200, Эрчмийн хар үүлдрийн үржлийн өсвөр ухна 180 толгой, Геррефорд үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үр 6000 ширхэг, зохиомол хээлтүүлгийн 4 иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна. Энэ ажил бэлчээрийн маллагаатай үхэр, хонийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 665 малчин болон аж ахуйн нэгжийн малд сайжруулагчаар ашиглах болсон.</p>
		<p>Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх</p>	<p>2017 он: “Хөдөө аж ахуйн маркетинг” төслийн хүрээнд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгуудын 5 суманд бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлсэн загвар аж ахуй нэгжийг бий болгох, дэмжих чиглэлээр нийт 32 аж ахуй нэгжүүдийг мэргэжил аргазүйн удирдлагаар ханган ажиллаж холбогдох үнэлгээг өгөв. Бог малын хээлтүүлэгч ялган төвлөрүүлсэн Архангай аймгийн Цахир сумын “Цахир тарам” ҮҮН, Баянхонгор аймгийн Баянцагаан сумын “Баяндэлгэрэх хайрхан” ХХК, Говь-Алтай аймгийн Цогт сумын “Есөн улаан булаг” ХХК, Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын “Бэлчир тээл” хоршоо, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Мал зүйч үржүүлэгчдийн холбоог цаашид загвар аж ахуй болгох боломжтой болсон байна.</p> <p>2018 он: “Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх тухай” гарын авлага, танилцуулга бэлтгэн орон нутгийн мэргэжлийн байгууллагад хүргүүлж, телевизтэй хамтран дэлгэрэнгүй танилцуулга мэдээлэл хийж, 2-3 удаагийн давтамжтай малчдад хүргүүлж ажилласан 7 аймгийн 8 хувийн нэгжид 185.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн байна.</p>

Зорилт 2.2		Хэнтий аймгийн Биндэр, Дундговь аймгийн Хулд суманд загвар аж ахуй нэгж байгуулж, сумын ИТХ, Засаг даргын тамгын газар, аймгийн ХХААГ-тай хамтран багийн ИНХ-ыг зохион байгуулж, Хулд суманд 85 өрхийн 420, Биндэр суманд 95 өрхийн 410 хуц, ухныг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлж, мэргэжилтний хяналтад авав.
	Аж ахуйн нэгжүүдийн маркетинг, техникийн чадавхыг дээшлүүлж, бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэх	2018 он: Малын чанарыг сайжруулах, фермийн байр засах, тэжээлийн нөөц бүрдүүлэх болон тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд нь зориулж сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 27 аж ахуйн нэгжид нийт 509 сая төгрөгийн зээлийг олгосон. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ТА-8960: MON “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төсөл хэрэгжсэн.
	Онол үйлдвэрлэлийн бага хурал зохион байгуулав	2018 он: “Мал аж ахуйн үйлдвэрлэлийг механикжуулах цахилгаанжуулах. Хөдөлмөрийг хөнгөвчлөх” сэдвээр онол үйлдвэрлэлийн бага хурал зохион байгуулсан байна.
	Малын удмын сангийн үндэсний цогцолборын эхний ээлжийг ашиглалтанд оруулах, малын генийн санг хамгаалах, баяжуулах, үр, хөврөл үрийг үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах	2016 он: “Малын удмын сангийн үндэсний цогцолбор”-ын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 98.0 хувьтай байсан. Инженерийн шугам сүлжээний ажил болон 14 барилгын угсралтын ажил бүрэн дууссан. Малын удмын сангийн үндэсний төвийн стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан. 2017 он: Хэнтий аймаг дахь Цөм сүргийн салбар нэгжийн Тал нутгийн цагаан үүлдрийн үржлийн чанарыг сайжруулах зорилгоор тус үүлдрийн 5 донор эм хонь, 2 хуцыг ашиглан 35 тээгч хонийг сонгож, 13 тээгчид хөврөл шилжүүлэн суулгах ажлыг амжилттай зохион байгуулсан.
	Хөврөл үрийг шилжүүлэн суулгах технологийн сургалт	2017 он: БНХАУ-ын Өмнөд, өмнөдийн хамтын ажиллагааны GCP/MON/010/CPR/ төслийн хүрээнд “Бог малд хөврөл шилжүүлэн суулгах технологи”-ийн сургалтыг 7 аймаг, нийслэлийн 22 мэргэжилтэнг хамруулан зохион байгуулсан байна. “Малын удмын сангийн үндэсний цогцолбор”-ын эхний ээлжийн 18 барилга, байгууламжийг улсын комисс хүлээн авсан. Дорнод аймгийн салбар нэгжид үржүүлж буй Барга үүлдрийн хуцнаас үр үйлдвэрлэх, Хэнтий аймаг дахь салбар нэгжийн Тал нутгийн цагаан үүлдрийн хонины аж ахуйд “Хөврөл үрийг шилжүүлэн суулгах технологийн сургалт”-ыг зохион байгуулсан байна.
	Цөм сүргийн аж ахуйг Чадавхжуулах	2016 он: Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгууд дахь цөм сүргийн үржлийн төвүүдэд 16 үүлдрийн 12.8 мянган толгой малтай болсон байна. Төвийн харьяа Хөвсгөл, Говь-Алтай, Хэнтий болон Булган аймгууд дахь Цөм сүргийн үржлийн төвүүдэд иж бүрэн компьютер болон малын ангилалтын багаж хэрэгсэл, 6 малын өвөлжөө, хашааг шинээр барьж байгуулав. 2017 он: Жилийн эцсийн байдлаар цөм сүргийн хэмжээнд 4095 толгой төл хүлээн авч, 16 үүлдрийн нийт 12.8 мянган толгой мал тоологдсон нь 2016 оны жилийн эцсийн тоотой харьцуулахад 4.8 хувиар өссөн дүнтэй байна. Цөм сүргийн аж ахуйг Чадавхжуулах ажлын хүрээнд НҮБ-ын ХХААБ-ын “Ган, зуд хавсарсан хүндрэлд яаралтай тусламж үзүүлэх, даван туулах чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд нийт 29.1 сая төгрөгийн өртөг бүхий бага оврын трактор, хадлангийн агрегат чиргүүлийн хамт, өвс хаман боогч, гар хадуур, жижиг усалгааны систем зэргийг нийлүүлсэн байна. 2018 он: Шинээр байгуулагдсан цогцолборт шаардлагатай шилмэл өндөр ашиг шимт Каракуль, Алтай, Цигай, Сараджин, Гиссар, Грузин, Дон, Ангор үүлдрийн 30 толгой бог малын шилмэл хээлтүүлэгч, сүү-махны чиглэлийн дэлхийг бүхэн үнэлгээгээр үнэлэгдсэн 13 толгой бухыг худалдан авсан.
Орон нутаг дахь Цөм сүргийн салбар нэгжүүдийн менежментийг боловсронгуй болгож, цөм сүргийн малын тоо толгойг өсгөж, үржлийн чанарыг сайжруулах	2018 он: Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх болон малын үржүүлэг, технологийн ажил”-ын хүрээнд өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн 4 үүлдрийн бухын 1244 тун гүн хөлдөөсөн үр, 110 литр азотыг захиалгын дагуу малчдад нийлүүлжээ. Өнгөрсөн онд бод, бог малын 17839 тун үр үйлдвэрлэсэн бол 2018 онд 28000 тун үр үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээ бүрэн хангаж, экспортлох зорилт тавин ажиллаж байна. Орон нутгийн 11 аймгийн дахь цөм сүргийн аж ахуй тус бүрээр малын чанар сайжруулах үржлийн бичил хөтөлбөрүүдийг боловсруулан Булган, Хэнтий, Баянхонгор, Говь-Алтай зэрэг аймгуудад үржлийн хуц худалдан авч үржилд ашиглан мөн Зохиомол хээлтүүлгийн аргаар жилд тодорхой хэмжээний хонийг сайжруулан суурь зохион байгуулалтыг оновчтой хийж байна. Хэнтий аймгийн цөм сүргийн үржлийн төв нь Өндөрхаан үржил хоршоотой хамтран эзэмшил газар Шүтээний худгийг түшиглэн малд ариутгал халдваргүйжилтийн үйлчилгээ явуулах 2500000 төгрөгийн үнэ бүхий мал угаалгын ванныг Мах ноосны хонины ашиг шимийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийн хүрээнд байгууллаа. Хэнтий аймгийн цөм сүргийн салбар нэгжид орон нутгийн санхүүжилтээр нарийвтар ноост Орхон үүлдрийн 6 хуц, 10 эм хонь Сэлэнгэ аймгийн Орхон сумаас худалдан авч нарийвтар ноост Тал нутгийн цагаан үүлдрийн хонийг сайжруулах ажлыг хийж байна. Мөн Булган аймгийн цөм сүргийн аж ахуйд орон нутгийн зүгээс нарийн ноост Хангай үүлдрийн хонины дулаан байр барих болон нутаг шилжүүлэн байршуулах зардлын санхүүжилтийг шийдвэрлэж өгсний дүнд тоо толгойг өсгөх боломж бүрдээд байна. Мөн Хангай үүлдрийн хээлтүүлэгчийг Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумаас үржлийн шилмэл хуц авч хээлтүүлэгт ашиглан Хангай хонийг сайжруулах ажлыг хийж байна. Мөн Баянхонгор аймгийн Цөм	



		сүргийн салбар нэгжид үржүүлж буй Байдраг үүлдрийн хонины ашиг шим, тоо толгой нэмэгдүүлэх зорилгоор тус аймгийн Жаргалант суманд үржүүлж буй үржлийн цөм сүргээс хээлтүүлэгч шилэн сонголт хийн авч үржилд ашиглаж байна. Мөн Сүхбаатар аймгийн цөм сүрэгт ХХААХҮЯ-ны Мал Хамгаалах сангаас 350 толгой эм хонь, 150 толгой хуцыг сүрэх сэлбэх зорилгоор балансаас баланс руу шилжүүлэн Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд дахь Бага-Өлгий ХХК –аас хүлээн авч цөм сүргийн малд нийлүүлэн цөм сүргийн аж ахуйг зохион байгуулалт болон эдийн засгийн хувьд бэхжүүлээ.
	Дотооддоо үр үйлдвэрлэх, импортоор үр авах	2016 он: Цөм сүргийн аж ахуйн нарийн, нарийвтар ноост болон арьсны чиглэлийн хуцнаас нийт 2.2 мянган тун үр үйлдвэрлэсэн байна. Мөн импортоор Симменталь үүлдрийн бухны 2000 тун үр авч, генийн санг баяжуулсан байна. Дотоодын үр үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 3.6 дахин буурсан байна. 2017 он: Дотооддоо үр үйлдвэрлэх чиглэлээр 2017 онд Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд цэврээр үржүүлж байгаа Герефорд үүлдрийн 11 шилмэл бухнаас 13.6 мянган тун үрийг үйлдвэрлэсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 3.0 дахин өндөр байсан байна. Мөн Дорнод аймгийн салбар нэгжид үржүүлж буй Барга үүлдрийн 9 толгой шилмэл хуцнаас нийт 4144 тун үрийг авч, генийн санд хадгалсан байна. 2018 он: Малын нөхөн үржихүйн биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэн Бүрэн хүчин чадалтай лабораторийг тохижуулан, малын генийн санг баяжуулж дотоодод үйлдвэрлэх гойд ашигт шимт малын гүн хөлдөөсөн үрийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Алатау 3000 тун, Ангус улаан 3000 тун, Сэлэнгэ 2000 тун, Герефорд 9000, Байдраг 2000 тун, Орхон 2000, Ерөө 1000 тун, Сүмбэр 2000 тун, Торгууд 1000 тун, Дархад 1000 тун, Алтанбулаг 1000 тун, Өнжүүл 1000 тун, Эрчмийн хар 1000 тун, Баяндэлгэр 1000 тун нийт 30000 тун үр үйлдвэрлэлийг эхлүүлэв.
	Зохиомол хээлтүүлгийн ажил зохион байгуулах	2016 он: Монгол улсад үхрийн зохиомол хээлтүүлгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд төвийн бүсийн орчмын 10 хээлтүүлгийн суурин цэг, 60 үржүүлгийн техникч нарыг шаардлагатай багаж, төхөөрөмжөөр ханган орон нутгийн зохиомол хээлтүүлгийн салбаруудын чадавхыг сайжруулах арга хэмжээ авсан. Мөн 2385 толгой үнээ, 2521 толгой эм хонь, 96 толгой эм ямаа, нийт 5002 толгой малд зохиомол хээлтүүлгийн ажил зохион байгуулсан байна. 2017 он: 19 аймаг, нийслэлийн 2100 толгой үнээг, 933 толгой хээлтэгч бог малыг зохиомлоор хээлтүүлсэн ба зохиомлоор хээлтүүлсэн 1900 үнээнд хээлийн шалгалт хийхэд хээл авалтын хувь 74.8 байсан нь зохиомол хээлтүүлэг амжилттай байгааг харуулж байна. Булган аймаг дахь Цөм сүргийн салбар нэгжийн Хангай үүлдрийн хонины үржлийн чанарыг сайжруулах зорилгоор Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумаас Хангай үүлдрийн хуцыг авч, хээлтүүлэгт ашиглахын зэрэгцээгээр генийн санд хадгалагдаж байгаа Хангай үүлдрийн хуцны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн байна.
	Үрийг генийн санд хадгалах	2016 он: Малын удмын сангийн үндэсний төвийн генийн санд үхрийн 39.5 мянган тун, хонины 24.3 мянган тун, ямааны 1.7 мянган тун, нийт 65.5 мянган тун үрийг тус тус стандартын дагуу хадгалж байна. 2017 он: Генийн сангийн үрийн тооллогыг хийж, тооллогын эцсийн дүнгээр 4 үүлдрийн ямааны 1793 тун, 16 үүлдрийн хонины 25878 тун, 8 үүлдрийн бухын 37086 тун, нийт 64757 тун үрийн чанарын үнэлгээгээр зохиомол хээлтүүлэгт ашиглах боломжгүй 7.0 мянган тун үрийг актлах тухай дүгнэлтийг мэргэжлийн хяналтын байгууллагаар гаргуулсан байна. 2018 он: Орон нутагт байрлах 11 аймгийн цөм сүргийн үржлийн төвөөс Дархад, Үзэмчин, Торгууд, үүлдрийн хуц, Баян дэлгэрийн улаан, Эрчмийн хар, үүлдрийн ухна нийт 8 тоо толгой шилмэл хээлтүүлэгчийг үржлийн үнэт чанараар нь шилэн сонгож, цогцолбор дээр татан байршуулан үр үйлдвэрлэх бэлтгэл ажлыг бүрэн ханган нэмэлт тэжээлд оруулан үр үйлдвэрлэн генийн санд нийт 1286 тун үрээр баяжилт хийсэн.
	Мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, генийн санг арвижуулах	2017 он: Тоо толгой нь цөөрч, устах аюулд орж болзошгүй нарийн ноост Хангай, нарийвтар ноост Орхон, Ерөө, Тал нутгийн цагаан үүлдрийн хонь, бүдүүн ноост Байдраг үүлдэр, бүдүүвтэр ноост Хотонт үржлийн хэсгийн хонь болон Дорнод талын махны хэвшлийн үхрийн удмын санг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор 4.1 мянган тун үрийг генийн санд хадгалсан байна.
	Орон нутгийн зохиомол хээлтүүлгийн салбаруудын чадавхыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах	2017 он: Зохиомол хээлтүүлгийн ажлыг эрчимжүүлэх аяны хүрээнд МУСҮТөвд хадгалагдаж буй импортоор орж ирсэн үр, чанарт үнэлгээ хийсэн ба үнэлгээгээр хөдөлгөөний идэвхи муутай 2.0-оос доош балын үнэлгээтэй 4 үүлдрийн бухын 3.1 мянган тун, 5 үүлдрийн хуцны 3.1 мянган тун, 2 үүлдрийн ухны 758 тун үрийг акталсан байна.
	Мал хээлтүүлгийн ажил, үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2018 он: Малын удмын сангийн үндэсний цогцолборт 2018.09.10-20-ны өдрүүдэд зохион байгуулсан "Бог малын үржүүлгийн техникч" бэлтгэх сургалтад 9 аймгийн 25 хүн хамрагдсан.



		<p>чиглэлээр сургалт явуулах, мэдээллээр хангах</p>	
	<p>Зорилт 2.3</p>	<p>Малын ээмэгжүүлэлтийн ажил зохион байгуулах</p>	<p>2016 он: Өссөн дүнгээр нийт 8.5 сая малыг ээмэгжүүлсэн, нийт малын тоотой харьцуулахад 14.5 хувь нь бүртгэлжүүлэлтэд хамрагдсан байна. 11 аймагт нийт 41376 ширхэг ээмэгний захиалгыг хүлээн авч, малыг ээмэгжүүлэх, бүртгэлд авах, мэдээллийн санд мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулж, үхрийн 642, хонины 23880, ямаа 15854, тэмээ 1000 ширхэг ээмгийг захиалагчдад хүргүүлсэн байна.</p>
<p>Малыг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх</p>		<p>2016 он: Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 21 аймаг, нийслэлийн нийт 339 сум, дүүргийн 90.0 мянга малчин өрх, мал бүхий 9.9 мянган өрхийн нийт 2693.9 мянган мал орсон нь өнгөрсөн онтой харьцуулахад малын тоо 312.6 мянга, малчин өрх, мал бүхий иргэний тоо 5.1 мянгаар тус тус нэмэгдсэн байна. Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 156 мэдээг нэгтгэж, мэдээллийн санг шинэчилсэн байна.</p> <p>2017 он: Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 21 аймаг, нийслэлийн нийт 339 сум, дүүргийн 90.0 мянга малчин өрх, мал бүхий 9.9 мянган өрхийн 1205.6 мянган толгой үхэр, 1007.2 мянган толгой хонь, 604.2 мянган толгой ямаа, 3.6 мянган толгой тэмээ, 1.1 мянган толгой адуу бүртгэлтэй байна. Өмнөх оноос 136.6 мянган толгой малаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Шинээр 1.2 сая толгой үхэр, 1.0 сая толгой хонь, 604.1 мянган толгой ямааг ялган тэмдэгжүүлэх, мөн 14 аймгийн 7.9 мянган толгой бод малын, 33.8 мянган толгой бог малын ээмэгний код олгож, малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулсан байна.</p> <p>2018 он: Баталгаажсан үүлдэр, омгийн малыг ялган тэмдэглэх, нэгдсэн санд оруулах ажлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, ноолуурын чиглэлийн Галшарын улаан омгийн ямааны 23.3 мянга, Өлгий улаан омгийн ямааны 20.6 мянга, Дорноговь аймгийн Дэлгэрэх суманд үржүүлж буй нутгийн шилмэл ямааны 23.0 мянга, нийт 66.9 мянган цөм сүргийн ямааг ялган тэмдэглэж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Мөн төрийн өмчтэй 11 цөм сүргийн аж ахуйд үржүүлж буй 14.1 мянган малыг ээмэглэж мэдээллийн санд бүртгээд байна. Улсын төсвийн хөрөнгөөр үзлэг ангилалт хийсэн 16 аймгийн 25 суманд бог малын 15.9 мянга, бод малын 3.6 мянга, нийт 32.2 мянган ээмэгний бар кодыг олгосны дагуу бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулсан. Малын үржүүлэг технологийн календарьчилсан төлөвлөгөөний дагуу бог малын хээлтүүлэгчийн 90%, бод малын хээлтүүлэгчийн 30%, баталгаажсан үүлдэр, омгийн малын 80 хувь, цөм болон үржлийн сүргийн шаардлага хангасан 90.1 мянган малыг тус тус ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг гүйцэтгээд байна.</p>	
<p>Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг сайжруулах, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах</p>		<p>2018 он: Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг сайжруулах, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах хүрээнд Үндэсний статистикийн хорооны удирдлага, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулав. Уулзалтаар малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг сайжруулах "Малчин өрхийн мэдээллийн сан"-д тулгалт хийх, дэд сан бүрдүүлэх ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэв.</p>	
<p>"Сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийн сан"-г бүрдүүлэх</p>		<p>2016 он: Мэдээллийн санд манай улсын эрчимжсэн сүүний үхрийн аж ахуй эрхлэх бүс нутгийн 382 саалийн аж ахуй эрхлэгчдийн 11348 үнээ, гунж бүртгэгдэж, сар бүр үржлийн болон ашиг шимийн бүртгэлийг гүйцэтгэж байна. Монгол улсын сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр 110-140 аж ахуйн нэгж, иргэдийн 1000-1500 үнээний бүртгэлийг сар бүр мэдээллийн санд оруулж мэдээллийн санг баяжуулж байна. Энэ онд 2 аж ахуйн нэгж, иргэний 255 толгой үнээг шинээр бүртгэж, мэдээллийн санд баяжилт хийсэн байна. Бүртгэлийн мэдээллийн системд хамрагдсан 11.0 мянган толгой үнээний хоногийн дундаж саам 9.53 кг, тослогийн хэмжээ 3.68 хувь, уураг 3.31 хувь байна.</p> <p>2017 он: сар бүр 100-130 аж ахуйн нэгж, иргэдийн 1000-1500 үнээний бүрэн бүртгэлийг мэдээллийн санд оруулж, нийт 41600 тоон мэдээллээр баяжуулж, шинээр 16 аж ахуй нэгж, иргэний 950 толгой сүүний үхрийг бүртгэлд хамруулсан байна. Сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийн сан"-гийн үйл ажиллагааг тогтмолжуулан энэхүү бүртгэл, мэдээллийн санд төвийн бүсийн аймаг, Улаанбаатар хотын 396 сүүний чиглэлийн үхрийн аж ахуйн 12.2 мянган толгой үнээг хамруулан бүртгэл, мэдээлэлд тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй селекци явуулснаар сүүний үхрийн ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэх, удам зүйн дэвшлийг богино хугацаанд түгээх ажилд ахиц өөрчлөлт гарч байна.</p> <p>2018 он: 2018 оны 2 улирлын байдлаар сард дунджаар 150-180 аж ахуй нэгж, иргэдийн 1500-2000 тоо толгой үнээний бүрэн бүртгэлийг сар бүр мэдээллийн санд оруулж, мэдээллийн санг нийт 11546 тоон мэдээллээр баяжуулж, шинээр 36 аж ахуй нэгж, иргэний 505 толгой сүүний үхрийг бүртгэлд хамруулан аж ахуй нэгж, иргэдийг эргэх тайлан мэдээгээр тогтмол хангаж байна. Монгол улсын сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд 13 мал үржүүлгийн тоо бүртгэгчтэй гэрээ байгуулан, тоо бүртгэгчдэд анхан шатны зөвлөгөө,</p>	



			<p>мэдээлэл өгч, бүртгэлийн ажлыг явуулж байна.</p> <p>2017 он: “Сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийн сан”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор 2017 онд 15 үржлийн тоо бүртгэгч нарт бүртгэлийн үйл ажиллагааг явуулсан урамшуулалд 17.8 сая төгрөгийг төсвөөс санхүүжүүлсэн байна.</p> <p>2018 он: “Сүүний үхрийн удам гарваль ашиг шимийн бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг зохион байгуулж үхрийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, нэмэгдүүлэх, өргөжүүлэх зорилгоор “Сүүний үхрийн гарваль, ашиг ашиг шимийн бүртгэл мэдээллийн сан”-д эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн 9 ферм, 293 тугал, 10,321 сүүний гарц, 10,321 сүүний бүрэлдэхүүний гурван үндсэн үзүүлэлт, 1,331 үхрийн амьдын жингийн бүртгэл, мэдээллийг нэмсэн буюу 2018 онд мэдээллийн санг нийт дүнгээр 10321 тоон мэдээллээр баяжуулав</p>
		Малын бүртгэл мэдээллийн системийн техник хэрэгсэл, сүлжээг сайжруулах	2016 он: 151 бүртгэл хариуцсан мэргэжилтнүүдийн компьютерийн мэдээллийн санг сэргээж, бүртгэлийн програм хангамжийг сэргээн засварласан байна. Мөн “Касперски” антивирусын програмыг 21 аймаг, нийслэлийн 339 сум, дүүргийн МЭҮТ-ийн малын бүртгэл, мэдээллийн компьютерт суулгаж мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангав.
		Малын бүртгэл мэдээллийн чиглэлийн сургалт хийх	2016 он: Архангай, Өвөрхангай, Хэнтий, Дундговь, Сүхбаатар, Говьсүмбэр аймгуудад малын бүртгэл, мэдээллийн программ хангамжийн сургалтыг зохион байгуулж, 91 мэргэжилтэнг хамруулсан байна.
		Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний загвар бий болгох	2018 он: Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний загвар бий болгох ажлыг “Малын бүртгэлийн систем”-ээр дамжуулан хэрэгжүүлэх ажлыг E-март худалдааны төвтэй хамтран туршилтын байдлаар зохион байгуулав
Зорилт 3	Зорилт 3.1	Үхрийн цээж болон шүлхий өвчнөөр тайван орны статус авах баримт бичиг” боловсруулах	2016 он: “Үхрийн цээж болон шүлхий өвчнөөр тайван орны статус авах баримт бичиг” боловсруулах, батлуулах чиглэлээр ДМАЭМБ-д хандаагүй байна.
		“Шүлхий өвчнийг хяналтанд авах хөтөлбөр”- ийг батлуулах	2016 он: Монгол Улсын “Шүлхий өвчнийг хяналтанд авах хөтөлбөр”- ийг боловсруулж, ДМАЭМБ-аар батлуулж, батламж гэрчилгээ авсан.
		Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	2016 он: Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 124079.7 литр шингэн, 23.291 мянган тун хатаасан вакцин, 7 нэрийн өвчнийг илрүүлэхэд шаардагдах 22 төрлийн 55.9 литр шингэн, 36.5 мянган тун хатаасан оношлуурыг үйлдвэрлэсэн байна.
		Халдварт өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга	2017 он: Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалт бүхий 20 нэр төрлийн 124079 литр шингэн, 23.3 сая тун хатаасан вакцин, 7 нэрийн өвчнийг илрүүлэхэд шаардлагатай 22 нэрийн оношлуур худалдан авах, тэдгээрийг орон нутагт хүргэх ажлын хүрээнд 5.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.
		Халдварт өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга	2016 он: Давхардсан тоогоор 598 суманд 1299 удаагийн гаралтаар 19 нэрийн халдварт өвчнөөр 17419 мал өвчилсний 3414 мал хорогдсон байна. Халдварт өвчний гаралт, өвчлөлийг өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл 2015 оноос давхардсан тоогоор 262 сумаар, гаралт 566-аар, хорогдол 18-аар тус тус буурсан байна.
		Гоц халдварт өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга	2017 он: Улсын хэмжээнд 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22 аймаг, нийслэлийн хэмжээнд давхардсан тоогоор 540 суманд 1140 удаагийн гаралт бүртгэгдэж, нийт 20 төрлийн халдварт өвчнөөр 9984 мал өвчилсөн ба үүний 26.4 хувь нь буюу 2638 толгой мал хорогдсон байна.
		Гоц халдварт өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга	2018 он: Улсын хэмжээнд давхардсан тоогоор 579 суманд 1025 удаагийн гаралт бүртгэгдэж нийт 20 төрлийн халдварт өвчнөөр 8,740 мал өвчилсний 26.6 хувь буюу 2,325 мал хорогдсон байна. Халдварт өвчний гаралт, өвчлөлийг өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл сум 38, гаралт 117, өвчилсөн малын тоо 1258, хорогдол 318 тохиолдлоор тус тус буурсан байна.
		Гоц халдварт өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга	2016 он: Хонины цэцэг өвчний хувьд 24398 толгой мал өвчилж, 220 мал хорогдож, нийтдээ 15185 толгой малыг зориуд устгалд хамруулсан байна. Нийт 6.2 сая тун вакциныг 14 цувралаар үйлдвэрлэж, хэрэглээнд нийлүүлсэн.
		Гоц халдварт өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга	Хонины цэцэг өвчний вакцинжуулалтад нийт 11 аймаг, нийслэлийн 145 сум, дүүргийн 16,879 малчин өрхийн 6.6 сая толгой хонь хамрагдсан. Шүлхий өвчний хувьд Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд шүлхий өвчин бүртгэгдэн 173 толгой үхэр өвчилж, 20 толгой үхрийг зориудын устгалд хамруулсан, Улсын хэмжээнд 10 аймгийн (давхардсан тоогоор) 161 сумын 42432 өрхийн 4691 толгой тэмээ, 18467 мянган толгой үхэр, 4566 мянган хонь, 3561.5 мянган толгой ямаа, 314 гахай вакцинжуулалтад хамрагдсан. Бог малын мялзан өвчний хувьд Ховд аймгийн нийт 11 сумын 126 голомтод 1081 өрхийн 83906 толгой бог мал өвчилж, 12796 толгой бог мал хорогдсон, бог малын мялзан өвчний зайлшгүй вакцинжуулалтад 5 аймгийн 70 сумын 23959 малчин өрхийн 4.6 сая толгой хонь, 5.8 сая толгой ямаа хамруулсан. Ямааны цэцэг өвчний хувьд Ховд аймгийн Ховд суманд ямааны цэцэг өвчин нэг голомтод нэг өрхийн 249 толгой ямааг зориудаар устгасан, 7 толгой



			<p>ямаа хорогдсон, харин 532 толгой ямааг вакцинжуулалтад хамруулсан байна. Монгол улсад шүлхий өвчний нэг, хонины цэцэг өвчний 41, бог малын мялзангийн 11, ямааны цэцэг өвчний нэг удаагийн тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.</p> <p>2017 он: Шүлхий өвчин 9 аймгийн 44 суманд бүртгэгдсэн ба нийт 10195 толгой мал өвчилсөн ба зориудаар устгалд 9683 толгой малыг хамруулсан байна. Шүлхийн вакцинжуулалтад давхардсан тоогоор 20 аймгийн 188 сумын 60916 малчин өрхийн 14.1 сая толгой малыг хамруулсан байна. Хонины цэцэг өвчин 9 аймгийн 31 суманд 37 голомт шинээр бүртгэгдэж, 5782 толгой мал өвчилснөөс 4670 толгой малыг зориудын устгалд хамруулсан байна. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 15 аймгийн 179 сумын давхардсан тоогоор 84921.0 малчин өрхийн 24.3 сая толгой хонийг хамруулсан байна. Бог малын мялзан өвчин зэрлэг амьтанд 11, гэрийн тэжээвэр малд 4 удаагийн тохиолдол оношлогдсон. Өнгөрсөн онтой харьцуулбал зэрлэг амьтны өвчлөлийн тоо нэмэгдэж, гэрийн тэжээвэр мал, амьтдын өвчлөлийн тоо буурсан байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2017 онд 15.2 сая толгой мал хамрагдсан ба 2.2 тэрбум төгрөгийн үйлчилгээний хөлс олгогдсон байна.</p> <p>2018 он: Гоц халдварт шүлхий, хонь, ямааны цэцэг, бог малын мялзан өвчний гаралт эпидемиологийн 1-р сард 9 тохиолдол, 2-р сард 19 тохиолдол шинээр тус тус бүртгэгдэж байсан бол 3-р сард 9, 4-р сард 2, 5-р сард тус бүр 1, 6-р сард 7, 7-р сард 7, 8-р сард 5 тохиолдол бүртгэгдэж бууралт, өсөлттэй гарсаар 2018 оны 09-р сард сүүлийн тохиолдол бүртгэгдсэн байна.</p> <p>2016 он: Шүлхий өвчин, бог малын мялзан өвчний тандан судалгаа, бруцеллэзын вакцинжуулалтын дараах тандалт, малын хээл хаялтад нөлөөлдөг өвчний шинжилгээ, гахайд голлон тохиолддог 10 өвчний тандалт судалгаа, шувууны томуу өвчнийг оношлох, тандах, цусны ийлдсийг ялган бүртгэлжүүлэх ажлыг УМЭАЦТЛ болон бусад байгууллага хамтран зохион байгуулав.</p> <p>2017 он: УМЭАЦТЛ төв орон нутгийн мал эмнэлгийн лаборатори хамтран шүлхий өвчний тандалт шинжилгээнд 17 аймгийн 65 сумыг хамруулан 10950 дээж хамруулсан байна. Бог малын мялзан өвчин Баруун бүсийн бог малд өвчний вакцин тарьсантай холбогдуулан вакцинд бүрэн хамрагдалт түүний дархлааны түвшин шалгах, өвчин бүртгэгдээгүй төв, зүүн бүсэд тухайн өвчний далд халдварыг илрүүлэх зорилготой тандалт судалгаа хийсэн. Өвчин гараагүй зүүн бүсийн Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Дорнод, Говьсүмбэр 5 аймгийн 23 сумын 46 багийн 138 өрхийн нийт 1,380 ийлдсэнд, төвийн бүсийн Хөвсгөл, Архангай, Сэлэнгэ, Дундговь, Өмнөговь, Төв, Баянхонгор зэрэг 7 аймгийн 14 сумын 28 багийн 210 өрхийн нийт 2,136 малын ийлдсэнд тус тус БММ өвчний эсрэг биом илрээгүй буюу сөрөг гарсан байна.</p> <p>2016 он: Малаас хүнд дамжин халдварладаг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргийг боом, галзуу, бруцеллэзын вакцинжуулалтад 13.3 сая толгой мал тус тус хамрагдсан байна. Бруцеллэзтой тэмцэх арга хэмжээнд 13.4 сая малыг вакцинжуулсан, Боом өвчний хувьд Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Завхан, Хөвсгөл, Хэнтий зэрэг 6 аймгийн 12 суманд 22 гаралтаар 87 мал өвчилсөн нь өнгөрсөн оныхоос 57.6 хувиар өвчний гаралт буурсан байна. Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 20 аймгийн 3.7 сая малыг хамруулахаар төлөвлөснөөс 3.5 сая мал хамрагдсан байна. Галзуу өвчний хувьд 128 суманд 153 гаралтаар 223 мал, амьтан өвчилсөн нь өнгөрсөн оныхоос 49.3 хувиар өвчлөл буурсан байна. галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 21 аймгийн 1676.7 мянган толгой мал хамрагдахаас 1652.8 мянган толгой мал хамрагдсан байна.</p> <p>2017 он: Малаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2017 онд 22.0 сая толгой мал сүргийг боом, галзуу, бруцеллэзын вакцинжуулалтад хамрагдсан ба 2016 онтой харьцуулахад 8.7 сая толгой малаар өссөн үзүүлэлттэй байна. Боом өвчин 3 аймгийн 7 суманд 11 гаралтаар 103 мал өвчилсөн байна. Боом өвчинтэй тэмцэх арга хэмжээнд жилдээ 21 аймгийн хэмжээнд нийтдээ 3.7-4.2 сая толгой мал хамрагдаж, вакцины зардалд 180.0-220.0 сая төгрөг зарцуулсан байна. Галзуу өвчнөөр 16 аймаг, нийслэлийн 100 сум, дүүрэгт 245 мал, амьтан өвчилсөн байна. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд жилдээ 22 аймаг, нийслэлийн 1,508.0-1,680.0 мянган толгой малыг хамруулж, вакцины зардалд 75.0-80.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.</p> <p>2016 он: 40-өөд нэрийн паразит өвчнөөр 22 аймаг, нийслэлийн 3344 цэгт 409755 толгой мал өвчилж, 592 мал хорогдож, 99.8 хувийн эдгэрэлттэй, өнгөрсөн оноос өвчлөлөөс 26 хувиар буурсан байна. Нийт 18.8 сая малыг арга хэмжээнд хамруулахаар төлөвлөж, гүйцэтгэл нь 27.9 сая мал буюу 148.4 хувиар давуулан биелүүлсэн байна. Малын халдваргүй өвчнөөр 205.3 мянган том мал өвчилж, үүнээс 54.0 мянган мал хорогдож эдгэрэлт 73.7 хувьтай, 221.4 мянган төл мал өвчилснөөс 47.5 мянга нь хорогдож, эдгэрэлт нь 78.5 хувьтай байна.</p> <p>2017 он: Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийт малын 30-с доошгүй хувийг хамруулахаар төлөвлөсөн ба давхардсан тоогоор 38.5 сая мал буюу 62.7 хувийг паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулжээ.</p>
	Мал, амьтны гоц халдварт өвчний тандалт шинжилгээ		<p>2016 он: Шүлхий өвчин, бог малын мялзан өвчний тандан судалгаа, бруцеллэзын вакцинжуулалтын дараах тандалт, малын хээл хаялтад нөлөөлдөг өвчний шинжилгээ, гахайд голлон тохиолддог 10 өвчний тандалт судалгаа, шувууны томуу өвчнийг оношлох, тандах, цусны ийлдсийг ялган бүртгэлжүүлэх ажлыг УМЭАЦТЛ болон бусад байгууллага хамтран зохион байгуулав.</p> <p>2017 он: УМЭАЦТЛ төв орон нутгийн мал эмнэлгийн лаборатори хамтран шүлхий өвчний тандалт шинжилгээнд 17 аймгийн 65 сумыг хамруулан 10950 дээж хамруулсан байна. Бог малын мялзан өвчин Баруун бүсийн бог малд өвчний вакцин тарьсантай холбогдуулан вакцинд бүрэн хамрагдалт түүний дархлааны түвшин шалгах, өвчин бүртгэгдээгүй төв, зүүн бүсэд тухайн өвчний далд халдварыг илрүүлэх зорилготой тандалт судалгаа хийсэн. Өвчин гараагүй зүүн бүсийн Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Дорнод, Говьсүмбэр 5 аймгийн 23 сумын 46 багийн 138 өрхийн нийт 1,380 ийлдсэнд, төвийн бүсийн Хөвсгөл, Архангай, Сэлэнгэ, Дундговь, Өмнөговь, Төв, Баянхонгор зэрэг 7 аймгийн 14 сумын 28 багийн 210 өрхийн нийт 2,136 малын ийлдсэнд тус тус БММ өвчний эсрэг биом илрээгүй буюу сөрөг гарсан байна.</p>
	Малаас хүнд халддаг өвчин, архаг халдварт өвчинтэй тэмцэх		<p>2016 он: Малаас хүнд дамжин халдварладаг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргийг боом, галзуу, бруцеллэзын вакцинжуулалтад 13.3 сая толгой мал тус тус хамрагдсан байна. Бруцеллэзтой тэмцэх арга хэмжээнд 13.4 сая малыг вакцинжуулсан, Боом өвчний хувьд Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Завхан, Хөвсгөл, Хэнтий зэрэг 6 аймгийн 12 суманд 22 гаралтаар 87 мал өвчилсөн нь өнгөрсөн оныхоос 57.6 хувиар өвчний гаралт буурсан байна. Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 20 аймгийн 3.7 сая малыг хамруулахаар төлөвлөснөөс 3.5 сая мал хамрагдсан байна. Галзуу өвчний хувьд 128 суманд 153 гаралтаар 223 мал, амьтан өвчилсөн нь өнгөрсөн оныхоос 49.3 хувиар өвчлөл буурсан байна. галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 21 аймгийн 1676.7 мянган толгой мал хамрагдахаас 1652.8 мянган толгой мал хамрагдсан байна.</p> <p>2017 он: Малаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2017 онд 22.0 сая толгой мал сүргийг боом, галзуу, бруцеллэзын вакцинжуулалтад хамрагдсан ба 2016 онтой харьцуулахад 8.7 сая толгой малаар өссөн үзүүлэлттэй байна. Боом өвчин 3 аймгийн 7 суманд 11 гаралтаар 103 мал өвчилсөн байна. Боом өвчинтэй тэмцэх арга хэмжээнд жилдээ 21 аймгийн хэмжээнд нийтдээ 3.7-4.2 сая толгой мал хамрагдаж, вакцины зардалд 180.0-220.0 сая төгрөг зарцуулсан байна. Галзуу өвчнөөр 16 аймаг, нийслэлийн 100 сум, дүүрэгт 245 мал, амьтан өвчилсөн байна. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд жилдээ 22 аймаг, нийслэлийн 1,508.0-1,680.0 мянган толгой малыг хамруулж, вакцины зардалд 75.0-80.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.</p>
	Паразиттах болон халдваргүй өвчнийг оношлох, тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ		<p>2016 он: 40-өөд нэрийн паразит өвчнөөр 22 аймаг, нийслэлийн 3344 цэгт 409755 толгой мал өвчилж, 592 мал хорогдож, 99.8 хувийн эдгэрэлттэй, өнгөрсөн оноос өвчлөлөөс 26 хувиар буурсан байна. Нийт 18.8 сая малыг арга хэмжээнд хамруулахаар төлөвлөж, гүйцэтгэл нь 27.9 сая мал буюу 148.4 хувиар давуулан биелүүлсэн байна. Малын халдваргүй өвчнөөр 205.3 мянган том мал өвчилж, үүнээс 54.0 мянган мал хорогдож эдгэрэлт 73.7 хувьтай, 221.4 мянган төл мал өвчилснөөс 47.5 мянга нь хорогдож, эдгэрэлт нь 78.5 хувьтай байна.</p> <p>2017 он: Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийт малын 30-с доошгүй хувийг хамруулахаар төлөвлөсөн ба давхардсан тоогоор 38.5 сая мал буюу 62.7 хувийг паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулжээ.</p>



Зорилт 3.2	Сум, дүүрэгт мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн магадлан шинжилгээ хийх чадавхтай болох	2016 он: Зоорь, агуулах 2682, малын хашаа, хороо 40322, худаг, уст цэг 1957, тэжээлийн агуулах 322, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах цэг 949, мал, амьтдын тоног хэрэгсэл, малын арьс, ноос 24895, автомашин бусад тээврийн хэрэгсэл 650250, гахайн байр 2324, шувууны байр 849, сэг зэм 197590 ширхэг, голомтын цэг 147, бэлчээрийн талбай 1.5 сая. м2, давхардсан тоогоор нийт 922 мянган нэгж объектыг хамруулан 15.2 сая. м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Нийт 19 оронтой 42 нэрийн мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд тохиролцсон мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл мэндийн гэрчилгээ, нөхцөлийг харилцан тохиролцсон байна.
	Экспортлох үеийн дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл	2016 он: ЕАЭК-ийн орнууд, Европын Холбоо, Тайланд, Ливан, Египет, БНСУ, БНХАУ, БНСВУ, Иран Улсад хонь, тэмээний угаасан, самнасан ноос, хөөвөр, хялгас, богийн боловсруулсан өлөн гэдэс, адууны дэл, сүүл, бугын ясан эвэр, салаа туурайтан малын мах, дайвар бүтээгдэхүүн экспортлоход дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл олгуулах хүсэлт, мэдээллийг шийдвэрлүүлсэн. Нийт 140 транзит зөвшөөрлийг импортлогч талаас олгоод байна. 12 аж ахуйн нэгж Европын Холбооны орнуудад ан, ангийн олзвор экспортлох тухай хүсэлтийг бүртгүүлж, зөвшөөрлийг олгуулах, экспортын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.
	Импортлох үеийн дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл	2016 он: Франц Улсаас 117 хонь, Латви Улсаас үржлийн болон хурдны адуу, хонь, ямаа, Польш, ХБНГУ-аас гахай, тахианы мах, махан бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүн импортлоход дамжин өнгөрүүлэх зөвшөөрлийг олгуулах ажлыг зохион байгуулсан. Дамжин өнгөрүүлэх 180 удаагийн зөвшөөрлийг ОХУ, Беларусийн талаас манай талд тоот албан бичгээр ирүүлсэн. Монгол улсын 15 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу ОХУ, Латви Улсаас үржлийн болон хурдны адуу, үхэр, хонь, ямаа, ургамлын гаралтай малын төрөл бүрийн тэжээл, хүнсний өндөг, хонины ноос, арьс шир, ямааны ноолуур, сүү, сүүн бүтээгдэхүүн, гахай, тахианы мах, махан бүтээгдэхүүн импортлоход тавигдах шаардлагыг дээрх орнуудын эрх бүхий байгууллагад хүргүүлсэн. Увс, Дархан-Уул, Орхон аймаг, Улаанбаатар хотод байрладаг мах, махан бүтээгдэхүүн боловсруулах 7-н үйлдвэрт хянан магадлааг хийсэн.
	Малын өвчний оношлогооны явуулын үйлчилгээ бий болгох	2016 он: Биоаюулгүйн лабораторид 13 эмч, мэргэжилтэн давхардсан тоогоор нийт 273 удаа, 826 цаг 36 минутын хугацаатай ажиллан оношлогоо, шинжилгээ, засвар үйлчилгээний ажил гүйцэтгэсэн байна. Жилийн 3.6 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй 180.0 сая төгрөгийн зээлийг 12 аймгийн 23 МЭҮН-д олгосон байна. 16 аймгийн 30 үржлийн аж ахуйн нэгжид 396.0 сая төгрөгийн зээл, мал амьтны халдварт болон гоц халдвар шүлхий өвчний оношлуур, эм урвалжийн нийт 368 нэрийн оношлуур, эм, урвалж багаж хэрэгслийг 588.8 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Гоц халдварт шүлхий өвчний оношлуур, эм урвалжийн 9 нэр төрлийн 70 ширхэг оношлуур урвалжийг 145.7 сая төгрөгөөр нийлүүлжээ. Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчний халдварын тархалтыг тогтоох тандалт шинжилгээнд шаардлагатай лабораторийн оношлуур, хэрэглэгдэхүүнийг 43.6 сая төгрөгийн нэмэлт худалдан авсан.
	Мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл мэндийн гэрчилгээ, нөхцөлийг харилцан тохиролцох	2017 он: Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт дэлхийн 14 улстай 39 нэрийн хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг, протокол, 19 оронтой 46 нэрийн мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл мэндийн гэрчилгээ, нөхцөлийг харилцан тохиролцсон байна.
	Монгол улсаас Япон улсад экспортлох мал эмнэлгийн гэрчилгээ, зарим бүтээгдэхүүний эрүүл мэндийн гэрчилгээ	2017 он: Монгол улсаас Япон улсад салаа туурайтан малын сүүн бүтээгдэхүүн экспортлох мал эмнэлгийн гэрчилгээ, давсалсан өлөн гэдэс экспортлох үеийн эрүүл мэндийн шаардлага, салаа туурайтан малын гаралтай давсалсан өлөн гэдэсний эрүүл мэндийн гэрчилгээ, гахайнаас гаралтай давсалсан өлөн гэдэсний эрүүл мэндийн гэрчилгээ тус тус авсан.
	“Traces” системд бүртгүүлэх	217 он: Монголын улсаас Евразийн эдийн гишүүн орнууд(ЕАЭЗХ), Европын Холбоо, Ливан, Египет, БНСУ, БНХАУ (Гонконг), БНСВУ, Узбекистан, Арабын Бүгд Найрамдах Египет, Ливан, Катар, Иран Улсад мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн экспортлоход гаалийн холбоо болон ЕАЭЗХ-ны нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх зөвшөөрлийг ОХУ, Беларусь, Казахстан улсын мал эмнэлэг, хорио цээрийн газарт хүргүүлж, зохих зөвшөөрлийг олгуулах арга хэмжээг авсан. Мөн ан, ангийн олзворыг Европын холбооны улсад экспортлох Монголын 3 аж ахуйн нэгжийг “Traces” системд бүртгүүлэн зохих зөвшөөрлийг олгуулсан.
	Мал эмнэлэг, ариун цэврийн дотоодын хянан магадлааг явуулах, үйлдвэр, АА-д итгэмжлэлийн зэрэглэлийг олгох	2017 он: Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, компаниудын хүсэлтийн дагуу Сүхбаатар болон Орхон аймаг, Улаанбаатар хот, Налайх дүүрэгт байрладаг мал төхөөрөх мах боловсруулах 6 үйлдвэр, махан бүтээгдэхүүн боловсруулах 3 үйлдвэрт мал эмнэлэг, ариун цэврийн дотоодын хянан магадлааг явуулж, 9 үйлдвэрээс 6 компанид АА, 3 үйлдвэрт ААА итгэмжлэлийн зэрэглэлийг олгож, гадаад орнуудад мах махан бүтээгдэхүүнийг экспортлох эрхийг авсан байна.
	Мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг шалгалтыг хийх	2017 он: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулах хүрээнд аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 746 мян.толгой малд эмнэлзүйн үзлэг шинжилгээнд хамруулсан бол 8,746 тонн мах, махан бүтээгдэхүүн, 5879 мян.литр сүү, сүүн бүтээгдэхүүн, 10,564 мянган өндөг, ноос ноолуур



	Зорилт 3.3	Малын эм, биобэлдмэлийг дотооддоо үйлдвэрлэх	<p>112,6 тн, малын тэжээл 36 тн, арьс шир (155,000 ш) тус бүрт зохих стандарт аргачлалын дагуу мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээгээр баталгаажуулан МЭАЦ, гарал үүслийн гэрчилгээг олгосон байна. Улсын хэмжээнд 31,230 удаагийн мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг шалгалтыг хийсэн ба мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдэд 56, хүнсний зах, дэлгүүр, худалдааны төвд 215, эмнэлэг, сургуульд 12, цайны газар, ресторан, нийтийн хоолны газарт 386, дэлгүүр мухлагт 213, автотээврийн хэрэгсэлд 65, гахай, шувууны аж ахуйд 11, түүхий эдийн агуулах, зоорьт 83, худаг уст цэгт 5 удаа үзлэг, шалгалтыг хийж, шинжилгээнд дээж авч баталгаажуулж, мэргэжлийн зөвлөгөөг өгсөн байна.</p> <p>2016 он: Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалт 124079.7 литр шингэн, 23291 мянган тун хатаасан вакцин, 7 нэрийн өвчнийг илрүүлэхэд шаардагдах 22 төрлийн 55.9 литр шингэн, 36.5 мянган тун хатаасан оношлуурыг үйлдвэрлэсэн байна. Улсын хэмжээнд мал эмнэлгийн зориулалттай 739 нэрийн эм улсын бүртгэлд бүртгэгдэж, хэрэглэж байна. 64 эм шинээр малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. Малын эмийн чиглэлээр мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 11 аж ахуйн нэгж, мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй 111 аж ахуйн нэгж, Улаанбаатар хотод 20 малын эмийн сан, аймгуудад малын эмийн ханган нийлүүлэх сүлжээний 22 аж ахуйн нэгж, хөдөө орон нутагт хувийн мал эмнэлэг үйлчилгээний 1005 нэгжийн эмийн сангаар дамжуулан мал бүхий иргэдийг улсын бүртгэлд бүртгэгдсэн 739 нэр төрлийн чанарын баталгаатай, өндөр идэвхтэй эмээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.</p> <p>2017 он: Мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 11 аж ахуйн нэгж, мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй 111 аж ахуйн нэгж, малын эмийн ханган нийлүүлэх сүлжээний 42 аж ахуйн нэгж, эмийн сан, хувийн мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдийн 1,005 эмийн сангаар дамжуулан үйлчилгээ үзүүлсэн байна. 2017 оны байдлаар улсын бүртгэлд 827 эм биобэлдмэл бүртгэлтэй байгаа ба 27.0 хувь нь паразитын эсрэг, 13.0 хувь нь тэжээл боловсруулах замын болон бодис солилцооны эмгэгийг эмчлэх, 14.0 хувь нь нянгийн эсрэг, 13.0 хувь нь биобэлдмэл, үлдсэн 33.0 хувь нь бусад үйлчилгээтэй эм байна.</p>
			Мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд болон мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, мөн малын эмийн ханган нийлүүлэх сүлжээнд үнэлгээ, хяналт тавих
Зорилт 4	Зорилт 4.1	Улс, аймаг, сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтад авах бэлчээрийн хэмжээг тогтоох	<p>2016 он: Ховд аймгийн Дарви сумын нутагт 105.2 мян.га талбайг улсын тусгай хэрэгцээний газарт шилжүүлсэн ба Баяннурууны аймаг дундын отрын бэлчээрийг шинээр байгуулж, аймаг дундын отрын бэлчээр 783.5 мян. га талбайгаар нэмэгдэж байна. Мөн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Бүрэнтогтох сумдын 35,000 га талбайг аймаг дундын отрын бүс нутаг нэмэгдсэн. Аймаг дундын отрын бэлчээр 782.5 мянган га болсон.</p> <p>2017 он: Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Баянзүрх сумын нутагт 87.0 мянган га бэлчээрийг улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг болгох судалгааг хийж, улсын тусгай хэрэгцээнд авахаар орон нутгийн удирдлагуудтай хамтран ажилласан ба 2017 оны байдлаар ашиглаж буй улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутгийн хэмжээ 782.5 мянга болсон байна.</p> <p>2018 он: Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Улсын газар зохион байгуулалтын 2003-2023 оны төлөвлөгөөнд Шинэ-Идэр, Бүрэнтогтох, Цэцэрлэг сумдын нийт 87.0 мян/га газрыг Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээр байгуулахаар тус тус тусгагдсан. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Зуунмод багийн Зосын голын нутаг дэвсгэрийг Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээр болгов. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн ээлжит хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж тус багийн нутаг дэвсгэрийг Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг болгох саналаас татгалзсан. Иймд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Зосын голын нутаг дэвсгэрийг Улсын тусгай хэрэгцээний отрын бүс нутаг болгох боломжгүй болсон.</p> <p>2017 он: Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт байрлах тэжээлийн агуулахын дээврийн засварыг хийж, худаг, тэжээлийн агуулахыг багтаасан блокон хашаа, Отрын бүс нутгуудын үйл ажиллагаанд ашиглагддаг 4 Уаз-</p>
		Дундын отрын бүс нутгийн тохижилт үйлчилгээг	

		сайжруулах, сэргээн засварлах	Фургон маркийн автомашиныг иж бүрэн засварлаж отрын бүс хариуцсан мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгөх арга хэмжээ авсан байна.
		Бэлчээрийн даац, хүрэлцээ хангамжийг тооцох	2017 он: Өвөл, хаврын бэлчээрийн даацыг авч үзэхэд нийт нутгийн 25 хувь нь хүрэлцээтэй, 30 хувь нь 1-3 дахин хэтэрсэн, 10 хувь нь 3-5 дахин хэтэрсэн, 30 хувь нь хэт их хэтэрсэн дүн гарсан ба өнгөрсөн жилтэй харьцуулахад бэлчээрийн даац хэтэрсэн байна. 2018 он: Өвөл хаврын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 25 хувь нь хүрэлцээтэй, 30 хувь нь 1-3 дахин хэтэрсэн, 10 хувь нь 3-5 дахин хэтэрсэн, 30 хувь олон дахин хэтэрсэн гарав
		Бэлчээр, бэлчээрийн менежментийг сайжруулах арга хэмжээ	2016 он: Үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг 2010-2016 онуудад 4095.8 мянган га талбайд, царцаатай тэмцэх ажлыг 744.2 мянган га талбайд гүйцэтгэсэн байна. Энэ ажлын үр дүнд нийт 4840.0 мянган га талбайг үлийн цагаан оготно, царцааны хөнөөлөөс хамгаалж бэлчээрийн даац багтаамжийг нэмэгдүүлсэн. 2017 он: Бэлчээрт хөнөөл учруулдаг мэрэгч амьтад, шавжтай тэмцэх үйл ажиллагаанд зориулж жил бүрийн улсын төсвөөс 1.2-1.6 тэрбум төгрөг гаргаж тандан судалгаа хийлгэж, бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг 12 аймгийн 81 сумын нийт 610.0 мянган га талбайд, царцаатай тэмцэх арга хэмжээг 3 аймгийн 16 сумын 89.8 мянган га талбайд зохион байгуулсан байна. Мөн Төв аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 30.0 мянган га талбайд, Сүхбаатар аймгийн орон нутгийн төсвөөр 0.3 мянган га бэлчээрийн талбайд, Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгөөр тус тус үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээнд зарцуулсан байна. “Ногоон алт малын эрүүл мэнд” төслийн хүрээнд бэлчээрийн менежмент, малын эрүүл мэнд, малчдын хоршооны зах зээлийг өргөжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус 11 байгууллагатай хамтран ажилласан ба малчдыг бэлчээр ашиглагчдын хэсгийн зохион байгуулалтад оруулах, бэлчээр ашиглалтын гэрээгээр дамжуулан бэлчээр сайжруулах, малчдын байгууллагыг хөгжүүлэх ажлыг Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоогоор дамжуулан хэрэгжүүлсэн байна. Төсөлд нийт 21 аймгийн 186 сум хамрагдаж 5 аймагт Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо, 24 сумын БАХолбоо, 147 БАХэсэг шинээр байгуулагдаж, нийт 12 АБАХ, 121 СБАХ, 1362 БАХэсэг үйл ажиллагаа явуулж байна. Монголын БАНХ шинэ 7 аймагт бэлчээрийг хамгаалах, бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр аймаг, сумын БАХ-ийн гишүүд, малчид, төрийн албан хаагч болон иргэдийн хурлын төлөөлөгч нийт 5486 хүнд 233 удаагийн сургалт явуулж, 4720 малчин, 573 төрийн албан хаагчид, 77 иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, бусад 116 оролцогчид хамрагдсан байна. Төслийн хүрээнд мөн бэлчээр ашиглалтын гэрээ нэвтрүүлсэн ба энэ ажлын хүрээнд 2017 оны байдлаар төслийн хуучин 7 аймагт 700 орчим БАХ болон сумын 3Д нарын хооронд бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан байна. Зах зээл ба бэлчээрийн хөгжлийн удирдлагын төслөөс 2017 онд Бэлчээр ашиглалтын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд “Аймаг дундын отрын бэлчээрийг ашиглах, хамгаалах тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлал”-ыг боловсруулах ажлыг санхүүжүүлсэн байна. Мөн аймаг дундын отрын бүсийн ашиглалтын захиргааны төвийн болон орон нутгийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор 9 мотоцикл, 22 ширхэг худгийн мотор, 11 ширхэг худгийн ус шахуурга (насос), 9 суурин компьютер, 2 ширхэг зөөврийн компьютер, дрон, оффисын тавилга зэргийг нийлүүлсэн байна.
Зорилт 4.2	Хадлан, тэжээлийн бэлтгэл	2016 он: Хадлан бэлтгэх ажилд 7101 дугуйт трактор, 558 хаман боогч, 8394 морин болон гар хадуур, тармуур ашиглаж, малчдын түвшинд 1.1 сая тн өвс, 35.7 мянган тн сүрэл, 22.3 мянган тн ногоон тэжээл, 27.1 мянган тн үйлдвэрийн тэжээл, 38.1 мянган тн гар тэжээл, 105.6 мянган тн давс, хужир бэлтгэж, биелэлт 87.5-тай байна. 2017 он: 935.7 мянган тн өвс бэлтгэсэн буюу төлөвлөгөө биелэлт 74.9 хувьтай, сүрэл 15.2 мянган тн буюу 95.0 хувийн биелэлттэй, ногоон тэжээл 22.6 мянган тн буюу 95.9 хувийн биелэлттэй, үйлдвэрийн тэжээл 34.4 мянган тн буюу 45.9 хувийн биелэлттэй, гар тэжээл 41.2 мянган тн буюу 50.5 хувийн биелэлттэй, дарш 9.4 мянган тн буюу 77.3 хувийн биелэлттэй, давс, хужир 105.8 мянган тн буюу 80.2 хувийн биелэлттэй, малчдын бэлтгэсэн нийт өвс, тэжээлийг тэжээлийн нэгжид шилжүүлснээр 70.2 хувийн биелэлттэй байсан ба төсвийн тодотголоор 40.0 тэрбум төгрөгийг тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээнд зориулсан байна. Энэхүү арга хэмжээнд 34 аж ахуйн нэгж гэрээ байгуулан хамтран ажилласан байна. 2018 он: Малчдын түвшинд хадлан тэжээлийн бэлтгэл 84.6 хувьтай байна. Үүнд: 1.0 сая 80.0 мянган тн өвс, 73.0 мянган тн ногоон тэжээл, 25.5 мянган тн үйлдвэрийн тэжээл, 50.0 мянган тн гар тэжээл, 5.3 мянган тн дарш, 84.0 мянган тн давс, хужир, шүү бэлтгээд байна.	
	Хадлан, тэжээлийн техник хэрэгсэл нэмэгдүүлэх	2017 он: 2017 онд хадлан бэлтгэх ажилд 7141 дугуйт трактор, 5735 бага оврын тракторууд дагалдах хэрэгслийн хамт, 621 хаман боогч, 1000 морин хадуур, 5000 гар болон хөдөлгөөнт хадуур, тармуур ашигласан ба хадлангийн техникийн шинэчлэлд зориулж хаман боогч 40 ширхэг, бага оврын трактор, хадуур тармуур тус бүр 20 ширхгийг зээлээр олгох ажлыг зохион байгуулсан байна.	
	Өвс, тэжээлийн аюулгүйн нөөц	2016 он: Аймаг, сумын аюулгүйн нөөц бүрдүүлэх даалгаврын дагуу 32.0 мянган тонн өвс бэлтгэхээс 20.4 мянган тонн өвс бэлтгэж, биелэлт 63.8	

	Зорилт 4.3	бүрдүүлэх	хувьтай, 13.1 мянган тонн тэжээл бэлтгэхээс 4.6 мянган тн тэжээл бэлтгэж, биелэлт 34.9 хувьтай байна. 2017 он: 32.0 мянган тн өвс, 13.1 мянган тн тэжээл бэлтгэх үүрэг даалгавар өгснөөс 23.0 мянган тн өвс, 5.3 мянган тн тэжээл бэлтгэсэн нь аймгийн түвшинд 88.5 хувь, сумдын түвшинд 58.5 хувийн биелэлттэй гарсантай холбоотой төсвийн тодотголоор 4.5 тэрбум төгрөгийг өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлэхэд зориулсан байна. Үр дүнд аймаг, сумын аюулгүйн нөөц 100 хувь (бүрэн) биелсэн байна. 2018 он: Өвс 25.9 мянган тн бэлтгэхээс 17.2 мянган тн буюу 66.4 хувь, тэжээл 14.7 мянган тн бэлтгэхээс 5.2 мянган тн буюу 35.4 хувьтай гарсан байна.
		Тэжээлийн ургамал тариалах, хураах	2016 он: 28.1 мянган га талбайд тэжээлийн ургамал тариалж, 50.6 мянган тонн дарш, ногоон тэжээл хураан авсан. 2017 он: 2017 онд 28.2 мянган га талбайд тэжээлийн ургамал тариалан 47.3 мянган тонн дарш, ногоон тэжээл хураан авсан байна. Нэг, ба олон наст ургамал тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Байгалийн эрсдэлд өртөмтгий аймгуудад таримал тэжээл тариалж тэжээлийн нөөц нэмэгдүүлэх” арга хэмжээг зохион байгуулж, Булган, Сэлэнгэ, Төв аймагт тус бүр 100 га-д царгас тариалах, үр үржүүлэх ажилд дэмжлэг үзүүлж тэжээл үйлдвэрлэлийг 2018 онд 1200 тн ногоон тэжээлээр нэмэгдүүлсэн ба царгасны үр үржүүлэх 720 га талбай, хөх тарианы үр үржүүлэх 200 га талбайг нэмэгдүүлж малын тэжээл тариалалтыг 0.03 хувиар өсгөсөн байна. 2018 он: “Царгас тариалах болон царгасаар мал тэжээх технологи” сэдэвт сургалтыг зохион байгуулж 30 гаруй малчныг хамруулав.
		Инженерийн хийцтэй худаг шинээр ашиглалтад оруулсан	2017 он: Аймаг дундын отрын бүс нутгийн тохижилт үйлчилгээний хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан, Ховд аймгийн Баяннурууны отрын бүс нутаг тус бүрт 2, нийт 4 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргах. Говь-Алтай, Сүхбаатар аймгуудад 190.0 сая төгрөгөөр 200 газарт уст цэгийн хайгуул судалгааны ажил хийж, 142 бэлчээрт 142 худаг шинээр гаргах нөөц цэгтэй болсон байна. 2016-2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 149, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 427, гадаадын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 62, малчдын санаачилгаар 673, нийт 1356 инженерийн хийцтэй худгийг шинээр барьж, ашиглалтанд оруулж, 2.0 сая га бэлчээр, 6.7 мянган малчин өрх, 3.7 сая мал сүргийг усаар хангах боломжийг бүрдүүлэв.
		Гар хийцийн худаг шинээр болон сэргээн засварлан ашиглалтад оруулсан	2017 он: Гар хийцийн худаг шинээр болон сэргээн засварлан ашиглалтад оруулсан байдал. 2016-2017 онд 11 аймагт малчдын оролцоотойгоор 155 гар хийцийн худгийг шинээр гаргах, сэргээн засварлах явцад залуу малчдыг гар худаг гаргах арга ажиллагаанд сургасан байна.
		Худаг сэргээн засварлаж, дахин ашиглалтад оруулах	2017 он: Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслийн санхүүжилтээр отрын бүс нутгуудад ашиглаж буй худаг сэргээн засварлах зориулалтаар 22 мотор 11 насосыг нийлүүлсэн. Сэргээн засварлаж, дахин ашиглалтад оруулсан худаг. 2016-2017 онд улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн хөрөнгөөр 10 аймагт сэргээн засварласан 60 гаруй худгийг ашиглалтад оруулсан байна.
Зорилт 4.4	Малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох	Булгаг шанд хашиж хамгаалах, хөв цөөрөм байгуулах	2017 он: Булаг шанд, хөв цөөрөм. Булган, Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Говь-Алтай, Дундговь аймгуудад 78 гаруй булгийн эхийг хашиж хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 87.2 сая төгрөгийн санхүүжилтээр Говь-Алтай аймагт 2 хөв цөөрмийг барьж байгуулан ашиглалтад оруулсан, мөн Баян-Өлгий аймгийн Буянт сумын зам дагуух үерийн далаанд цас борооны усыг тогтоон барих арга хэмжээ авч байна.
		Малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох	2016 он: 2006 оноос хойш Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнд өссөн дүнгээр нийт 112 мянга орчим малчин өрх хамрагдаж 20.6 сая толгой мал даатгуулсан байна. Малын индексжүүлсэн даатгал хэрэгжиж эхэлснээс хойш 20.0 мянган малчин өрх буюу даатгуулсан малчдын 17.8 хувь нь 3.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр авсан байна. 2018 он: 33719 малчны 7.8 сая малыг 3.4 тэрбум төгрөгөөр даатгуулах ажлыг зохион байгуулсан нь нийт малчин өрхийн 19.8 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос 9571 өрхөөр, даатгалын хураамжийн орлого 1 тэрбум 133 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.
		Мал аж ахуйн эрсдэлийг үнэлэх, сэргийлэх	2017 он: Монгол улсын ЗГ болон бусад яамд, агентлаг, улсын онцгой комисс 21 аймагт ажиллаж, 13 аймгийн 53 сум цагаан зудтай, 13 аймгийн 55 сум цагаан зудруу нөхцөлийн зэрэглэлтэй болохыг тогтоосон байна. Мөн гангийн үнэлгээ тогтоох, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 21 аймагт ажиллаж, 15 аймгийн 94 сум гантай, 21 аймгийн 153 сум гандуу зэрэглэлтэйг тогтоосон байна. Дээрх ажлын үр дүнд МУЗГ-аас 8.3 тэрбум төгрөгийг мал аж ахуйн эрсдэлийг бууруулахад зарцуулсан байна. Мөн МУ-ын Шадар сайдын Уриалгын дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ОУБ-уудтай хамтран “Ган, зуд хавсарсан хүндрэлийг даван туулахад яаралтай тусламж үзүүлэх, чадавхыг бэхжүүлэх” төслийг 2016-2017 онд 18 аймгийн 136 сумын эмзэг бүлгийн 10200 малчин өрхөд 2.1 сая ам.долларын өртөг бүхий бэлэн мөнгө, тэжээл, эрдсийн долоод, загасны тос, хуурай сүү орлуулагч, амин тунгийн багц, ахуйн хэрэглээний багц, хүнсний багцын тусламж үзүүлж ажилласан байна.



		Малын даатгалыг өргөжүүлэх, сурталчлах	<p>2017 он: 2006-2014 он хүртэл хэрэгжсэн “Малын индексжүүлсэн даатгал” төслийг МУЗГ үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа ба 2017 оны 2 сараа 7 сарыг хүртэлх хугацаанд 21 аймгийн нийт 330 суманд даатгалын компаниуд болон зуучлалаар дамжуулан нийт 24,148 малчинтай малын индексжүүлсэн даатгал байгуулж, 2 тэрбум 329 сая төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 15.3 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос 5,410 малчин өрхөөр, даатгалын хураамжийн орлого 555.0 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Малын даатгалыг өргөжүүлэх, сурталчлах зорилгоор “Малчдад ээлтэй багийн Засаг дарга” уралдааныг нийт 21 аймгийн 330 сумын 1600 багийн Засаг дарга нар дунд зохион байгуулсан, мөн аймаг, сумдад зохион байгуулж буй малчдын зөвлөгөөн, уулзалтын үеэр МИД-ын талаар танилцуулга хийж, телевизийн 2 нэвтрүүлэг, 3 төрлийн шторк, Үндэсний радиогоор 4 төрлийн яриа нэвтрүүлэг бэлтгэн хүргэсэн байна. Даатгалын сурталчилгааг Малчдадаа зориулан цаг тооны бичиг 20.0 мянган ширхгийг, “Даатгал” сонинг 40.0 мянган ширхэг, Төрийн болон Хаан банкны сурталчилгааны зурагт хуудас нийт 1000 ширхэг, 2000 ширхэг гарын авлагыг тараасан байна.</p>
Зорилт 5	Зорилт 5.1	Мал нядалгааны цех бий болгох	<p>2016 он: Улсын хэмжээнд махны холбоонд бүртгэлтэй 55 мал нядлах, мах боловсруулах үйлдвэртэй, үүнээс 21 үйлдвэр мэргэжлийн хяналтын байгууллагаар итгэмжлэгдсэн, 18 мах нядалгааны цехийг шинээр байгуулсан байна.</p> <p>2017 он: Улсын хэмжээнд Монголын махны холбоонд бүртгэлтэй 55 мал нядлах, мах боловсруулах үйлдвэртэй ба 21 үйлдвэр нь мэргэжлийн хяналтын байгууллагаас итгэмжлэгдсэн байна. Мөн Монгол мал хөтөлбөрийн хүрээнд 18 мах нядалгааны цехийг шинээр байгуулсан байна.</p>
	Зорилт 5.2	Дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн, гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнд чанараас хамааран урамшуулал олгох	<p>2016 он: Ноосны урамшуулалд 20.5 мянган тн ноосонд 22.6 тэрбум төгрөг, арьс ширний урамшуулалд 278.1 мянган ширхэг бодын арьсанд, 2846.7 мянган ширхэг богийн арьсанд 12.7 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна.</p> <p>2017 он: Ноосны урамшуулалд 20.2 тн ноосонд 22.5 тэрбум төгрөг, арьс ширний урамшуулалд 350.7 мянган ширхэг бодын арьсанд, 3116.6 мянган ширхэг богийн арьсанд 11.8 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна.</p> <p>2018 он: Ноосны урамшуулалд 16.5 мянган тн ноосонд 18.4 тэрбум төгрөг олгосон байна.</p>
	Зорилт 5.3	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний биржийн сүлжээ бий болгох	<p>2016 он: Хөдөө аж ахуйн бирж 2016 онд 181 удаагийн сфот арилжаа зохион байгуулж, 1146 удаагийн хэлцлээр 7 216.4 тн ноолуурын, 16 150.3 тн хонины ноосны, 774 тн тэмээний ноосны, 1639 тн ямааны завод ноосны, 1.1 тн сарлагийн завод ноосны, 4.1 тн сарлагийн хөөврийг арилжиж, 463.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн.</p> <p>2017 он: Хэнтий, Сүхбаатар, Хөвсгөл, Баянхонгор аймгуудад “Хөдөө аж ахуйн бирж” ХХК болон аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2017 оны боловсруулаагүй ноолуурын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулсан ба ноолуурын зах зээлийн жишиг үнэ харьцангуй өндөр тогтож, малчид, хоршоо биржийн арилжаанд шууд оролцох эхлэл тавигдсан. Малчдыг ноолуурын эцсийн худалдан авагчтай холбох ажлыг амжилттай зохион байгуулж, 4 удаагийн дуудлага худалдаагаар нийт 12.7 тонн ноолуурын арилжаа хийгдсэн байна. Мөн 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Хөдөө аж ахуйн бирж нь Монголд анх удаа “Ноолуурын форвард арилжаа”-г амжилттай зохион байгуулсан ба нийт 7 хэлцэл хийгдэж, нийт 11.5 тонн боловсруулаагүй ноолуурыг худалдах, худалдан авах форвард гэрээг байгуулсан байна.</p> <p>2018 он: Биржийн хувьд Монголын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих оновчтой тогтолцоог бий болгох замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх бололцоог бүрдүүлэх эрхэм зорилго дэвшүүлэн ажиллаж байна.</p> <p>Хөдөө аж ахуйн бирж 2018 онд 157 удаагийн сфот, 1 удаагийн форвард гэрээний арилжаа зохион байгуулж 1144 хэлцлээр 5862.0 тн ноолуур, 13794.4 тн хонины ноос, 274.0 тн тэмээний ноос, 3262.9 тн ямааны завод ноос, 1358.6 тн хонины завод ноос, 20 тн сарлагийн хөөвөр тус тус арилжиж нийт 711,4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.</p>

Эх сурвалж: ХХААХҮЯ (2016-2019)





## Орон нутгийн хэмжээнд хийгдсэн ажил, гарсан үр дүн

### 1. Малын эрүүл мэндийн үйлчилгээ

- Архангай, Орхон аймгуудын хувьд төмөр хашаа барьж, олон малыг нэг дор төвлөрүүлэн хашиж вакцинжуулалт хийх ажлыг үр дүнтэй гүйцэтгэж байна.
- Орхон аймагт малаас хүнд халдварладаг зоонозын халдварт өвчний талаарх мэдлэг, мэдээллийг хялбарчилсан гарын авлага хэлбэрээр сурталчлан, ЭМГ-тай хамтран эрсдэлт бүлгийн (малчид, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид) иргэдийг бруцеллёзын шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн даатгалд хамруулж хэвшсэн.
- Ховд аймгийн хувьд төл малын өргөн дархлаажуулалтын ажлыг 9 дүгээр сард зохион байгуулж зөвхөн охин тугал дархлаажуулсан байна. Энэхүү арга хэмжээнд 744.8 мянган толгой төл буюу 99.5 хувьтай хийж гүйцэтгэсэн боловч одоогоор үйлчилгээний санхүүжилт нь олгогдоогүй байна. Тус аймаг нь бруцеллёзтой тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр хийгддэг төлөвлөгөөт шинжилгээг Хүнс, хөдөө ахуйн газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр баталсан удирдамжийн дагуу мал эмнэлгийн албаны ажлын хэсэг 05 дугаар сард 6,389 хуц буюу 82.5% , 7,389 ухна буюу 73%, 472 бух буюу 18%, 92 буур буюу 29.5% нь нийт 14,342 хээлтүүлэгч мал хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд бруцеллёзын тандах шинжилгээнд нийт малын 69% хамрагдсан байна. Мөн Ховд аймгийн мал сүрэгт шүлхий өвчний байгалийн халдвар буй эсэхийг тандан илрүүлэх, шүлхий өвчнөөр тайван, түүнийг халдваргүй болохыг нотлох зорилтот тандах шинжилгээг аймгийн Хүнс, хөдөө ахуйн газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн баталсан А/17 тоот тушаалаар ажлын хэсэг 2018 оны 5 дугаар сарын 25-30-ны хооронд Алтай, Булган, Үенч сумын 9 багийн 45 өрхийн 225 үхэр, 90 хонь, 135 ямаа, нийт 450 малын дээжинд ID Screen PPR Antigen Capture Элиза урвалын шинжилгээ хийж шинжилгээний дүнгээр Булган сумын Баянгол багаас үхэр 1, Үенч сумын Жаргалан багаас хонь 1, Улиаст багаас үхэр 1 нийт 3 мал эерэг урвал үзүүлж, УМЭАЦТЛ-д баталгаажуулах шинжилгээнд хүргүүлээд байна. Бог малын Мязан өвчнөөс урьдчилан сэргийлэх өргөн дархлаажуулалтын ажлыг 10 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн Ховд аймгийн 17 сумын 3,499.4 мянган толгой мал хамруулахаас 3,199.2 мянган толгой мал буюу 100 хувийн гүйцэтгэлтэй дархлаажуулав. Зэргэлдээ аймаг сумын нутагт отор нүүдэл хийж байгаа малчдын мал нэг бүрийг вакцинжуулалтад хамруулан ажилласан хэдий ч уг ажлыг хийхэд шаардагдах зардлыг МЭҮН-д бие даан зээлийн шугамаар хийж гүйцэтгэсэн боловч одоог хүртэл үйлчилгээний санхүүжилт нь олгогдоогүй байна. Аймгийн хэмжээнд сумдыг бүсчилэн жил бүр Адууны ям, халдварт цус багасах өвчний шинжилгээг хийж бүрэн эрүүлжсэн дүн мэдээтэй байна.
- Хөвсгөл аймгийн малын халдварт өвчний гаралт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.2%-иар буурсан. 2018 оны жилийн эцсээр 18 сумын 50 багийн нутаг дэвсгэрт 150 голомтод 9 төлийн паразиттах өвчнөөр 18,614 толгой мал өвчилж, үүнээс 98 толгой мал үхэж, 18,516 толгой мал эмчлэгдсэн

байна. Паразиттах өвчний гаралт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.3%-иар буурсан байна. Том, төл малын өвчний өвчлөлийг урьд оны мөн үетэй харьцуулахад 41.9%-иар буурсан байна.

- Хэнтий аймгийн Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, лабораторийн оношлогооны чадавхыг бэхжүүлэх, малын эрүүл мэндийн хамгаалах ажилд дунджаар 1.2 тэрбум төгрөгийг улс, аймгийн төсвөөс зарцуулж, давхардсан тоогоор 3.7 сая малыг вакцинжуулалтад хамруулснаар гоц халдварт, халдварт өвчний гаралт 23.3-100 хүртэл хувиар буурсан байна.
- Нийслэлийн хэмжээнд үхрийн бруцеллөз, адууны ям, цус багасах, үхрийн лейкоз болон бог малын бруцеллөз өвчнүүдийн гаралт тархалтад анхаарч дархлаажуулалт болон тандалт шинжилгээнд жил бүр хамруулснаар эдгээр өвчний гарал тархалт буурсан. Эм тугал, хурга, ишгийг бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулж, жил бүр 2000 дээжинд вакцины дараах мониторинг хийж дархлаа тогтолтыг шалгаж үр дүнг тооцож ажилласан. Халдварлалтын хувийг 2015 онтой харьцуулахад 2018 онд 21.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2016 оноос хойш нийслэл хотод лейкоз, адууны халдварт цус багасах өвчний тохиолдлууд бүртгэгдээгүй байна. “Монгол мал” үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Үхрийн цээж, үхрийн тархины эд сархиатах өвчин оношлогдоогүй тайван байна.

## **2. Малын генетик нөөц, үржил селекти**

- Баян-Өлгийн аймгийн сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр худалдан авсан өндөр ашиг шимтэй Алатау, Сэлэнгэ үүлдрийн нийт 12 эрлийз бухыг сайжруулагчаар сүүлийн 3 жил үржилд ашиглан нийт 1,570 үнээг хээлтүүлж, 1,256 тугал бойжуулсан байна.
- 2016-2019 онд ХХААХҮЯ-ны Малын Удмын сангийн Үндэсний төвөөс зохион байгуулж буй “Бод, бог малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх” сургалтад 4 хүн хамрагдлаа.
- Үржлийн ажил, үйлчилгээ явуулдаг “Мандах он” ХХК-ний үржлийн нэгжтэй хамтран нийт 340 үнээг зохиомлоор хээлтүүлээд байна.
- УМЭҮГ-аас ХХААХҮС-ийн А/74 тоот тушаалаар батлагдсан “Малын бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 7 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ХХААГ болон сумдын малын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтний компьютерт 5 ширхэг антивирусны програмыг суулгасан бөгөөд малын мэдээллийн сангийн програмын засвар үйлчилгээг үзүүлэн шинээр оффлайн, онлайн програмыг суулгасан ажилласан байна.
- “Малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 47,900 толгой бод, 15,400 толгой бог малыг ээмэгжүүлэн бүртгэлд хамруулахаас нийт ээмэгжүүлэх бод малын 88 хувь буюу 42.3 мянган толгой үхэр, 13.8 мянган бог малыг ээмэгжүүлжээ.
- Баянхонгор аймаг 2016 онд Бөмбөгөрийн улаан ямаа омогоор, 2017 онд Ламын гэгээний улаан тэмээ үржлийн хэсгээр батлагдаж аймагт “Торгон сүрэг” хөтөлбөр хэрэгжиж байна.



- Говь-Алтай аймаг Гоц халдварт өвчингүй тайван статусаа хадгалж байна.
- Дархан-Уул аймаг мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд аймгийн хэмжээний 1642 малчин, мал бүхий өрхийн 40843 үхэр, бог малыг бүртгээд байна.
- УМЭҮГ-аас ХХААХҮС-ийн А/74 тоот тушаалаар батлагдсан “Малын бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 7 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ХХААГ болон сумдын малын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтний компьютерт 5 ширхэг антивирусны програмыг суулгасан бөгөөд малын мэдээллийн сангийн програмын засвар үйлчилгээг үзүүлэн шинээр оффлайн, онлайн програмыг суулгасан ажилласан байна.
- Дорноговь аймаг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн ээмэгний кодыг сумдын МЭҮТ-ууд олгосон ээмэгний бүртгэлийн кодтой тулгалт 2011, 2012, 2013 он тус бүрээр гаргаж УМЭҮГ-т албан тоотоор хүргүүллээ.
- Дундговь аймгийн хувьд 2016-2019 онд ХХААХҮЯ-ны Малын Удмын сангийн Үндэсний төвөөс зохион байгуулж буй “Бод, богийн малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх” сургалтад 4 хүн хамрагдлаа. Үржлийн ажил, үйлчилгээ явуулдаг “Мандах он” ХХК-ний үржлийн нэгжтэй хамтран нийт 340 үнээг зохиомлоор хээлтүүлээд байна.
- Орхон аймаг малыг ээмэгжүүлж, бүртгэлд хамруулж бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.
- Малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 120 өрхийг ажлын байраар хангаж цаашид үхрийн аж ахуй эрхлэх суурийг бий болгож өгсөн. Сүү, цагаан идээг тогтмол хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсэн
- Өмнөговь Малын шилжилт хөдөлгөөн, малчдын дур зоргоороо уур амьсгал, бэлчээрийн төлөв байдлыг харгалзалгүй, мэргэжилтнүүдийн зөвлөмжгүй сайн гэсэн хээлтүүлэгч мал зөөвөрлөдөг нь орон нутагтаа дасан зохицсон мал сүргийг эмзэг болгох, ашиг шимийг муутгах зэрэг сөрөг нөлөө үзүүлж байна.
- Сэлэнгэ аймаг мал сүргийн үзлэг ангилалтын ажлыг жил бүр тогтмол хийж гүйцэтгэж ирснээр малын чанар үүлдэрлэг байдал сайжирч нийт сүрэгт эзлэх цэвэр эрлийз малын тоо толгой нэмэгдсэн.
- Увс аймаг ноолуур, сүүний гарц өндөр “Өлгийн Улаан” омгийн ямаа үүдрээр батлагдаж малчдын орлого тодорхой хэмжээгээр нэмэгдэх мөн бусад сумуудад сайжруулагчаар ашиглах боломж нөхцөл бүрдсэн.
- Ховд аймаг 2017 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 08 сарын 09-ны 79 тогтоолоор “Шилмэл мал” аймгийн дэд хөтөлбөр, 11 сарын 03-ны 106 дугаар тогтоолоор “Залуу малчин” дэд хөтөлбөрүүдийг тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шилмэл мал аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд энэ онд аймгийн Засаг даргын А/569 дугаар захирамжаар 10 сая төгрөгөөр Булган суманд үржүүлж буй Торгууд үүлдрийн хэсгийн цөм сүрэг, Алтай суманд үржүүлж буй Алтай улаан үүлдрийн ямааны цөм сүрэг, Дарви суманд үржүүлж буй Сутай үүлдрийн хонины цөм сүргээс хээлтүүлэгч бойжуулах зардалд 6 сая, хээлтүүлэгч малд үзлэг ангилалт хийх ажилд 2 сая, Сарлагийн чанар сайжруулахад 2 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгасан. ХХААХҮСайдын 2016 оны А/87 тушаалаар Алтай суманд үржүүлж буй Алтайн

улаан ямааг үүлдрээр, 2017 оны А/175 тушаалаар Дарви суманд үржүүлж буй Сутай хонийг үүлдрээр, 2018 оны А/190 тушаалаар Мянгад суманд үржүүлж буй Мянгад адууг омгоор баталгаажуулсан. Мөн Булган суманд Торгууд үүлдрийн хэсгийн хонь үржүүлж байна. Эдгээр үүлдэр, үүлдрийн хэсэг, омгийн малыг орон нутагт сайжруулагчаар ашиглаж байна. Алтайн улаан үүлдрийн ямааны тоо 67.7 мянга, Торгууд үүлдрийн хэсгийн хонины цөм сүргийн хонины тоо 4.8 мянга, сайжруулсан хонины тоо 35.3 мянга, Сутай омгийн хонь 142.1 мянга, Мянгад омгийн адууны тоо 132.1 мянгад хүрсэн байна. Алтай суманд үржүүлж буй Алтайн улаан үүлдрийн 15,386 ямаа, Сутай үүлдрийн 12,000 хонь, Мянгад омгийн 6,000 адуу, Торгууд үүлдрийн хэсгийн 4,255 хонинд үзлэг ангилалт хийх ажлыг зохион байгуулан, тухайн үүлдэр, омгийн малын ашиг шимийн түвшин тогтоох ажлыг 37,641 малд хийж гүйцэтгэлээ. Нийт ангилалтанд хамрагдсан малын 20.5 хувь нь цөм сүрэгт, 78.3 хувь нь үржлийн сүрэгт, 1,2 хувь нь хэрэгцээний сүрэгт хамрагдсан дүнтэй байна. 09 дүгээр сарын 10-аас 10 дугаар сарын 01-ны хооронд хөдөөгийн 16 сумын бог малын хээлтүүлэгчид үзлэг, ангилалт хийх ажлыг зохион байгуулж нийт 7,396 хээлтүүлэгч мал үүнээс 3,464 хуц, 3,932 ухна хамрууллаа. Үзлэг ангилалт хийж стандартын шаардлага хангасан, зааз хээлтүүлэгчийг ялгаж, заазлах хээлтүүлэгчийг үржилд ашиглахгүй байх талаар сумын МЭҮТ-ийн Малын биотехнологи, үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэнд зөвлөгөө өгч ажиллаа. нийт 64 хуц, 91 ухна стандартын шаардлага хангахгүй болохыг тогтоосон.

- Хөвсгөл аймаг нутгийн өндөр ашиг шимт малыг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийснээр Эрчим хар үүлдрийн ямаа, Мах-өөх бүдүүвтэр ноост Цагаан уул үүлдрийн хонийг батлуулсан. Үүлдэр батлагдсанаар малчдын орлого нэмэгдэж байна.
- Хэнтий аймаг 2017 онд малын ашиг шим, үр төлийн чанарыг сайжруулах зорилгоор ОНТХөрөнгө оруулалт 5 сая төгрөгөөр үржлийн мал худалдан авсан. Үүнд: Орхон үүлдрийн 10 эм хонь, 5 хуц аваад байна. (Цөм сүргийн үржлийн төв) 2019 онд 1.7 сая төгрөгийн ОНТХөрөнгө оруулалтаар 1.7 мянган толгой малд үзлэг ангилалтыг хийсэн.

### **3. Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалт**

- Архангай аймаг хөтөлбөр хэрэгжсэнээс хойших хугацаанд давхардсан тоогоор нийт 1,400 гаруй малчдыг бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх арга технологид сургасан.
- Хөтөлбөрийн хүрээнд төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран бэлчээрийг сэлгээн өнжөөх, сэргээх, хашиж хамгаалах сургалтуудыг зохион байгуулснаар аймгийн 270 гаруй мянган га бэлчээрийг зохистой ашиглаж байна.
- Баян-Өлгий аймаг 2016 оны судалгаагаар 451 иргэн, аж ахуйн нэгж 3,351.5 га газрыг хашиж хамгаалан хадлан авч байна. Малчид бэлчээр болон хадлангийн талбайг хашиж хамгаалах ажил ид өрнөж байгаа боловч талбайг хаших материал их дутагдалтай, гадаад дотоодын төслийн байгууллагын дэмжлэгийг хүсэгчид олон. Тус аймагт 2010 оноос эхлэн Бэлчээрийн

менежмент төсөл хэрэгжиж эхлээд байна. Сум бүрт зохицуулагч ажиллан, ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангагдсан. Нийтдээ бэлчээр ашиглалтын 270–аад хэсэг шинээр байгуулагдсан байна. Ногоон алт хөтөлбөр, бэлчээрийн менежментийн төсөл хамтран бүх сумдад үйл ажиллагаа явуулж байна. Энэ төслийн гол зорилго нь бэлчээрийн хуваарьтай ашиглах, малчдын хамтын ажиллагаа хоршооны хэлбэрийг бий болгох, дундын сан байгуулан хадгаламж зээлийн хоршоог ажиллуулах, түүхий эд бүтээгдэхүүнийг авч олсон ашгийг дахин хуваарилах, малчдаас хадгаламж авах зэрэг олон талын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Баянхонгор аймаг бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам баталж сумдаар хэлэлцүүлж байна.
- Бэлчээрийн хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх ажлын үр дүн 85 хувьтай байна.
- Говьсүмбэр аймаг улсын төсвийн 48 сая төгрөгөөр 30 мян.га-д, орон нутгийн төсвийн 20.5 сая төгрөгийн хөрөнгөөр 20 мян га-д бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг 80-аас дээш хувийн техник үр дүнтэйгээр хийсэн.
- Дархан-Уул аймаг бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготно, царцаатай байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 22 аж ахуйн нэгж, 4 иргэн өөрсдийн хөрөнгөөр 9,200 га талбайд үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулсан байна.
- Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, сумдын МЭҮТасагтай хамтран 7.8 дугаар саруудад 52 цэгт бэлчээрийн ургамлын зүйлийн бүрдлийг шугаман цэгийн аргаар тодорхойлж, олон наст ургамлын суурь хоорондын зайг хэмжиж, ургац тодорхойлох дээж авч бэлчээрийн ургацыг тооцон, бэлчээрийн ургамлын ургалтын байдал, бэлчээрийн идэгдэц, талхагдлын байдал, хөрсний өөрчлөлтийн хүчин зүйлийг тодорхойлж, үнэлж, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ, судалгаагаар Орхон сумын зүүн хэсэг, Хонгор сумын хойд болон зүүн хойд, Дархан сумын хойд болон зүүн хэсгээр 8-17 ц/га, бусад сумдын нутгаар 3-6 ц/га буюу олон жилийн дунджаас ахиу ургац бүрдэж хадлангийн нөөц хангалттай байна. 2017 оны мөн үетэй харьцуулахад Хонгор сумын Зулзагын гол, Цогт-Өндөр, Орхон сумын Дардай нуур, Шарын гол сумын Буянт, Төмөр толгой орчмын бэлчээрт 6-8 ц/га-аар, Орхон сумын Дэлгэр уул, Хонгор сумын Салхит, Хар бэлчрийн ам, Шарын гол сумын Дархан-Уул, Олон хөтөл орчмын бэлчээрт 3-5 ц/га-аар ахиу ургац бүрдсэн. Газрын нэгдмэл сангийн дүнгээр аймгийн хэмжээнд 177 мянган га бэлчээр, 9,072.5 га хадлангийн талбай байдаг.
- Дорноговь аймаг Монгол мал үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.
- Дорнод аймаг бэлчээрийг нөөцөд авч, бэлчээрийн талхагдал багасаж, бэлчээрийг зохистой ашиглах малчдын тоо нэмэгдсэн.
- Дундговь аймаг бэлчээрийн хортон мэрэгч бүхий 13 суманд 212 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 132.500 га бэлчээрийн талбайд тэмцэх арга хэмжээг 80%-иас дээш үр дүнтэйгээр зохион байгуулсан. Бэлчээрийн даац 1-2 дахин



нэмэгдсэн. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2018 оны 85-р тогтоолоор "Бэлчээрийн менежментийн хөтөлбөр"-ийг батлуулж 85%-ийн үр дүнтэйгээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Сэлэнгэ аймаг бэлчээрийг сэлгэх өнжөөх, хортон мэрэгч тархсан талбайд устгал хийж гүйцэтгэснээр бэлчээрийн ургац нэмэгдэж хортон мэрэгч тархсан талбайн хэмжээ буурсан.
- Ховд аймаг Мерси-Кор олон улсын байгууллагатай хамтран, ХХААХҮЯ-аас ирүүлсэн заавар зөвлөмж, аргачлалын дагуу Булган, Үенч, Мөнххайрхан, Манхан, Ховд, Эрдэнэбүрэн, Мянгад 7 суманд . “Бэлчээрийн менежментийн дунд хугацааны төлөвлөгөө” (2017-2020)-г боловсруулан холбогдох сумдад хүлээлгэн өгсөн. ХХААХҮЯ-ны сайдтай аймгийн Засаг дарга, ХХАА-н газрын даргын байгуулсан гэрээний дагуу Аймгийн дүнгээр өндөр уулын бүсийн Мөст, Мөнххайрхан, Манхан, Зэрэг, Цэцэг, Дуут сумдын нутагт ургамал хамгааллын 4,500 литр Карате (5%)-н бодис хэрэглэн химийн аргаар 30,000 га-д бэлчээрийн хөнөөлт шавьж царцаатай тэмцэх ажилд нийт 164.2 сая төгрөгийн зардал гаргаж, 98.4%-ийн үр дүнтэйгээр тэмцэх ажлыг зохион байгуулсан.
- Нийслэл Орон нутгийн төсөвт санхүүжилт тусгагддаггүй.

#### **4. Ус, худаг шинээр гаргах, хуучин сэргээн засварлах**

- Архангай аймаг хөтөлбөр хэрэгжсэнээс хойш жилд дунджаар 20-25 худгийг шинээр гаргаж, 10 худгийг сэргээн засварлаж, аймгийн нийт бэлчээрийн 60 гаруй хувийг усаар хангаж, нийт худгийн ашиглалт 85%-д хүрсэн.
- Баян-Өлгий аймаг 17 услалтын систем ба бэлчээрт инженерийн хийцтэй 116 худаг, гар худаг 112, төв суурийн газарт 103 худаг ажиллагаатай байна. Өнгөрсөн онд бэлчээрт улсын төсвийн хөрөнгөөр 5 инженерийн хийцтэй худаг, малчдын санаачилгаар 10 худгийг шинээр гаргасан. 2019 онд худаг сэргээн засварлах ажилд орон нутгийн төсвөөс 7 сая төгрөг хуваарилсан .
- Баянхонгор аймаг Олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд худаг ус шинээр гаргаж сэргээн засаж байна.
- Говь-Алтай аймаг бэлчээрт улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр инженерийн хийцтэй худаг шинээр гарснаар малчдын болон малын усан хангамж нэмэгдэж нийт 40,000 мян.га бэлчээр усжуулагдсан.
- Дархан-Уул аймаг бэлчээрийн усан хангамж сайжруулах чиглэлээр Дархан сумын Малчин багийн Уужим булагт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 15.0 сая төгрөгийн өртөг бүхий 1 худгийг шинээр гарган, мал сүрэг ихээр төвлөрөн өвөлждөг 15 дугаар багт малчдын санаачилгаар 1 худаг сэргээн засварлан малчдад хүлээлгэн өгсөн бол 2018 онд орон нутгийн хөрөнгөөр 35.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 худаг, малчдын санаачилгаар 2 худаг шинээр гаргаад байна.
- Дорнод аймаг Улсын болон орон нутаг төсөв байгаль орчин нөхөн сэргээн зардал, төсөл хөтөлбөрийн 1.517.2 сая төгрөгийн санхүүжилтээр 14 суманд давхацсан тоогоор 68 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг, 38 цооног барьж нийт бэлчээрийн талбайн 6.94 хувь буюу 680.4 мянган га талбай, 518

малчин өрхийн 200 орчим мянган малыг усаар хангасан. Алслагдсан бэлчээрийг ашиглах нөхцөл бүрдсэн.

- Дундговь аймаг 143 энгийн уурхайн худаг сэргээн засварлаж, гүн өрмийн 56 худгийг шинээр гаргаж, 110000 га бэлчээрийг усжуулж, 350 гаруй малчин өрхийн 420000 толгой малыг усаар хангаж аймгийн хэмжээний бэлчээр усжуулалт 3 хувиар нэмэгдсэн.Энгийн уурхай худаг засварлах хөрөнгийг сумдууд орон нутгийн төсөвт тусгаж засварын бригад гаргаж засварладаг.
- Орхон аймаг бэлчээрийн усан хангамж нэмэгдэж, хүн, малын цэвэр усны хэрэгцээ хангагдсан.
- Өмнөговь аймаг орон нутгийн төсвийн хөрөнгөөр жил бүр бэлчээрийг усжуулах арга хэмжээнд 15-30 инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж, 2019 оны 3-р хагасын байдлаар бэлчээрийн усан хангамж 50%-д хүрч байна. 2018 оноос ашиглалтгүй худгуудыг сэргээн засварлах ажлыг эхлүүлэн орон нутгийн төсвөөр 2018 он 28, 2019 онд 30 худгийг сэргээн засварлаж байна.
- Сэлэнгэ аймаг бэлчээрт худаг гаргаснаар ашиглагддаггүй алсын бэлчээр ашиглалт нэмэгдсэн.
- Увс аймаг бэлчээрийн зориулалттай худаг шинээр гаргаснаар бэлчээрийн даац буурах, нөхөн сэлгэж ашиглах боломж нөхцөл бүрдсэн.
- Ховд аймаг Монгол улсын засгийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 39 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын баримт бичгүүдэд тусгагдсаны дагуу 2018 онд хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 04 дугаар сарын 21 –ний өдрийн “Худаг шинээр гаргах тухай” А/172 дугаар Захирамжийн дагуу “Эвлэл” ХК “Түрээсийн гэрээ”-гээр ашиглаж байгаа усны өрөмдлөгийн иж бүрдлийн үлдэгдэл үнэд 74.55 сая төгрөгт шинээр Мөст сумын Баянхайрхан багийн Тавтын Баянбулгийн ам, Манхан сумын Ботгон багийн Бааз, Зэрэг сумын Хөндлөн багийн Дэлийн адаг, Жаргалант сумын Наран багийн 8-р гудамж, Бичигт багийн 10-р гудамжны нийт 5 инженерийн хийцтэй худаг барьж байгуулах ажил хийж улсын комисст хүлээлгэн өгсөн байна
- Хөвсгөл аймаг бэлчээрийн 30 худаг гаргаж, 1500 хүн, 96000 мал усаар хангагдсан.
- Хэнтий аймаг 2016-2019 онд бэлчээрийн усан хангамжид зориулан орон нутгийн төсөв 367.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 40 худаг шинээр гаргаж 100,0 мянган га бэлчээрийн талбай усжуулсан байна.
- Нийслэл орон нутгийн төсвийн санхүүжилтээр 9 худаг гаргасан.

## **5. Хадлан бэлтгэл**

- Архангай аймаг хадлан бэлтгэдэг аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан хамтран ажилладаг болсон.
- Баян-Өлгий аймгийн Засаг даргын захирамжийн дагуу хадлан бэлтгэх төлөвлөгөөг бүх сум 104,5 % давуулан биелүүлсэн болно.
- Говь-Алтай аймаг Засгийн газрын тогтоолын хүрээнд жил бүр аймгийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж ажиллаж байна. Нөөцийн өвс, тэжээл бэлдсэнээр



- мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай давж байна. 2008 онд 678 га-аас 1,997 тн, 2019 онд 831.8 га-аас 2,366 тн хадлан тус тус хурааж авсан.
- Говьсүмбэр аймаг сумын өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэхэд зориулж жил бүр орон нутгийн төсвөөс хөрөнгө гаргаж, орон нутгийн хадлангийн салаанаас бэлтгэсэн өвсийг худалдан авч хамтран ажиллаж байна.
  - Дархан-Уул аймаг мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас жил бүр тогтоол гаргаж хэрэгжилтийг 90 дээш хувиар хангаж ажиллаж байна.
  - Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолын дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 30 тонн өвс 20 тонн малын тэжээлийг тус тус нөөцлөөд байгаа бөгөөд сумын аюулгүйн нөөцөд Дархан сум 50 тонн өвс, 20 тонн малын тэжээл, Хонгор сум 50 тонн өвс, 14 тонн малын тэжээл, Орхон сум 40 тонн өвс, 10 тонн малын тэжээл, Шарын гол сум 50 тонн өвс, 23 тонн малын тэжээл тус тус бэлтгэснээр сумдын түвшинд өвсний нөөц 93 хувь, тэжээлийн нөөц 66 хувьд хүрсэн.
  - Нийт 4 сумын 96 малчин тэжээл авах захиалгаа ирүүлснээс 75 малчин ноосны урамшууллаар 12,5 сая төгрөгөөр 1379 шуудай буюу 35 тонн тэжээл, бэлэн мөнгөөр 4 сумын 44 малчин 1697 шуудай буюу 40,4 тонн малын тэжээл 17,4 сая төгрөгөөр худалдан авсан байна. Оны эхний хээлтэгчээс бойжуулсан төлийн тоог үндэслэн өвөлжих, хаваржих малын тоо, шаардагдах өвс, тэжээлийн хэрэгцээг тооцон 6 дугаар сард сумдад даалгавар болгон хүргүүлж ажилласан. 2018-2019 оны өвөл, хаварт 4 сумын 17 багийн 31 хот айл, 2589 малтай, малчин өрхөд хонин толгойд шилжүүлснээр 616.4 мянган толгой мал өвөлжиж хаваржихаар зохион байгуулалт хийж, нийт 59.1 мянган тонн байгалийн хадлан бэлтгэхээр төлөвлөн, шаардлагатай хадлангийн 80,6 хувь буюу 46880 тонн хадлан бэлтгэсэн. Хонгор сумын 19 малчны хүсэлтээр Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Хонгорын нуруунд 2230 га талбайд байгалийн хадлан бэлтгэсэн байна. Мөн алслагдмал бэлчээр, хадлантай Зэдэр, Нам даваа, Гахайтад Зарим шаардлагатай хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх зорилгоор 302 малчинтай 5787 га талбайд гэрээ байгуулан хадлан бэлтгүүлсэн.
  - Дорноговь аймаг Монгол мал үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.
  - Дорнод аймаг аймгийн ИТХ-аар “Бэлчээр, хадлан, тэжээлийн талаар баримтлах бодлого” батлуулан жил бүр орон нутгийн төсөвт 5,0 сая төгрөг батлуулан, хадлан бэлтгэлд хяналт тавьснаараа зөвшөөрөлгүй, гадны хадлангийн тоо буурсан үзүүлэлттэй байна.
  - Орхон аймгийн хувьд цас зудтай цаг хүндэрсэн үед малчдад өртөг багатай хямд өвс, тэжээлийг хугацаа алдахгүй олгож, малаа өвс тэжээлийн дутагдалд оруулахгүй байлгах нөхцөлийг бүрдүүлж ажиллаж байна.
  - Ховд аймгийн хувьд энэ жил ургацын байдал тааруу, усны түвшин их байгаатай холбоотой 8 дугаар сарын 10-аас эхлэн сумдын малчид хадландаа гарсан. Хадлан, тэжээл бэлтгэхэд нийт дугуйт трактор 449 үүний 363 нь бага



оврын трактор, хадуур 106, тармуур 113, хаман боогч 9 зэрэг багаж техник, төхөөрөмжийг ашигласан байна. Аймгийн хэмжээнд 61,600 тн байгалийн хадлан, 4,000 тн гар тэжээл, 7,756 тн хужир шүү бэлтгэхээс байгалийн хадлан 7,1761 тн, гар тэжээл 2,557 тн, хужир шүү 6,416 тн-ыг бэлтгэж, хадлан 116.4 %, гар тэжээл 63.9%, хужир шүү 82.7 %-ийн биелэлттэй байна. Энэ жилийн хувьд Булган сум газрын гарц сайтай, байгалийн хадланг маш сайн хийж, аймгийн нийт хадлан бэлтгэлийн төлөвлөгөөний 57,8 хувийг бэлтгэсэн дүн мэдээтэй байна.

- Нийслэлд хадлан бэлтгэх талбай байхгүй, бусад аймаг сумдаас бэлтгэдэг

## **6. Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэл**

- Архангай аймаг тэжээлийн ургамлын тариалалт 10 гаруй хувиар нэмэгдсэн.
- Баян-Өлгий аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан. Өлгий Агро ХХК 200 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаж, Алтанцөгц сумын Цонжийн хөдөө гэдэг газар 100 га талбайд малын тэжээл тариалж 185 тн малын тэжээл хураан авсан. Уг тэжээлээр хивэг, багсармал тэжээл үйлдвэрлэж байна. Өнөөдрийн байдлаар 30 тн хивэг үйлдвэрлэж бэлэн болгосон.
- Баянхонгор аймаг тэжээлийн ургамлын тариалалт, ургацын хэмжээ жил дараалан нэмэгдэж байна.
- Дархан-Уул аймаг ҮХААЯ, “Тогтвортой амьжиргаа-2” төсөл, УМЭҮГ-аас хамтран “Мал аж ахуйн эрсдэлийг урьдчилан мэдээлэх тогтолцоо”, “Мал аж ахуйн эрсдэлийг урьдчилан мэдээлэх нь”, “Орон нутгийн малын үржлийн ажил үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх” сэдэвт сургалтуудад 3 мэргэжилтэн хамрууллаа.
- Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар, Нэгдсэн Үндэсний байгууллагын ХХААБ хамтран хэрэгжүүлж буй Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны Техник туслалцаа үзүүлэх төслийн хүрээнд “Малын тэжээлийн ургамал тариалах, технологи”, Хятад улсын таримал тэжээлийн ургамал төрөл зүйл сэдэвт сургалт, танилцах аяллыг зохион байгуулан Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нийт 50 гаруй төлөөлөгчид оролцон УГТЭШХүрээлэнгийн туршилтын талбай, Шинэ орчин трейд ХХКомпаний өвлийн хүлэмж, Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын газар тариалангийн “Бумбат таван толгой” ХХКомпаний үйл ажиллагаатай танилцуулж мөн сургалтаар тэжээлийн үйлдвэрийн талаар Хятад Улсын мэдээллийг үзүүллээ.
- Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар, Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА) хамтран малын тэжээл тариалах туршилтын төслийн хүрээнд 2 га газарт Турк сортын үрийг туршиж тариалсан байна. Хүцэнгэ буюу малын тэжээлийн ургамлын үрийг арвайтай хольж тарьснаар 5-н жил дараалан ургах боломжтой юм. Мөн Дархан сумын “Ган-Алдар” хоршоо нь малын тэжээлийн багсармал болон хорголжин тэжээл үйлдвэрлэх зорилгоор тэжээлийн үйлдвэрийг байгуулж 38,0 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийг суурилуулан үйл ажиллагаагаа эхлээд байна. Үйлдвэрлэл хэвийн үргэлжлэх явцад хоногт 24 тн багсармал тэжээл үйлдвэрлэснээр 15

дугаар багийн малтай иргэдийг хүчит тэжээлээр хангах боломж бүрдэх юм. Энэ онд үр тарианы талбайгаас малын тэжээлийн ургамалд 876.7 га шилжиж 1578.1 тонн ургац, 90 га-д малын тэжээлийн ургамал тариалж 162 тонн ургац тус тус хураан авсан байна. Малчин өрхийн уст цэгээ засварлах, малын хашаа саравчны тохижилт 91 хувь, түлээ түлш бэлтгэл 83.8 хувь, хоол хүнс, дулаан хувцасны хангалт 88.8 хувийн биелэлттэй хангагдаад байна. Мал бүхий 1250 өрхийн 1652 өвөлжөө хашааны 290,6 мянган метр кв талбайд төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх ариутгалыг хийгээд байна. Өвс тэжээлийн бэлтгэл 72,9 хувьтай байна. Орон нутгийн нөөц боломжийг ашиглан лууль, халгай, шарилж, хүнсний ногооны хаягдал зэргээр гар тэжээл, дарш бэлтгэх сургалтыг зохион байгуулж 50 гаруй малчдыг хамруулсан байна. Үүний үр дүнд Хонгор сумын Салхит баг болон сумын төвд 3 газар дарш хийж нөөцлөөд байна. Гар тэжээл, дарш бэлтгэх чиглэлээр гарын авлага зөвлөмжийг 440 гаруй малчинд хүргүүлэн ажиллалаа.

- Дорноговь аймаг Монгол мал үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.
- Дундговь аймгийн хэмжээнд 1 малчин өрх жил бүр 0.5 га талбайд малын тэжээлийн ургамал тариалан жилд 1.5 тн хурааж авдаг. 2019 онд Уур амьсгалын өөрчлөлтөд ухаалгаар дасан зохицох нь төслийн шугамаар Луус сумын Суварга багт 7 малчин өрхийг бүлгийн зохион байгуулалтад оруулж 2 га талбайд малын тэжээлийн ургамал тариалан 1гүн өрмийн худаг шинээр гаргаж нарны цахилгаан үүсгүүрийг суурилуулсан.
- Өмнөговь 2018 онд малчдын түвшин 38 га талбайд тэжээлийн ургамал тариалан 230 тн ургац хураан авсан.
- Сэлэнгэ аймаг ашиг шим үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн.
- Ховд аймаг 2018 оны тариалалтаар 397 га талбайд малын тэжээлийн ургамал тариалж нийт 1708,4 тн ургац хураан авсан байна.
- Нийслэл Иргэд, фермер эрхлэгчдэд 100 га талбайг ашиглалтын гэрээгээр ашиглуулж, ногоон тэжээл тариалж байна.

## **7. Малчдын эрүүл мэнд**

- Архангай аймаг Элэгний эмгэггүй –Архангай хөтөлбөрийг хэрэгжүүлж, бүх малчдыг үзлэг шинжилгээнд хамруулснаар нийт малчдын 15 хувийг эмчилсэн.
- Баян-Өлгий Аймаг орон нутгийн радиогоор “малчдад зөвлөгөө” цуврал нэвтрүүлгээр нийгмийн даатгалыг сурталчилсны үндсэн дээр аймгийн хэмжээнд 950 малчин нийгмийн даатгалд хамрагдсан. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 5,987 малчин ЭМД, 1,233 малчин нийгмийн даатгалд хамрагдсан Аймгийн эрүүл мэндийн газраас нарийн мэргэжлийн эмч нар бүх сумдаар явж “Төлөвлөгөөт бүлэг” хөтөлбөрийн хүрээнд үзлэг хийсэн. Жилд нэг удаа аймгийн нэгдсэн эмнэлгээс “Төлөвлөгөөт бүлэг” хөтөлбөрийн хүрээнд эмч нарын баг гарч бүх сумдын малчдыг үнэ төлбөргүй эрүүл



мэндийн үзлэгт хамруулсан. хийсэн Энэ жил 2,250 малчинд эрүүл мэндийн үзлэг хийсэн байна

- Баянхонгор аймаг орон нутгаас малчдад эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийх ажилд ахиц гарч байна.
- Дархан-Уул аймаг эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Монголын үндэсний олон нийтийн радиогийн захирлын хамтарсан А/13, А/04 тоот тушаалаар “Нийгмийн даатгал Малчин таны төлөө” уралдааны болзлыг сумдын ЗДТГ-т албан тоотоор хүргүүлэн сурталчлан ажиллаж байна. Дархан хотноо Хонгор сумын “Малчдын зөвлөгөөн” зохион байгуулагдаж Эрүүл мэнд нийгмийн даатгал шинэчлэгдсэн хуулийн талаар сурталчлан 96 малчин оролцлоо. Малчдын эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр дээрх хөтөлбөр төслүүдийн хүрээнд холбогдох арга хэмжээг авахын зэрэгцээ нийгмийн даатгалд хамруулах, тэтгэвэр тэтгэмжид хамрагдах нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн байгууллагаас холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулах арга хэмжээ авсан бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн хэрэгжсэнээр аймгийн хэмжээнд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд 2018 онд 4 сумын нийт 755 малчин хамруулсан байна.
- Дорнод аймаг жилд дунджаар 2,037 малчин малын эрүүл мэндийн дэвтэр бөглүүлж, 6.5 сая төгрөгийг зарцуулж байна.
- Дундговь аймаг малчдыг өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд орон нутгийн эмнэлгийн байгууллага малчдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг.
- Ховд аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэр, Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар Эрүүл мэндийн хамтарсан ажлын хэсэг өвөлжилт хүндэрсэн сумдын малчин ард иргэдийг эргэж тойрох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмийн багц тараах ажлын хүрээнд Эрүүл мэндийн газар, БОЭТ-ийн нарийн мэргэжлийн (дотор, хүүхэд, сэтгэцийн) эмч нартай хамтарсан ажлын хэсэг Дөргөн, Чандмань, Дарви, Зэрэг, Манхан, Дуут, Цэцэг, Мөст, Мөнххайрхан, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн сумдад 2018 оны 01 дүгээр сарын 15-30-ны өдрүүдэд ажиллаж малчин иргэдэд эмийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг газар дээр үзүүллээ. Ажилласан сумуудад 3.6 сая төгрөгийн эмийн багцыг 12 сумын 360 малчин өрхөд гардуулан өгсөн. Нэг суманд 30 эмийн багц, Аймгийн 5 өрхийн эрүүл мэндийн төвд харьяалагдах 150 өрхөд нийт 1.5 сая төгрөгийн эмийн тусламж үзүүлжээ. “Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төслийн хүрээнд Ховд аймгийн Чандмань суманд нийт 24.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг гардуулан өгсөн. Үүнд зөөврийн мобайл зүрхний цахилгаан бичлэгийг аппарат, даралтын аппарат, зөөврийн ЭХО аппарат, зөөврийн компьютер, сахар хэмжигч, холестерин хэмжигч, ДОХ, Тэмбүү, Хеликобактер, Гепатит С,В сахар, холестерин тест хуруу шил гэх мэт урвалж бодис, багаж тоног төхөөрөмжөөр хангасан. Энэхүү ажлын хүрээнд Чандмань

сумын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг алслагдсан иргэдэд газар дээр мобайл технологи болох зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар бичлэг хийх, даралтын аппаратаар даралт хэмжих, хэвлийн ЭХО-гоор цуллаг эрхтэнг оношлох, түргэвчилсэн оношлуураар оношлогоо, шинжилгээ хийх, биеийн жин, өндөр үзэх, асуумж судалгаанд нийт 599 хүнийг хамруулсан байна.

## **8. Малчдын боловсрол**

- Архангай аймаг мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулсан (цаг агаарын мэдээ, өвөлжилтийн бэлтгэл, мал онд оролт, бэлчээрийн менежмент гэх мэт).
- Баян-Өлгий аймаг малчдын хүүхдүүдийг ерөнхий боловсрол эзэмших болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцахад нь дотуур байраар бүрэн хангагдсан. Нийтдээ 16,870 малчин сургалт сурталчилгаанд хамрагдаж, арга зүйн зөвлөгөө авсан. Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газраас 6 ахмад мэргэжилтэнг ажиллуулж 1,420 малчинд сургалт явуулсан бөгөөд Мерси кор ОУБ-ын шугамаар 12 сумын 1,356 малчинд сургалт явуулсан.
- Баянхонгор аймаг малчдын дунд сургалт хийгдэж цөөн боловч малчдыг сургууль, дамжаанд хамруулж байна.
- Булган аймаг малчдын мэдлэг мэдээлэл сайжирна. Төлчин эмэгтэйчүүд, 100 аавуудын уулзалтыг зохион байгуулан холбогдох мэдээллийг хүргэж ажилладаг.
- Дархан-Уул аймаг Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Малчдын Улсын нэгдсэн зөвлөгөөн”-д сумдаас 8 малчин мөн Нэгдсэн үндэсний байгууллага ХХААБ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Гангаас улбаатай зудын хүндрэлийг эрсдэл багатай даван туулахад яаралтай тусламж үзүүлэх, чадавхыг сайжруулах” төслөөс Орхон аймагт зохион байгуулагдсан сургалтад сумдын мал зүйч нар болон ХХААГ-ын төлөөллийг хамруулсан байна.
- Мал аж ахуйн салбарт шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийг сурталчлан таниулах, төрөөс малчид, мал аж ахуйн үйлдвэрийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг танилцуулах, малчид, мал аж ахуй эрхлэгчдийн тэргүүн туршлагыг солилцох, тэдний нийгмийн хамгаалал, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, санал санаачилгыг орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх зорилгоор “Малчдын зөвлөгөөн”-ийг 2018 оны 11 дүгээр сарын 08- 09-ний өдрүүдэд 4 сумын 300 гаруй малчид, фермерүүдийг оролцуулан зохион байгуулж, ХХААХҮЯам, МУСҮТөв болон 15 төрийн байгууллагууд оролцож мэдээлэл хийлээ.
- Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, зах зээлийг нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, чанаржуулах ажлын хүрээнд “Гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдаа”-г Хонгор суманд зохион байгуулж, дөрвөн сумын 32 малчин 213 толгой мал, тэжээвэр амьтнаар оролцуулсан байна.
- НҮБ-ын Хүнс , хөдөө аж ахуйн байгууллага , Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Европын холбоо , Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх ” SECIM” төслийн хүрээнд хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай

бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл, сүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх хүрээнд Хонгорын бахархал хоршоотой хамтран Хонгор сумын Зулзагын амралт, Цайдам орчимд сүүний хөргөлтийн төвийг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Хонгор сумын Соёлын төвд “Саальчин эмэгтэйчүүдийн сургалт”-ыг зохион байгууллаа.

- Сургалтаар малчид, фермерүүдэд ХХААГазар, МХГ, ХААН банкнаас мэдээлэл хийж, 53 саальчид хамрагдлаа.
- Хаврын тариалалтын үеэр "Таримал тэжээлийн ургамал тариалах болон жимс, жимсгэнэ, гоёлын бут ургуулах, үржүүлэх технологи" сэдэвт сургалтыг зохион байгуулан 40 гаруй малчид, фермерийг хамруулж, гарын авлага материалаар хангаж ажиллалаа. Аймгийн хэмжээнд 2,503.7 га-д малын тэжээлийн ургамал тариалж 1,950 га-аас 3,529.5 тонн ургац хураан авсан байна.
- Дорноговь аймаг Монгол мал үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.
- Дорнод аймаг малчдын 60 хувь нь тусгай, дунд 30 хувь нь бүрэн дунд, 10 хувь нь дээд боловсролтой байна.
- Дундговь аймаг залуу малчдын амьжиргааг дэмжих аймгийн хөтөлбөрийг боловсруулж батлуулан МСҮТ-д мэргэжлийн малчин ангийг шинээр нээж сургалт явуулж байна. 75 орчим малчдыг сургасан
- Өмнөговь аймаг малчдад чиглэсэн сургалтуудын багийн хурлаар мэдээллэж, "Малчдын зөвлөгөөн" арга хэмжээг 2 жилд 1 удаа зохион байгуулж, малчдаас ирсэн саналыг орон нутгийн бодлого үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж байна. Малчдын эрчимжсэн АА эрхлэх, тэжээлийн ургамал тариалах, өрхийн үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр БНХАУ, Япон, БНСУ зэрэг орнуудад богино хугацааны туршлага судлах сургалт, аяллууд зохион байгуулсан. 2016 оноос хойш малчдын хоршоог хөгжүүлэх, чадавхжуулах сургалтыг баг, нөхөрлөлийн түвшинд хийсний үр дүнд 3 сумын малчдын хоршоо идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Мөн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын шугамаар залуу малчидад чиглэсэн сургалтыг явуулдаг.
- Сэлэнгэ аймаг мал аж ахуйг эрчимжүүлэх, өндөр ашиг шимт мал өсгөн үржүүлэх сонирхолтой болон энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн тоо өссөн
- Ховд аймаг 2018 оны 5 дугаар сарын 21-нд Залуу малчдын аймгийн зөвлөгөөнийг Хүнс хөдөө аж ахуйн газар, аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулж 160 малчин оролцлоо. нийт 20,0 сая төгрөгийн зардал гаргаж 10 шилдэг залуу малчдыг шалгаруулан урамшуулсан. Зөвлөгөөнд Хүнс хөдөө аж ахуйн газар, Ус цаг уур орчны шинжилгээний газар, Нийгмийн даатгал, Политехник коллеж, Мэргэжлийн хяналтын газраас мэдээлэл өгч, SECIM төсөл, Мерси Кор ОУБ-ууд танилцуулга мэдээлэл хийж, малчдад тулгамдаж буй асуудал, малчидтай хамтран ажиллах талаар зөвлөлдөж, зөвлөмж гарган ажиллаа. Аймгийн ХАА-н салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2018 оны 3 дугаар сарын 12,13-нд зохион байгуулсан.

Сумдын МЭҮТ-ийн эмч, мэргэжилтнүүдтэй жил бүр хамтарч ажиллах гуравлсан гэрээ байгуулж, заавар зөвлөмж өгч ажилладаг.

- Нийслэлд Фермер эрхлэгчдэд зориулсан сургалтуудыг хэлтэс, албаны мэргэжилтнүүд хариуцан төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа явуулдаг.

## **9. Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ**

- Архангай аймгийн нийт малчин өрхийн 80 гаруй хувь нь цахилгаан хэрэгсэлтэй, 50 гаруй хувь нь автомашинтай, 10 гаруй хувь нь аймаг, хотод орон сууцтай байна.
- Баян-Өлгий аймаг Малжуулах хөтөлбөрийн хүрээнд 8 сумын 48 малчин өрхийг 4,665 толгой мал буюу 178,000,000 төгрөгөөр малжуулсан байна. Малчдын бүлэг, хоршооны хүрээнд хадгаламж, зээлийн хоршоо байгуулан ихэнх сумдад хэрэгжиж эхэлсэн. Аймгийн хэмжээнд 37 хоршоо байгуулагдан, мал аж ахуй газар, тариалан хосолсон, МАА-н бүтээгдэхүүний борлуулалт, бэлтгэн нийлүүлэх, эсгий эсгийн эдлэл, бэлчээр усжуулах, өөр хоорондоо хөнгөлөлттэй зээл гаргах зорилгоор хамтран үйл ажиллагаа явуулж байна.
- Баянхонгор аймаг Илгээлтийн эзэн хөтөлбөрийн шугамаар жилд 100-с доошгүй малчныг малжуулж байгаагийн дээр цөөнгүй малчныг ажлын байраар хангаж байна.
- Дархан-Уул аймгийн сумдын малчдаас жил бүр зах зээлд нийлүүлж байгаа махны судалгааг авч нэгтгээд байна. Энэ онд тус аймгийн 4 сумын 17 багийн 2362 малчин, мал бүхий өрхөд 2019-2020 онд өвөлжих, хаваржих малын тоо шаардагдах тэжээлийн хэрэгцээ, хадлан тэжээл бэлтгэх даалгаврын тооцон сумдад албан тоотоор хүргүүлээд байна. Ийнхүү хонин толгойд шилжүүлснээр 471,5 мянган толгой мал өвөлжиж, хаваржина. Энэ онд 45,2 мянган тонн байгалийн хадлан, 7 тонн хүчин тэжээл бэлтгэх тооцоо гарсан байна.
- Мөн 4 сумын хэмжээнд энэ онд нийт 26,8 мянган толгой малыг хүнсэнд хэрэгцээлэх, 71,6 мянган толгой малыг зах зээлд худалдан борлуулах урьдчилсан тооцоог гаргаж ХХААХҮЯ-д хүргүүлээ.
- Монгол мал үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.
- Дорнод аймгийн хэмжээнд 2016-2019 онуудад 489 малчин өрхөд бод 212 толгой, бог 21565 толгой нийт 21777 толгой малыг малжуулахаар өгч малчдын амьжиргаа дээшилсэн.
- Дундговь аймаг Залуу малчдын амьжиргааг дэмжих аймгийн хөтөлбөрийг боловсруулж батлуулан МСҮТ-д мэргэжлийн малчин ангийг шинээр нээж сургалт явуулж сургалтад хамрагдсан амьжиргааны түвшин доогуур малчдыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төсөлд хамруулж айл өрхүүдийн амьжиргааг дээшлүүлсэн. 150 орчим малчдыг төсөлд хамруулсан.
- Ховд аймаг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу арьс, шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан (2017 оны сүүлийн хагас жилийн арьс ширний урамшуулал) манай аймгийн 17 сумын нийт 5037 малчин, мал бүхий иргэдийн бодын 17,2 мянган ширхэг, богийн 209,3 мянган

ширхэг, 886,5 сая төгрөгийн арьс ширний баримтыг Мал хамгаалах санд хүргүүлснээс 3,648 өрхийн 467.6 сая төгрөг малчдын дансанд ороход бэлэн болоод байна. 2019 оны 1 дүгээр сарын 15-аас эхлэн 2018 онд үндэсний үйлдвэрт арьс, шир тушаасан малчин, мал бүхий иргэдийн материалыг хүлээн авна. 2017 оны ноосны урамшуулалд 17 сумын 2,837 малчин, мал бүхий иргэдэд 566 сая төгрөгийн урамшуулал 2018 онд олгогдлоо. 2018 оны ноосны урамшуулалд орох 17 сумын малчин мал бүхий иргэдийн 571,1 мянган тн ноосны материалыг Мал хамгаалах санд хүргүүлээд байна. 2018 онд нийт 618.2 тонн ноолуур бэлтгэж зах зээлд нийлүүлсэн. Ноолуурын үнэ 82-105 мянган төгрөгт хүрч малчдын орлого нэмэгдсэн. Сумдын Засаг дарга нартай “Говь” ХХК-тай 2019 онд малчдын бэлтгэсэн ноолуурыг нийлүүлэх гэрээ хийж хамтран ажиллахаар болсон.

- Нийслэл Улсын хэмжээнд хэрэгжиж буй тэмээний ноос, арьс ширний урамшуулалд давхардсан тоогоор 909 өрхөд 208.4 сая төгрөгийн урамшууллын мөнгө олгогдсон байна.

#### **10. Дэд бүтэц (Зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт)**

- Архангай аймгийн нийт малчдын 80 гаруй хувь нь үндэсний үйлдвэрт түүхий эдээ нийлүүлж урамшуулалд хамрагдаж байна.
- Баян-Өлгийн аймгийн хэмжээнд бүртгэлтэй 12 мал нядлах, мах боловсруулах үйлдвэртэй байна. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журмын шаардлагын хангаж мах экспортлох зөвшөөрөл авахаар Ет транзит болон Зергер интернешнл” ХХК-үүд материалаа бүрдүүлж 400 тн мах экспортлох хүсэлтээ гарган ХХААХҮЯамд хүргүүлж зөвшөөрөл авсан байна. Мал сүргийг эрүүл байлгах, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар аймгийн хэмжээний стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулж, энэ хүрээнд ажил зохион байгуулж байна. 2017 онд Нөхөд, Угур, Ет транзит, Акбоар мал нядлах үйлдвэрүүд 1760 тн мах бэлтгэсэн. Азат ХХК мал нядлах, мах боловсруулах үйлдвэрээ барьж байна. Тус компани малын дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулж, савлан үйлдвэрлэж байна. Мах боловсруулах үйлдвэрүүд шинээр баригдаж, мах боловсруулалт өмнөх оныхоос 2 ахин нэмэгдэж байна. Эдгээр үйлдвэрүүд бэлтгэсэн махыг Хятад, Казахстан улсад гаргахаас гадна Зергер интернешнл ХХК Иранд хонины мах гаргах юм.
- Баянхонгор аймгийн зарим суманд арьс нэхий боловсруулах, эсгий хийх, мал нядлах зэрэг үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна.
- Дархан-Уул аймагт жилдээ аймгийн хэмжээний нийт малын 8 хувь буюу 24 мянган толгой малыг хүнсэнд хэрэглэдэг бол 15-20 хувь буюу 40-60 мянган толгой малыг малчид зах зээлд худалдан борлуулж байгаа тооцоо гарсан байна.
- Тэгвэл энэ оноос туршилтын шугамаар "Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгөх тогтолцооны загвар арга хэмжээ"-ний эхлэл болгож, ХХААХҮЯ, Монголын махны холбоо, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Швейцарын хөгжлийн агентлагийн "Ногоон

алт, малын эрүүл мэнд" төсөл, долоон мах төхөөрөх болон боловсруулах үйлдвэрийн төлөөлөл бүхий ажлын хэсэг Дархан-Уул аймгийн "Дархан meat фүүдс" ХХК дээр сургалт зохион байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд "Дархан meat фүүдс" ХХК-ийн мах боловсруулахад тавигдаж байгаа шалгуур үзүүлэлт нь ээмгийг махны үйлдвэрт зураасан код болгох, тоног төхөөрөмж, програм хангамжийн сургалт хийгдлээ. Цаашид аймгийн ХХААГ-аас сумдын МЭҮТ дээр хүнсний хэрэгцээнд нядлах малын захиалгыг 4 сумын малчдаас авч эрүүл мэндийн үзлэгт хамруулан ээмэгжүүлэн бүртгэлжүүлснээр эрүүл аюулгүй хүнсийг хэрэглэгчдэд нийлүүлэх чиглэлээр зөвлөмж өгсөн.

- Ховд аймаг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу арьс, шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан (2017 оны сүүлийн хагас жилийн арьс ширний урамшуулал) манай аймгийн 17 сумын нийт 5037 малчин, мал бүхий иргэдийн бодын 17,2 мянган ширхэг, богийн 209,3 мянган ширхэг, 886,5 сая төгрөгийн арьс ширний баримтыг Мал хамгаалах санд хүргүүлснээс 3648 өрхийн 467,6 сая төгрөг малчдын дансанд ороход бэлэн болоод байна. 2019 оны 1 дүгээр сарын 15-аас эхлэн 2018 онд үндэсний үйлдвэрт арьс, шир тушаасан малчин, мал бүхий иргэдийн материалыг хүлээн авна. 2017 оны ноосны урамшуулалд 17 сумын 2837 малчин, мал бүхий иргэдэд 566,0 сая төгрөгийн урамшуулал 2018 онд олгогдлоо. 2018 оны ноосны урамшуулалд орох 17 сумын малчин мал бүхий иргэдийн 571,1 мянган тн ноосны материалыг Мал хамгаалах санд хүргүүлээд байна. 2018 онд нийт 618,2 тн ноолуур бэлтгэж зах зээлд нийлүүлсэн. Ноолуурын үнэ 82,0-105,0 мянган төгрөгт хүрч малчдын орлого нэмэгдсэн. Сумдын Засаг дарга нартай "Говь" ХХК-тай 2019 онд малчдын бэлтгэсэн ноолуурыг нийлүүлэх гэрээ хийж хамтран ажиллахаар боллоо. "Ховд хаан бирж" ХХК 6.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, хоногт 15-25 тн ноос ноолуурт анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрийн барилгын ажлыг дуусгаж, цэвэрлэх байгууламж баригдах ажил хүлээгдэж байна. Үүний үр дүнд малын гаралтай түүхий эдийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 70-80 ажлын байр бий болгох боломжтой. 2018 онд 11,825,0 сая төгрөгийн өртгөөр барихаар шийдвэрлэсэн. Арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн хоногт -8,000 м<sup>3</sup> цэвэрлэсэн ус үйлдвэрлэх үйлдвэр байгуулахаар энэ оны төсөвт 710.0 сая төгрөг тусгагдаж тендер зарлагдаж түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зураг төслийг боловсруулан "Саруул цамхаг" ХХК шалгарч цахилгааны дэд өртөө хашаа гражны ажил хийгдэж байна. "Ноолуур" хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮ-ийн яамнаас зарласан тендерт оролцож Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр байгуулахаар Алтайн сүрлэг пирамид ХХК ны 650,0 сая төгрөгийн төсөл шалгарч Хөгжлийн банкнаас олгохоор шийдвэрлэсэн боловч санхүүжилт нь хүлээгдэж байна.
- Нийслэл Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Нийслэлийн баруун, зүүн хэсэгт мал, мах боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж байна. МБҮ трейд ХХК хариуцан гүйцэтгэж байгаа.



## **11. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид**

- Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 12 жижиг ферм, 20-оос дээш үнээтэй 12 ферм, Гүүний 8 ферм, ингэний 3 ферм үйл ажиллагаагаа явуулж аймгийн төвийн иргэдийг сүү, цагаан идээ, өндгөөр зохих хэмжээгээр хангаж байна. Одоогоор нийт сүүний хэрэгцээний 78.3%-ийг дотооддоо хангаж байна. Фермер эрхлэгчдийг мэргэжлийн арга зүйгээр ханган хамтран ажиллаж байна.
- Булган аймгийн зүгээс эрчимжсэн мал аж ахуй эрхлэх малчдад сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл өгсөн.
- Говьсүмбэр аймгийн эрчимжсэн мал аж ахуйн суурьшлын бүсийг тогтоож инженерийн хийцтэй 2 худгийг орон нутгийн төсвөөр гаргасан.
- Дорнод аймагт мах-сүүний чиглэлийн 21 ферм үйл ажиллагаа явуулж, 28 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, аймгийн хэмжээнд 7999.8 тн хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэгцээтэй бөгөөд фермерийн аж ахуйгаас зах зээлд 2134,1 тн сүү нийлүүлж, хүн амын сүүний хэрэгцээний 26,7 хувийг хангаж байна.
- Дундговь аймаг мах сүүний үхрийн аж ахуйг хөгжүүлэх төслүүдийг олгож төв суурин газрын ард иргэдийн мах сүүний хангамжийг нэмэгдүүлсэн.
- Орхон аймаг фермерийн аж ахуй эрхлэгчид малын дулаан хашаа барихад санхүүгийн дэмжлэг болдог.
- Сэлэнгэ аймаг Мал аж ахуйг эрчимжүүлэх, өндөр ашиг шимт мал өсгөн үржүүлэх сонирхолтой болон энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн тоо өссөн
- Ховд аймаг Булган, Буянт, Манхан, Жаргалант сумдад эрчимжсэн мал аж ахуйн бүс нутагт махны, мах- сүүний, сүүний чиглэлийн үхрийн 12, эрчимжсэн аж ахуй эрхэлдэг нийт 19 иргэн, аж ахуйн нэгж байна. Эдгээр аж ахуйн нэгж, иргэдийн 57.8 хувь нь Жаргалант суманд үйл ажиллагаа эрхэлж аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг хангаж байна.
- Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/592 дугаар Захирамж, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 21/06 дугаар тогтоолоор мал аж ахуй эрхлэх бүс нутгийг нэмэгдүүлж, аж ахуй эрхлэх чиглэлээр нь төрөлжүүлэн хөгжүүлж байна.

### **3.2.2 Хүлээгдэж байсан үр дүнд хүрсэн эсэх (Шалгуур үзүүлэлтээр)**

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны явцад хөндлөнгийн үнэлгээ өгөхөд уг хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүдийг үндэс болгосон. Өөрөөр хэлбэл, 2016-2018 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтүүдийн 2021 онд хүрэх түвшинтэй харьцуулж, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ өгсөн.



## 1-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт

**Хүснэгт 5.** “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 1-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2008 оны түвшин	Хүрэх түвшин		
			2012 он	2015 он	2021 он
1.1 Мал аж ахуйн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	-	-
1.2 Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг бэхжүүлэх: - Төрийн үйлчилгээний алба - Хувийн хэвшлийн үйлчилгээний нэгж шинээр	Тоо Тоо	0 751	338 60	- 75	- 135
1.3 Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх: - Шинээр бэлтгэх, давтан сургах мэргэжилтэн - Малчны түр сургууль төгсөгчид	Тоо Тоо	104 25	1,272 6,800	1,908 10,200	2,120 17,000

Эх сурвалж: УИХ (2010)

**1.1 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд** тус хөтөлбөрийн 2016-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 17 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Доорх хүснэгтэнд тус 1.1 дүгээр шалгуур үзүүлэлтийн үнэлгээг харуулав.

**Хүснэгт 6.** “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 1.1 дүгээр шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

№	Үйл ажиллагаа	Хугацаа он	Хэрэгжилт / Тайлбар	Өгсөн үнэлгээ
1	Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх	2016-2018	2017 оны 12 сарын 14-д батлагдсан.	100.0
2	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх	2016-2017	2017 оны 12 сарын 8-д батлагдсан.	100.0
3	Бэлчээрийг хамгаалах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх	2016-2017	Хөтөлбөрийн хэрэгжилтийн 2016 оны тайланд "Бэлчээрийг хамгаалах тухай" хуулийн төслийг эргүүлэн татаж, "Отрын бэлчээрийг хамгаалах тухай хууль" -ийн төсөл болгон өөрчлөхөөр тусгагдсан ба 2017 оны 3 улиралд багтаан хийхээр төлөвлөсөн, харин 2017 оны тайланд Бэлчээрийг хамгаалах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов гэсэн хэдий ч 2018 оны тайланд дурдаагүй байна.	0.0
4	Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж хэлэлцүүлэх	2017-2020	2016-2018 онуудад хэрэгжүүлээгүй байна. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа 2020 он гэсэн учир үнэлгээнд оруулалгүй орхисон.	
5	Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн заагийг тогтоох эрх зүйг бүрдүүлэх	2017-2018	Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн заагийг тогтоох эрх зүйн орчин дараах арга хэмжээнүүдийн хүрээнд үүссэн байна. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөр, Тариалангийн зарим бүс нутаг тогтоох тухай тогтоол	80.0
6	Мал аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд төрөөс урамшуулал олгох системийг боловсронгуй болгох, эрх зүйн орчинг бүрдүүлэх	2017-2020	“Үндэсний үйлдвэрлэгчийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоол, “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолыг үндэслэн батлагдсан үндэсний үйлдвэрт тушаасан түүхий эдийн бэлтгэлд урамшуулах журмаас хойш эрх зүйн боловсронгуй болгох, бүрдүүлэх чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулаагүй болох 2016-2018 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харагдаж байна. Гэхдээ энэхүү үйл ажиллагаа нь 2020 онд дуусна.	50.0
7	Газрын тухай, Газрын төлбөрийн тухай хуульд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалттай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах, хэлэлцүүлэх	2017-2018	2016-2018 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд энэхүү үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн мэдээлэл байхгүй байна	0.0
8	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Мал хамгаалах	2016-2017	2016-2018 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд энэхүү үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн мэдээлэл байхгүй байна	0.0



	сангийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах, хэлэлцүүлэх			
9	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2016-2017	2017 оны 12 сарын 14-д батлагдсан.	100.0
10	Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2017-2018	2016-2018 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд энэхүү үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн мэдээлэл байхгүй байна	0.0
11	Малын үржлийн ажил, үйлчилгээний стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах	2016-2017	Сайдын тушаалаар Малын үржлийн ажил, үйлчилгээний стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	50.0
12	"Бэлчээр тэжээл", "Тэмээ" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	2017-2021	Эхний шатанд тусгагдсан Тэмээ дэд хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн 2 дахь шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн байна. Аймгийн Засаг дарга 2014 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн байна.	100.0
13	Мал аж ахуйн салбарт шинээр батлагдсан хуульд нийцүүлэн холбогдох журам, заавар, стандарт, стратегийн баримт бичгийн төслийг шинэчлэн боловсруулж батлуулах	2016-2017	Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлуулах 6 эрхзүйн баримт бичгээс 1 журам, 2 жагсаалт батлагдаж, 1 журам, 2 чиглэлийг батлуулахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар батлуулах 24 эрхзүйн баримт бичгээс 8 журам, 1 жагсаалт батлагдаж, 8 журмыг батлуулахаар оруулж, 4 журам, 3 төлөвлөгөөг боловсруулж байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргаар батлуулах 87 эрхзүйн баримт бичгээс 2 журам, 3 нийтээр дагах заавар, 1 дүрэм, 1 стандарт, 67 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар, 1 төлөвлөгөө, нийт 75 эрх зүйн баримт бичгийг батлуулсан байна.	70.0
14	Мал, амьтны эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх	2016-2017	2016-2018 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад энэхүү үйл ажиллагааг эдийн засгийн орчин бүрдсэн харагдаж байна.	80.0
15	Төрийн хяналт шалгалтын тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2016-2017	"Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийг дагалдан гарах Төрийн хяналт шалгалтын тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиудын төслийг боловсруулан, үзэл баримтлалын төслийг Хууль зүй дотоод хэргийн сайдаар батлуулахаар хүргүүлэв.	100.0
16	Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийг хянах үндэсний хөтөлбөр боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах	2016-2017	"Малын эмийн үлдэгдлийн хяналтын хөтөлбөр"-ийг боловсруулах ажлын хэсгийг 2016 онд байгуулсан, хөтөлбөрийн төслийг "Хууль тогтоомжийн тухай хууль", "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль"-ийн дагуу боловсруулсан байна. Хөтөлбөрийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	50.0
17	Малаас хүнд дамжин халдварладаг бруцеллөз өвчнийг мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтанд оруулахад шаардлагатай хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэх	2016-2017	Мал зүйч мэргэжлийг хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамруулах зорилгоор ажлын байрны нөхцөлд судалгаа, үнэлгээ хийлгэх саналаа хүргүүлээд байна.	60.0
<b>Дундаж үнэлгээ</b>				<b>58.8</b>

Эх сурвалж: ХХААХҮЯ (2017-2019)

Дээрх хүснэгтээс харахад дундаж үнэлгээ 58.8%-тай гарсан байна.

**1.2 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд 2021 он гэхэд хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг 2008 онтой харьцуулахад 270 нэгжээр нэмэгдүүлж, 2021 онд 1021 хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (МЭҮН) бий болгох шалгуур үзүүлэлт тавьсан. 2018 оны байдлаар 1,006 МЭҮН үйл**

ажиллагаа явуулж байна. Энэ нь 2021 оны зорилтот түвшнийхээ 98.5 хувьд хүрснийг харуулж байна.

### 1.3 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд:

- Шинээр бэлтгэсэн болон давтан сургасан мэргэжилтний тоо 2016-2018 оны хооронд давхардсан тоогоор 229 хүн болж, 2021 оны зорилтот түвшний 10.8%-д хүрсэн байна.
- Түр сургалтад хамрагдсан малчдын тоо 2016-2018 оны хооронд давхардсан тоогоор 3942 болж, 2021 оны зорилтот түвшний 23.2%-тай тэнцэж байна.

### 2-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт

Тус шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ХХААХҮЯ (2017-2019)-ны тус хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас дор авч орууллаа.

### Хүснэгт 7. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2008 оны түвшин	Хүрэх түвшин		
			2012 он	2015 он	2021 он
2.1 Малын удмын санг хамгаалах ажлын хүрээнд: - Малын удмын сангийн үндэсний цогцолбор - Бүсүүдэд байгуулагдах мал үржүүлэг, биотехнологийн салбар - Зохиомлоор хээлтүүлэх мал	Тоо Тоо Тоо	0 0 3,200	1 3 16,000	- 2 24,000	- - 120,000
2.2.Дотооддоо үйлдвэрлэх, импортоор авах үржүүлгийн бүтээгдэхүүн: - Дотооддоо үйлдвэрлэх үр, хөврөл үр - Импортлох үр, хөврөл үр	Тоо Тоо	21,000 7,000	24,000 20,000	60,000 30,000	195,000 -
2.3.Оны эхний малын тоо. Үүнээс төрөл тус бүрээр: - Тэмээ - Адуу - Үхэр - Хонь - Ямаа	Мян.тол Хувь Хувь Хувь Хувь Хувь	43,288 0.6 5.1 5.8 42.4 46.1	33,343.4 0.8 6.4 7.7 44.9 40.2	35,298.9 0.8 6.8 9.6 45.4 37.4	36,475.6 0.9 8.2 13.8 45.1 32.0
2.4.Нэг малаас авах ашиг шим: - Цэвэр, эрлийз үнээний сүү - Ноолуур - Нарийн, нарийвтар ноос - Бүдүүн, бүдүүвтэр ноос	305 хоног/ кг грамм кг кг	1,769 290 3.9 1.1	2,217 290 4.1 1.2	2,673 300 4.4 1.3	3,200 310 4.9 1.5
2.5.Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох: - Сүлжээнд хамрагдах нэгж - Бүртгэлжүүлэх мал, өссөн дүнгээр	тоо хувь	0 0.3	338 40	- 60	- 80

Эх сурвалж: УИХ (2010)

2 дугаар шалгуур үзүүлэлттэй холбоотой дараах үзүүлэлтүүдийг 2016, 2017, 2018 оны “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны ажлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаас авч үнэлсэн.

Зарим шалгуур үзүүлэлтүүдийн хувьд мэдээлэл байхгүй байсан тул үнэлэх боломжгүй байна. (2.4 дүгээр шалгуур үзүүлэлт)

## 2.1 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд:

- Малын удмын санг хамгаалах зорилтын хүрээнд 2018 оны байдлаар Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Малын удмын сангийн үндэсний цогцолборыг байгуулж, ашиглалтанд оруулснаар 2021 оны хүрэх түвшиндээ 100% хүрсэн байна.
- Мал үржүүлэг, биотехнологийн 5 салбарыг бүсүүдэд байгуулах ажлын хувьд 2018 оны байдлаар орон нутагт байрлах 11 цөм сүргийн үржлийн төв ажиллаж байгаа нь зорилтдоо 100% хүрсэн байгааг харуулж байна.
- Зохиомол хээлтүүлгийн ажлын хүрээнд
  - Малын удмын сангийн үндэсний төв дээр БНЧех улсын Хөгжлийн агентлагаас 2014-2016 онд хэрэгжсэн “Монгол улсад үхрийн зохиомол хээлтүүлгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд төвийн бүсийн орчмын 10 хээлтүүлгийн суурин цэг, 60 үржүүлгийн техникч нарыг шаардлагатай багаж, төхөөрөмжөөр ханган орон нутгийн зохиомол хээлтүүлгийн салбаруудын чадавхыг сайжруулах арга хэмжээ авсан. Мөн түүнчлэн 2016 онд 9 аймаг, нийслэлд 26 мал үржүүлгийн техникч бод зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг, 8 аймаг, нийслэлд 10 техникч бог малд зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг эрхлэн 2,385 толгой үнээ, 2521 толгой эм хонь, 96 толгой эм ямаа, нийт 5,002 толгой малыг зохиомлоор хээлтүүлэн, мал үржүүлэгчдийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллалаа.
  - “Мах, сүүний анхдугаар аян”-ы үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд “Малын зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг өргөжүүлэх аян”-ыг улсын хэмжээнд 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс зарлан Монгол улсын үржлийн ажлын стратегид нийцүүлэн зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг зохион байгууллаа. Энэхүү аяны хүрээнд Мал эмнэлэг, үржлийн газрын даргын тушаалаар 9.1 сая төгрөгийг зохиомол хээлтүүлгийн техникчдийн орон нутагт ажиллах зардлыг санхүүжүүлэн, дэмжлэг үзүүлснээр 21 аймаг, нийслэлийн мал бүхий иргэд, аж ахуйн нэгжид хүрч, үйлчилгээг үзүүлэх мэргэжлийн шилдэг баг-мал зүйчид, үржүүлгийн техникчдийг орон нутаг руу томилон ажиллуулан эдгээр техникчдийг орон нутагт ажиллах бололцоогоор хангаж, генийн санд хадгалагдаж байгаа үржлийн үнэт чанар нь олон улсын түвшинд үнэлэгдсэн сүүний, мах-сүүний хосолмол, махны чиглэлийн өндөр ашиг шимт чанарын бухын гүн хөлдөөсөн үр, холбогдох багаж, хэрэгсэл, шингэн азотоор ханган ажиллалаа. 2017 онд 19 аймаг, нийслэлд 21 мал үржүүлгийн техникч ажиллаж, 2,100 толгой үнээ, 933 толгой бог малын хээлтэгч, нийт 3,033 толгой хээлтэгч малыг зохиомлоор хээлтүүллээ.
  - 2018 онд 4 аймаг, нийслэлийн 8 мал үржүүлгийн техникч нартай гэрээ байгуулан ажиллаж байна. Үржүүлгийн техникчийн мэдээгээр нийт 3,874 толгой малаас 1321 тоо толгой үнээ, 1,380 тоо толгой хонь, гүн хөлдөөсөн болон шингэлсэн үрээр 1,173 тоо толгой ямаанд хээлтүүлэг хийж 8 мал үржүүлгийн техникчийн 500 толгой үнээнд хээлийн шалгалтын ажил хийж хээл авалт 83% -тай байна.

2016-2018 онд нийт 5,806 толгой үнээ, 6,103 толгой бог малын хээлтэгч, нийт 11,909 толгой хээлтэгч малыг зохиомлоор хээлтүүлсэн нь 2021 оны зорилтот түвшний 9.9%-ийг гүйцэтгээд байна.

## 2.2 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд:

- Дотооддоо үйлдвэрлэсэн үр, хөврөл 2009-2018 онд нийт 95,133 тун үр, хөврөл дотоодод үйлдвэрлэсэн нь зорилтот түвшний 48.8%-ийн гүйцэтгэлтэй байна.

### Зураг 8. Дотоодод үйлдвэрлэсэн малын үр, хөврөл (тун)



Эх сурвалж: ХХААХҮЯ (2017, 2019) ММҮХ-ийн 2016, 2018 оны ХШҮ-ний тайлан

- Импортлох үр, хөврөлийн хувьд 2016-2018 оны гүйцэтгэлийг авч үзвэл 2016 онд 2000 тун үр, хөврөл импортолсон ба 2017, 2018 онд импортлоогүй байна.

**2.3 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд:** 2021 оны зорилтот түвшинд оны эхний малын тоо 36.5 сая толгой байхаар төлөвлөсөн боловч 2018 оны эцсийн малын тоо 66.5 сая толгой болж өссөн. 2008 онтой харьцуулахад малын тоог 15.7%-иар бууруулах шалгуур үзүүлэлт тавьсан боловч эсэргээрээ малын тоо өссөн. Тиймээс тус шалгуур үзүүлэлтийн биелэлт 0% гэж үнэлэгдлээ.

Малын тоог бүтцээр нь авч үзвэл 2018 оны тэмээний тоо толгой зорилтот түвшин буюу 2021 оны дүнгээс 0.2 пунктээр, адуу 2.3 пунктээр, үхэр 7.2 пунктээр тус тус бага бол хонь 0.9 пунктээр, ямаа 7.2 пунктээр өндөр байна (ҮСХ 2018).

**2.4 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд:** Малын ашиг шим, мах, сүү, ноос, ноолуурын гарцыг тусгай судалгаагаар судлан гарган шаардлагатай. ХХААХҮЯ (2017-2019)-ны “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн ХШҮ-ний тайланд тус шалгуур үзүүлэлтийг үнэлээгүй байна. Гэвч бидний үнэлгээгээр тус шалгуур үзүүлэлтийн биелэлт 91% байна.

## 2.5 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд:

- Сүлжээнд хамрагдах нэгжийн тухайд авч үзвэл 2018 оны 2 улирлын байдлаар сард дунджаар 150-180 аж ахуй нэгж, иргэдийн 1500-2000 тоо толгой үнээний бүрэн бүртгэлийг сар бүр мэдээллийн санд оруулж, мэдээллийн санг нийт 11546 тоон мэдээллээр баяжуулж, шинээр 36 аж ахуй нэгж, иргэний 505 толгой сүүний үхрийг бүртгэлд хамруулан аж ахуй нэгж, иргэдийг эргэх

тайлан мэдээгээр тогтмол хангаж байна. Монгол улсын сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд 13 мал үржүүлгийн тоо бүртгэгчтэй гэрээ байгуулан, тоо бүртгэгчдэд анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгч, бүртгэлийн ажлыг явуулж байна.

- Хөтөлбөрийн бүртгэл мэдээллийн санд бүртгэжүүлэх ажлын хүрээн малын үржүүлэг технологийн календарьчилсан төлөвлөгөөний дагуу бог малын хээлтүүлэгчийн 90%, бод малын хээлтүүлэгчийн 30%, баталгаажсан үүлдэр, омгийн малын 80 хувь, цөм болон үржлийн сүргийн шаардлага хангасан 90.1 мянган малыг тус тус ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг гүйцэтгээд байна. 2017 оны байдлаар нийт малын 13.1%-ийг буюу 8,688,218 толгой малыг ээмэгжүүлэн бүртгэсэн, 2018 онд 100,500 толгой мал, нийт 8,788,718 толгой мал бүртгэлжүүлсэн нь нийт мал сүргийн 13.2% болж байна. 2021 онд нийт мал сүргийн 80%-ийг бүртгэлжүүлнэ гэсэн шалгуур тавьсан боловч энэ үзүүлэлт 2018 оны байдлаар 16.5%-ийн биелэлттэй байна.

### *3-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт*

Тус шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ХХААХҮЯ (2017-2019)-ны тус хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас дор авч орууллаа.

**3.1 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд** Монгол улс үхрийн цээж, хонь, ямааны цэцэг, үхрийн тархины эд сархиатах өвчнөөр тайван, өвчингүй статусыг ДМАЭМБ-аас авах шалгуур үзүүлэлт тавьсан. Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлжсэн болохыг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулах ажлыг 2018 онд эхлүүлж, 2021 онд баталгаажуулахаар төлөвлөн Мал эмнэлгийн хүрээлэнтэй “Монгол улс үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлжсэн болохыг баталгаажуулах” ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх МЭЭГ2018/АГ-05 дугаартай гэрээг байгуулж, шинжилгээний ажлыг эхлүүлээд байна. 2016-2018 онуудын “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас үзэхэд шүлхий, хонь, ямааны цэцэг өвчний гаралт тохиолдсон нь зорилтот түвшинд хүрэхэд сөргөөр нөлөөлнө. Тус хөтөлбөрийн 2-р үе шатны төгсгөл буюу 2021 онд хүрэх тус шалгуур үзүүлэлтийн 2018 оны биелэлтийг 50%-иар үнэлэв.

**3.2 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** малыг үхэр, тэмээг бруцеллёз өвчнөөс, адууг ям өвчнөөс, адууг халдварт цус багасах өвчнөөс, сүүний үхрийг лейкоз өвчнөөс, бог малыг бруцеллёз өвчнөөс эрүүлжүүлэх, бруцеллёзоос тайван бус нийт малчин өрхийн хувь хэмжээг бууруулах шалгуур үзүүлэлт тавьсан.

- Үхэр, тэмээг бруцеллёз өвчнөөс эрүүлжүүлэх: ХХАА-н сайдын 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А-154 дугаар тушаалаар баталгаажсан “Бруцеллёзтой тэмцэх стратеги”-ийн дагуу 2017 оноос хойш бруцеллёз өвчнөөс эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ нь 2021 оны зорилтот түвшинд хүрэхэд чухал юм. 2018 онд бруцеллёзын ийлдэс судлалын

шинжилгээнд нийт 242350 дээж шинжлэгдсэн ба буурны 0.53% (11/279), бухын 0.55% (141/25453), хуцны 0.34% (396/117816), ухны 0.31% (304/97030) -д нь тус тус эерэг, эсрэг бием илэрсэн байна. Нийт шинжилгээнд хамрагдсан бухын 0.55 хувьд, буурны 0.53 хувьд илэрсэн нь 2021 оны зорилтот түвшин буюу 100 хувь эрүүлжүүлэхэд нэг алхам ойртож байна.

- Адууг ям ба халдварт цус багасах өвчнөөс эрүүлжүүлэх: Энэхүү шалгуурын үзүүлэлтийн 2021 оны зорилтот түвшин (100 хувь эрүүлжүүлэх) -тэй одоогийн түвшинг харьцуулж үнэлэхэд хүндрэлтэй байна. Учир нь 2016-2018 хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд уг шалгуурын үзүүлэлтийн өнөөгийн байдлын талаар мэдээлэл байхгүй байна.
- Сүүний үхрийг лейкоз өвчнөөс эрүүлжүүлэх: 2017 онд үйлдвэрлэсэн үрийг бүрэн шинжилгээнд хамруулахад лейкоз (-) буюу сөрөг урвалтай илэрч, нянгийн ерөнхий бохирдолгүй гарсан 2021 оны зорилтот түвшинд хүрэхэд нэг алхам ойртсоныг илтгэж байна.
- Бог малыг бруцеллэз өвчнөөс эрүүлжүүлэх: Бруцеллэзтой тэмцэх арга хэмжээг 2010 оноос хойш нилээд эрчимжүүлж, уг өвчинтэй тэмцэх ажлын хүрээнд малын эрүүлжилтийг хяналтандаа авахын тулд уг өвчнөөр өвчлөмтгий бүх малыг вакцинжуулалтад хамруулах зорилт дэвшүүлэн, жил бүр тодорхой тооны мал сүргийг хамруулан масс вакцинжуулалтын ажлыг зохион байгуулсан байна. Энэ хүрээнд 2016 онд 13.4 сая малыг вакцинжуулалтад хамруулсан. Мөн 2014 оноос эхлэн охин тугал, богийн төлийг хүйс харгалзахгүй вакцинжуулах ажлыг эхлүүлсэн байна. Малын хээл хаялтад нөлөөлдөг өвчний шинжилгээг Хэнтий, Дорнод, Дундговь, Говь-Алтай, Увс, Завхан, Архангай аймгийн 48 сум хамрагдсанаас Хэнтий аймгийн 5, Дорнодын 3, Дундговийн 9, Говь-Алтайн 6, Увсын 4, Завханы 16, Архангайн 6 сумын 133 малчин өрхийн 2154 толгой малын нийт 2888 ширхэг сорьцонд шинжилгээ хийсэн байна. Шинжилгээгээр бруцеллэз өвчтэй 137 толгой мал буюу шинжлэгдсэн малын 6.3 хувьд өвчний сэжиг илэрсэн 2021 онд тухайн өвчнөөс мал сүргийг 100 хувь эрүүлжүүлэхийн тулд онцгой анхаарч ажиллах ёстойг илтгэж байна.
- Бруцеллэзоос тайван бус нийт малчин өрхийн хувь хэмжээг бууруулах: Үнэлгээ хийхэд ашиглах мэдээлэл бүрэн бус байна.

**3.3 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** малын гоц халдварт өвчний дэгдэлт гараагүй байх шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзэхэд 2016-2018 оны хооронд авч үзэхэд хонины цэцэг өвчний хувьд 2016 онд 24,398 толгой мал, шүлхий өвчний хувьд 173 толгой үхэр, бог малын мялзан өвчний хувьд 2016 онд 83,906 толгой мал, ямааны цэцэг өвчний хувьд 249 толгой ямааг зориудаар устгасан, 7 толгой ямаа хорогдсон байна. 2017 онд Манай оронд өнгөрсөн онд шүлхий, хонь, ямааны цэцэг, бог малын мялзан өвчин дахин бүртгэгдсэнээс шүлхий өвчин өнөөдрийн байдлаар дэгдэлт хэлбэрээр үргэлжилж байна. Өнгөрсөн 2016 онд шүлхий шүлхий 2 аймгийн 4 суманд оношлогдсон, 2017 онд 9 аймгийн 44 суманд бүртгэгдсэн, хонины цэцэг өвчин 37 бүртгэгдсэн, бог малын мялзан өвчин 2017 онд зэрлэг амьтанд 11, гэрийн тэжээвэр малд 4 удаагийн тохиолдол оношлогдсон, шүлхий өвчин Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд 1 сард бүртгэгдсэнээс хойш Сүхбаатар, Дорнод,



Хэнтий, Дорноговь, Төв, Дундговь, Сэлэнгэ аймгийн нийт 41 сум, нийслэлийн нэг дүүрэгт шүлхий өвчин оношлогдсон байна. 2018 онд хонины цэцэг өвчний гаралт нэг тохиолдол бүртгэгдсэн, бог малын мялзан өвчин 5 тохиолдол бүртгэгдсэн, 61 тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ бүгдээс үзэхэд малын гоц халдварт өвчний дэгдэлт гараагүй байхын тулд илүү онцгой анхаарч ажиллах ёстой байна.

**3.4 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд** сум, дүүрэгт мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн магадлан шинжилгээ хийх чадавхтай болох, **3.5 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** малын өвчний оношлогооны явуулын үйлчилгээ бий болгох шалгуур үзүүлэлтийг хөтөлбөрийн II шатны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд оруулаагүй болно.

**3.6 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** малын эм, биобэлдмэлийг дотооддоо үйлдвэрлэх шалгуур үзүүлэлт тавьсан. Тус шалгуурын хангахын тулд 2021 онд дотоодын үйлдвэрлэлийг 100 хувь болгох зорилтот түвшин дэвшүүлсэн байна. Энэ хүрээнд 2016 онд 20 нэр төрлийн 5.7 тэрбум төгрөгийн үнэ бүхий нийт 124,079.7 литр шингэн, 23,291 мянган тун хатаасан вакцин, 7 нэрийн өвчнийг илрүүлэхэд шаардагдах 22 төрлийн 18.0 сая төгрөгийн үнэ бүхий 55.9 литр шингэн, 36.5 мянган тун хатаасан оношлуурыг дотооддоо үйлдвэрлэсэн байна.

#### **4-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ХХААХҮЯ (2017-2019)-ны тус хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас дор авч орууллаа.

**4.1 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд** улс, аймаг, сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтад авах бэлчээрийн хэмжээ шалгуурын үзүүлэлтийг авч үзэхэд 2009 онд нийт 577.2 мянга га талбайг отрын бүс нутагт авч байсан бол 2018 онд өссөн дүнгээр 905.5 мянган га талбайг отрын бүс нутгаар авч, жилд дунджаар 7.7 хувиар өссөн байна. Энэ нь бэлчээрийн талбай (110,429.33 мян.га)-н 0.82%-ийг эзэлж байна, уг шалгуур ёсоор бол 2021 он гэхэд 10% хүргэх ёстой. Тус шалгуурын 2018 оны биелэлт (2021 оны хүрэх түвшинтэй харьцуулахад) 8.2% байна.

**4.2 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулан малын тооны дээд хязгаарыг тогтоох шалгуур үзүүлэлтийн хувьд 2016 онд энэ талын ямар нэгэн ажил хийгдээгүй, 2017 он (2018)-д өвөл хаврын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 25 хувь нь хүрэлцээтэй, 30 хувь нь 1-3 дахин хэтэрсэн, 10 хувь нь 3-5 дахин хэтэрсэн, 30 хувь олон дахин хэтэрсэн дүн гарч, өнгөрсөн жилтэй харьцуулахад 3 дахин хэтэрсэн дүнтэй гарсан байна. 2017 болон 2018 оны хөтөлбөрийн тайланд шинжилгээ хийх явцад бэлчээрийн даацын судалгааны үр дүн ижил гарсан нь аль нэг оны мэдээлэл буруу болохыг харуулж байна.

**Аймаг, сум бүрт өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех бий болгох 4.3 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** хөтөлбөрийн I шат хэрэгжиж дуусахад 150



цехтэй болно гэсэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна. 2018 оны жилийн байдлаар улсын хэмжээнд нийт 116 тэжээлийн үйлдвэр, цех байгаагаас байнгын болон түр ажиллагаатай 68, ажиллагаа нь зогссон 49 тэжээлийн үйлдвэр, цех байна. Энэ нь 2015 оны үзүүлэлттэй харьцуулахад 22.7 хувиар доогуур байна.

**4.4 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд бэлчээр сайжруулах арга хэмжээний хүрээнд** шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн тоо 2021 онд 2686 байхаар тогтоосон байна. Манай улс 2017 оны байдлаар хөдөөгийн хүн ам, мал аж ахуйг усаар хангах зориулалт бүхий 43.8 мянган худагтай, үүнээс 90.0 орчим хувь нь өвөл, хавар, зун намрын бэлчээрт байрлалтай. Нийт худгийн 28.3 хувь буюу 13.6 мянга нь инженерийн хийцтэй, 71.7 хувь буюу 30.2 мянга нь энгийн гар худаг байна. 2017 онд 142 худаг шинээр гаргах нөөц цэгтэй болсон. 2016-2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 149, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 427, гадаадын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 62, малчдын санаачилгаар 673, нийт 1356 инженерийн хийцтэй худгийг шинээр барьж ашиглалтанд оруулсан байна. 2016-2018 онд 1449 худаг ашиглалтад оруулсан нь 2021 оны зорилтот түвшинтэй харьцуулахад бага хувьтай байна.

Бэлчээр сайжруулах арга хэмжээний хүрээнд бэлчээрийн хортон, мэрэгч амьтантай тэмцэх талбайг авч үзэхэд 2021 онд өссөн дүнгээр 10000 мянга га байхаар шалгуур үзүүлэлт тогтоосон байна. 2010-2016 онд 2010-2016 онуудад бэлчээрийн хортон, мэрэгч амьтантай тэмцэх арга хэмжээг 4840 мянган га талбайд, 2017 онд 570.1 мянган га талбайд, 2018 онд 800 мянган га талбайд, нийт 2010-2018 онууд 6210.1 мянган талбайд арга хэмжээ авсан 2021 оны зорилтот түвшинтэй харьцуулахад 62.1 хувьтай байна.

**4.5 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд малын индексжүүлсэн даатгалд хамрагдах малчин өрхийн тоо 2021 онд суурь онтой харьцуулахад 20 хувиар өсөх шалгуур тавьсан байна. 2017 онд малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан 24.1 мянган малчин өрх 5.6 сая толгой мал даатгуулсан бол 2018 онд 33.7 мянган малчин өрх 7.8 сая мал даатгуулсан байна. Сүүлийн 2 жилийн өсөлтийн хувийг авч үзэхэд 7.1 хувьтай байна.

**4.6 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** нийт үйлдвэрлэх тэжээлийн хэмжээг 2021 онд 900 мянган тонн, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээлийг 40 хувь өсгөх шалгуур тавьсан байна. 2016-2018 онууд 408 мянган гар тэжээл, 61.5 мянган тонн үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээл бэлтгэсэн байна.

### **5-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ХХААХҮЯ (2017-2019)-ны тус хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас дор авч орууллаа.

**5.1 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд** мал нядалгааны цех бий болгох ажлын хүрээнд 2021 оны зорилтот түвшинг тодорхойлоогүй 2012 онд дуусгавар болсон байна.

**5.2 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** мах, нядалгааны жингээр нийт үйлдвэрлэх махны хэмжээг 2021 оны зорилтот түвшнээр авч үзэхэд мах нядалгааны жингээр 324 мянган тонн байхаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна. 2018 оны байдлаар 515.2 мянган тонн мах үйлдвэрлэсэн нь 2021 оны зорилтот түвшнээс 59 хувиар өндөр гарсан байна.

Харин үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний хэмжээг 2021 онд 157 мянган тонн байхаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон ба 2018 онд 42.5 мянган тонн мах үйлдвэрийн боловсруулсан нь 2021 оны зорилтот түвшинтэй харьцуулахад 3.7 дахин доогуур үзүүлэлттэй байна.

Экспортод гаргах махны хэмжээ 2021 онд 50 мянган тн байхаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон ба 2018 онд 39.4 мянган тонн, мах, махан бүтээгдэхүүний нийт экспортын хэмжээ 54.9 мянган тонн болсон байна. Экспортод гаргасан махны хэмжээг 2021 оны зорилтот түвшинтэй харьцуулахад 100%-иас давсан байна.

**5.3 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** нийт үйлдвэрлэх сүүний хэмжээ 2021 оны зорилтот түвшинг 622.9 мянган тонн байхаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна. 2018 онд 902.4 мянган тонн сүү үйлдвэрлэсэн нь зорилтот түвшинтэй харьцуулахад 1.4 дахин өндөр үзүүлэлттэй байна. Харин үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ 2018 оны байдлаар 135 мянган тонн байгаа нь 2021 оны зорилтот түвшин буюу 124.6 мянган тоннтой харьцуулахад 8.3 хувиар өндөр үзүүлэлттэй байна.

**5.4 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд** дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн, гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнд чанараас хамааран урамшуулал олгох арга хэмжээг ноос болон арьс ширний урамшуулал олгох замаар шийдвэрлэсэн байна.

#### Хүснэгт 8. Малчдад олгосон ноосны урамшуулал

Он	Малчны тоо	Дундаж өсөлт, %	Ноосны хэмжээ (Тонн)	Дундаж өсөлт, %	Мөнгөн дүн (Тэрбум төгрөг)	Дундаж өсөлт, %
2011	32,977	10.8%	4,924.9	18.9%	9.8	9.5%
2012	103,162		14,696.6		29.4	
2013	117,667		18,307.3		36.6	
2014	80,619		16,643.5		18.3	
2015	79,407		16,897.0		19.3	
2016	92,885		20,599.0		22.6	
2017	86,985		20,244.6		22.5	
2018	67,648		16,564.0		18.5	
<b>НИЙТ</b>	<b>661,350</b>				<b>128,876.9</b>	

Эх сурвалж: ХХААХҮЯ (2019)-ны тайлангийн тоо мэдээнд үндэслэн тооцсон зохиогчдын тооцоолол

Ноосны урамшуулалд жилд дунджаар 82,669 малчин өрх хамрагдаж, нэг малчин өрх дунджаар 267.6 мянган төгрөгийн ноосны урамшуулал авсан байна. Мөн ноосны урамшуулалд хамрагдах малчдын тоо жилд дунджаар 10.8%-иар, урамшуулал бодох



ноосны хэмжээ жилд дунджаар 18.9%-иар, урамшуулалд олгосон мөнгөн дүн жилд дунджаар 9.5%-иар тус тус өссөн байна.

### Хүснэгт 9. Малчдад олгосон арьс, ширний урамшуулал

№	Он	Малчны тоо	Дундаж өсөлт, %	Арьс, ширний тоо (Ш)	Дундаж өсөлт, %	Нийт мөнгөн дүн (Тэрбум Төг)	Дундаж өсөлт, %
1	2013 оны сүүлийн хагас	29,811	21.2%	741,417	36.1%	2.7	34.3%
2	2014 оны эхний хагас	3,085		57,990		0.2	
3	2014 оны сүүлийн хагас	54,535		2,014,597		7.9	
4	2015 оны сүүлийн хагас	45,061		2,492,871		9.5	
5	2016 оны сүүлийн хагас	64,255		3,124,932		12.7	
6	2017 оны сүүлийн хагас	77,995		3,467,404		11.8	
<b>НИЙТ</b>		<b>274,742</b>	-	<b>11,899,211</b>	-	<b>44.8</b>	-

Эх сурвалж: ХХААХҮЯ (2019)-ны тайлангийн тоо мэдээнд үндэслэн тооцсон зохиогчдын тооцоолол

Арьс, ширний урамшуулалд дунджаар 45.7 мянган малчин өрх хамрагдаж, нэг малчин өрх дунджаар 163.1 мянган төгрөгийн урамшуулал авсан байна. Мөн арьс, ширний урамшуулалд хамрагдах малчдын тоо дунджаар 21.2 хувиар, урамшуулал бодох арьс, ширний хэмжээ дунджаар 36.1 хувиар, урамшуулалд олгосон мөнгөн дүн дунджаар 34.3 хувиар тус тус өссөн байна.

**5.5 дугаар шалгуур үзүүлэлтийн хувьд** хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний биржийн сүлжээ бий болгох ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн бирж жилд дунджаар 169 спорт арилжаа зохион байгуулж, 1,145 хэлцлээр 6,539.2 тонн ноолуур, 14,972.35 тонн хонины ноос, 524 тонн тэмээний ноос, 2,450.9 тонн ямааны завод ноос, 12.05 тонн сарлагийн хөөвөр арилжиж, 587.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нийт шалгуур үзүүлэлтийн биелэлт

Хүснэгт 10. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2016-2018 оны хэрэгжилтэд шалгуур үзүүлэлтийн дагуу өгсөн үнэлгээ

№	ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	2008 ОНЫ СУУРЬ ТҮВШИН	2021 ОНД ХҮРЭХ ТҮВШИН	2018 ОНД ХҮРСЭН ТҮВШИН	2021 ОНЫ ТҮВШИН БА 2018 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ (%)	ТАЙЛБАР БА ЭХ СУРВАЛЖ	
1	1-р тэргүүлэх чиглэл	1.1 Мал аж ахуйн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	58.8%	58.8%	-	
2		1.2 Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг бэхжүүлэх:	- Төрийн үйлчилгээний алба	Тоо	0	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй	-	
3			- Хувийн хэвшлийн үйлчилгээний нэгж шинээр	Тоо	751	1,021	1,006	98.5%	ММҮХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан
4			<b>Дундаж</b>					<b>98.5%</b>	-
5		1.3 Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх:	- шинээр бэлтгэх, давтан сургах мэргэжилтэн	Тоо	104	2,120	229	10.8%	ММҮХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан
6			- Малчны түр сургууль төгсөгчид	Тоо	25	17,000	3,942	23.2%	ММҮХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан
7			<b>Дундаж</b>					<b>17.0%</b>	-
8		<b>1-р тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэл</b>						<b>58.1%</b>	-
9	2-р тэргүүлэх чиглэл	2.1 Малын удмын санг хамгаалах ажлын хүрээнд:	- Малын удмын сангийн үндэсний цогцолбор	Тоо	0	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй	-	
10			- Бүсүүдэд байгуулагдах мал үржүүлэг, биотехнологийн салбар	Тоо	0	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй	-	
11			- Зохиомлоор хээлтүүлэх мал	Тоо	3,200	120,000	11,909	9.9%	ММҮХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан
12			<b>Дундаж</b>					<b>9.9%</b>	
13		2.2. Дотооддоо үйлдвэрлэх, импортоор авах үржүүлгийн бүтээгдэхүүн:	- Дотооддоо үйлдвэрлэх үр, хөврөл үр	Тоо	21,000	195,000	95,133	48.8%	ММҮХ-ийн 2016, 2018 оны ХШҮ-ний тайлан
14			- Импортлох үр, хөврөл үр	Тоо	7,000	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		
15			<b>Дундаж</b>					<b>48.8%</b>	
16			Нийт	Мян.тол	43,288	36,475.60	66,460.18	0.0%	ҮСХ-ны 1212.mn
17			- Тэмээ	Хувь	0.6%	0.9%	0.7%	33.3%	ҮСХ-ны 1212.mn
18			- Адуу	Хувь	5.1%	8.2%	5.9%	25.8%	ҮСХ-ны 1212.mn
19			- Үхэр	Хувь	5.8%	13.8%	6.6%	10.0%	ҮСХ-ны 1212.mn
20		- Хонь	Хувь	42.4%	45.1%	46.0%	100.0%	ҮСХ-ны 1212.mn	
21		- Ямаа	Хувь	46.1%	32.0%	40.8%	37.6%	ҮСХ-ны 1212.mn	
22		<b>Дундаж</b>					<b>34.5%</b>	-	
23	2.4. Нэг малаас авах ашиг шим:	- Цэвэр, эрлийз үнээний сүү	305 хоног/ кг	1,769	3,200	2,623	82.0%	ММҮХ-ийн 2016, 2018 оны ХШҮ-ний тайлан (1	



								үнээнээс өдөрт дунджаар 8.6 Л сүү саасан)	
24		- Ноолуур	Грамм	290	310.0	406.7	100.0%	ҮСХ (2019) 2018 оны статистикийн эмхэтгэл	
25		- Нарийн, нарийвтар ноос	Кг	3.9	4.9	Шаардлагатай мэдээлэл олдоогүй		-	
26		- Бүдүүн, бүдүүвтэр ноос	Кг	1.1	1.5			-	
27		<b>Дундаж</b>						<b>91.0%</b>	-
28	2.5. Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох:	- Сүлжээнд хамрагдах нэгж	Тоо	0	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
29		- Бүртгэлжүүлэх мал, өссөн дүнгээр	Хувь	0.3%	80.0%	13.2%	16.5%	ХХААХҮЯ-ны вэб хуудас (2012-2017 онд нийт 8,688,218 мал), ММУХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан (2018 онд 100,500 мал)	
30		<b>Дундаж</b>						<b>16.5%</b>	-
31		<b>2-р тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэл</b>						<b>40.1%</b>	-
32	3.1. Монгол Улс дараахь өвчнөөр тайван, өвчингүй статусыг ДМАЭМБ-аас авах:	- үхрийн цээж		0	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
33		- үхрийн тархины эд сархиатах		0	сертификат	50%	50.0%	Статус авах ажил эхэлсэн, зарим арга хэмжээ авч эхэлсэн	
34		- шүлхий		0	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
35		- хонь, ямааны цэцэг		0	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
36			<b>Дундаж</b>						<b>50.00%</b>
37	3.2. Малыг дараахь төрлийн өвчнөөс эрүүлжүүлэх:	-үхэр, тэмээг бруцеллэз өвчнөөс	Хувь	98%	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
38		-адууг ям өвчнөөс	Хувь	97.5%	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
39		-адууг халдварт цус багасах өвчнөөс	Хувь	99.3%	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
40		-сүүний үхрийг лейкоз өвчнөөс	Хувь	75%	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
41		-бог малыг бруцеллэз өвчнөөс	Хувь	99.5%	100%	93.7	93.7%	ММУХ-ийн 2018 оны ХШҮ- ний тайлан	
42		- бруцеллэзоос тайван бус нийт малчин өрх /одоо 3,5-11,7 хувь/	Хувь	7.6%	0.1%	Шаардлагатай мэдээлэл олдоогүй		-	
43		<b>Дундаж</b>						<b>93.7%</b>	-
44	3.3. Малын гоц халдварт өвчний дэгдэлт гараагүй байх:	Үйл ажиллагааны хэрэгжилтээр		-	-	50%	<b>50.0%</b>	ММУХ-ийн 2018 оны ХШҮ- ний тайлан	
45	3.4. Сум, дүүрэгт мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн магадлан шинжилгээ хийх чадавхитай болох:	Лабораторийн тоо		120	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
46	3.5. Малын өвчний оношлогооны явуулын үйлчилгээ бий болгох:	Тоо		0	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй		-	
47	3.6. Малын эм, биобэлдмэл /вакцин, оношлуур/-ийг дотооддоо үйлдвэрлэх:	Хувь		70%	100%	90%	<b>90.0%</b>	ММУХ-ийн 2018 оны ХШҮ- ний тайлан	
48		<b>3-р тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэл</b>						<b>70.9%</b>	-




49	4-р тэргүүлэх чиглэл	4.1.Улс, аймаг, сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтад авах бэлчээрийн хэмжээ:	Хувь	0.5%	10%	0.82%	<b>8.2%</b>	ММУХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан (905.5 мян.га-г хамгаалалтад авсан нийт бэлчээр 110,429.33 мян.га)		
50		4.2.Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулан малын тооны дээд хязгаарыг /квот /тогтоох:	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй	-	-		
51		4.3.Аймаг, сум бүрт өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех бий болгох:	Тоо	38	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй	-	-		
52		4.4.Бэлчээр сайжруулах арга хэмжээ:	Шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн тоо	Тоо	1314	2,686	1,449	53.9%	ММУХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан	
53			Бэлчээрийн хортон, мэрэгч амьтантай тэмцэх талбай	Мян.га	700.0	10,000	6,210	62.1%	ММУХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан	
54		<b>Дундаж</b>						<b>58.0%</b>	-	
55		4.5.Малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох:	- малын индексжүүлсэн даатгалд хамрагдах малчин өрхийн тоо	Хувь	3.3%	20%	14.6%	<b>73.0%</b>	33.7 мян.өрх индексжүүлсэн даатгалд хамрагдсан (ММУХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан). Нийт малчин өрхийн тоо 230,854 (ҮСХ, 2018 оны статистикийн эмхэтгэл).	
56		4.6.Бэлтгэх тэжээлийн хэмжээ:	- нийт үйлдвэрлэх тэжээл	Мян.тн	560.5	900	725.3	80.6%	ХХААХҮЯ, 2018	
57			-үйлдвэрийн аргаар бэлтгэх тэжээл	Хувь	9.6%	40%	5.8%	14.5%	42 мянган тонн тэжээл үйлдвэрийн аргаар бэлтгэсэн (ХХААХҮЯ,2018)	
58		<b>Дундаж</b>						<b>47.6%</b>	-	
59		<b>4-р тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэл</b>						<b>46.7%</b>	-	
60		5-р тэргүүлэх чиглэл	5.1.Мал нядалгааны цех бий болгох	Тоо	25.0	2021 онд хүрэх түвшин тодорхойлогдоогүй	2-р шатны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй	-	-	
61			5.2.Мах, нядалгааны жингээр	нийт үйлдвэрлэх махны хэмжээ:	Мян.тн	223.1	324	515.2	100.0%	ҮСХ (2019) 2018 оны статистикийн эмхэтгэл
62				үйлдвэрийн аргаар боловсруулах	Мян.тн	15.1	157	45.2	28.8%	ҮСХ (2019) 2018 оны статистикийн эмхэтгэл
63	экспортод гаргах			Мян. тн	10.2	50	54.9	100.0%	ХХААХҮЯ (2018)	
64	<b>Дундаж</b>						<b>76.3%</b>	-		
65	5.3.Нийт үйлдвэрлэх сүүний хэмжээ:		- Нийт	Мян.тн	457.3	622.9	902.4	100.0%	(ХХААХҮЯ (2018)	
66			- үйлдвэрийн аргаар боловсруулах	Мян.тн	16.5	124.6	134.9	100.0%	ҮСХ (2019) 2018 оны статистикийн эмхэтгэл	
67	<b>Дундаж</b>						<b>100.0%</b>	-		
68	5.4.Дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн, гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнд чанараас хамааран урамшуулал олгох		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	-	90.0%	<b>90.0%</b>	ММУХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан	
69	5.5.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний биржийн сүлжээ бий болгох		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	-	90.0%	<b>90.0%</b>	ММУХ-ийн 2018 оны ХШҮ-ний тайлан	
70	<b>5-р тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэл</b>						<b>89.1%</b>	-		
71	<b>ХӨТӨЛБӨРИЙН 2-Р ШАТНЫ ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН</b>						<b>61.0%</b>	-		

Эх сурвалж: ХХААХҮЯ (2017-2019)-ны тайлангийн тоо мэдээнд үндэслэн тооцсон зохиогчдын тооцоолол

Дээрх хүснэгтээс харахад 5-р Тэргүүлэх чиглэлийн дагуу хэрэгжүүлсэн ажлууд гүйцэтгэл өндөр, харин 2 болон 4-р Тэргүүлэх чиглэлийн хэрэгжүүлсэн ажлууд гүйцэтгэл багатай болох нь харагдаж байна. Харин хөтөлбөрийн нэгдүгээр шатны үр дүнг 2016-2018 хэрэгжилтийн үр дүнтэй харьцуулсан үнэлгээг дараах зургаар харуулав.

Тус хөтөлбөрийн II үе шатанд төлөвлөсөн 109 үйл ажиллагаанаас 24 үйл ажиллагааг 2016-2018 онуудад хэрэгжүүлэхээр арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан ба эдгээр үйл ажиллагааны үр дүнг дээрх хүснэгтэд харуулсан шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дундаж үнэлгээ нь 61%-тай байна.

**Зураг 9.** “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээ, тэргүүлэх чиглэлээр



Эх сурвалж: ХХААХҮЯ (2017-2019)-ны тайлангийн тоо мэдээнд үндэслэн тооцсон зохиогчдын тооцоолол

Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл тус бүрээр 2016-2018 оны хэрэгжилтийг I шатны хэрэгжилттэй харьцуулахад 1, 2, 4-р тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт I шатны биелэлтээс доогуур, 3, 5-р тэргүүлэх чиглэлийн биелэлт I шатны биелэлтээс өндөр байна. Тавдугаар тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийн өсөлт нь бусдаас өндөр гарсан нь хэд хэдэн шалтгаантай. Үүнд: сүү, махны үйлдвэрлэл мэдэгдэхүйц өссөн, хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа сайжирсан, ноос, ноолуур, арьс, ширний урамшууллын бодлого амжилттай хэрэгжсэн зэрэг нь гол нөлөө үзүүлсэн.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн I шатны хэрэгжилт 68% байсан (ХХААХҮЯ, 2019) бол II шатны хэрэгжилт 61% болж буурсан байна. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II шатны хэрэгжилтийн түвшин I шатны хэрэгжилтийн түвшнээс хамгийн ихээр буурсан тэргүүлэх чиглэл нь малын үржил, ашиг шим, гарц нэмэгдүүлэх 2-р тэргүүлэх чиглэл юм. Энэ чиглэлийн хэрэгжилт эхний шатанд 74.3% байснаа 40.1% болж буурсан байна. Үүний гол шалтгаан нь нэгдүгээрт дотооддоо малын үр үйлдвэрлэх, импортоор авах малын үрийн тоог бууруулах зорилт маш бага хувьтай хангагдсан, хоёрдугаарт малын бүртгэл мэдээллийн систем, сүлжээ бий болгох шалгуур үзүүлэлт хангалттай биелээгүйтэй холбоотой.



### 3.2.3 Орон нутгаас “Монгол мал” үндэсний хөтөлбөрт өгсөн санал, шүүмж

#### **1. Малын эрүүл мэндийн үйлчилгээ**

##### ***Алдаа дутагдал:***

- Малчдын хандлага муу байгаа нь мал эмнэлгийн үзлэг, шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмч мэргэжилтнүүдийн ажилд тусалж хамтран ажиллахдаа хойрго ханддагаар харагдаж байна.
- Зарим аймагт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээний хөлс нийт малын 20 хувьд ногдож байгаа нь хэт бага байна.
- Малаас хүнд халдварладаг зоонозын халдварт өвчнүүдээс малчид болон түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг хамруулах, тандалт шинжилгээ хийх санхүүгийн асуудлыг орхигдуулсан
- Тендэрээр нийлүүлэгдсэн зарим тоног төхөөрөмжийн хангалт дутмаг, малын эмч нарыг чадавхжуулах сургалтыг хангалттай бус зохион байгуулсан.
- Бруцеллёз өвчний жил бүр тохиолдол илэрч байна
- Хөтөлбөрийн хугацаанд 2016 онд адууны ям, 2016, 2017 онд хонь, ямааны цэцэг, 2017, 2018 онд шүлхий өвчин тус тус оношлогдсон байна. Шинээр 2019 онд Гахайн Африкийн мялзан өвчин оношлогдсон.

##### ***Санал шүүмж:***

- Малын эрүүл мэндийн даатгал бий болгох.
- Малчдыг идэвхжүүлэх
- Төсвөөс тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх

#### **2. Малын генетик нөөц, үржил селекц**

##### ***Алдаа дутагдал:***

- Бэлчээрийн даац хэтэрсэн.
- Мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай.
- Багаж тоног төхөөрөмж хангалтгүй.
- Үржлийн нэгжүүд үйл ажиллагаа явуулахад санхүүгийн дэмжлэг дутмаг байна.
- Бог малын хээлтүүлэгчийг бүрэн ялгаж мэргэжилтний хяналтад оруулж чадахгүй байна.
- Малчид дур мэдэн дур зоргийн хээлтүүлгийг ихээр хийж байна.
- Хээлтүүлэгчийг хяналтгүй хаа сайн байна гэсэнээс ашиглаж малын үүлдэрлэг байдлыг алдагдуулах төлөв ажиглагдаж байна.
- Малын (бог, бод) ээмэг амархан унадаг, ашиглалт муутай байна.
- Орон нутгаас санхүүжүүлж байгаа төсөв нь цаг хугацаандаа орж ирдэггүй.
- 2019 оны төсөвт 25 сая төгрөгийн санал өгсөн боловч дэмжигдээгүй. Малын чанар сайжруулах асуудалд санхүүжилт хомсдолтой байна.



- Үзлэг ангилалтын зардлыг ОНТөсөвт суулгах санал хүргүүлдэг боловч зардал батлагддаггүй.
- Үржлийн ажил үйлчилгээний төрийн хяналт байхгүй учраас иргэн аж , ахуйн түвшинд үржлийн бодлого алдагдсан.

### **Санал шүүмж:**

- НҮБ-ын ХХААБ-аас санхүүжүүлэн ХХААХҮЯ-тай хамтран “Малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төслийг 2019-2020 онд хэрэгжүүлнэ.
- Монгол мал үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.
- Мал сүргийг болон эрсдэлт бүлгийн (малчид, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид) иргэдийг тандалт шинжилгээнд хамруулж байх
- Хөтөлбөрөөр тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байсан. Тухайлбал мал эмнэлгийн үйлчилгээний хяналт мониторинг хийх зардал гэх мэт.
- Вакцины нийлүүлэлт оройтох, вакцин хангалттай хэмжээнд ирэхгүй байх, мал эмнэлгийн үйлчилгээний хөлс олгогдохгүй байх зэрэг хүндрэлүүд гарч байна.
- Халдварт өвчний хорио цээрийн бүсэд ажилласан ажилтан албан хаагчидын томилолт, ажлын хөлс бусад зардал олгогдохгүй
- Шинээр байгуулагдаж байгаа МҮТАҮН-ийг бодлого, санхүүгээр дэмжих шаардлагатай байна.

### **3. Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалт**

#### ***Алдаа дутагдал:***

- Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 670.0 мянган га бэлчээрт үлийн цагаан оготно тархсан боловч жилд 40.0 мянган га бэлчээрт уг мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж байгаа нь хангалтгүй байна.
- Бэлчээрийн тухай хууль, эрх зүйн орчин байхгүй байна..
- Орон нутагт бэлчээрийн тухай хууль эрх зүйн орчин дутагдалтай байна. Малчдын идэвх санаачилга муу хөрөнгө мөнгөтэй ажилд л оролцдог.
- "Монгол мал" аймгийн дэд хөтөлбөр батлуулаагүй. Хөтөлбөрийн нэгдсэн төсөв батлагдаагүй, үйл ажиллагааны зардал тодорхой бус, байгаа нь хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, үнэлгээ хийх, дүгнэлт өгөхөд хүндрэлтэй байна.
- Малчид бэлчээрээ сэлгэж ашиглах нь ховор, нэг суурин байх сонирхолтой. Мөн гадны малчид зөвшөөрөлгүй ихээр орж ирж бэлчээр талхагдалд орж байна.
- Эрс тэс уур амьсгалтай тус аймгийн хувь бэлчээрийг хуваарьтайгаар ашиглах боломж тааруу байсан.
- Зардлыг ОНТөсөвт суулгах санал хүргүүлдэг боловч зардал батлагддаггүй.
- Алслагдмал 3 дүүрэг Багануур, Багахангай, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт бэлчээрт хөнөөл учруулагч үлийн цагаан оготно устгалд зарцуулагдах зардлыг улс, орон нутгийн төсөвт тусгадаггүй.



### **Санал шүүмж:**

- Хөрөнгө санхүүгийн дутагдалтай
- Бэлчээрийг зүй зохистой ашиглах талаар улсын хэмжээнд компанит ажил өрнүүлэх
- Бэлчээрийн тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах, улсын хэмжээнд нийтээрээ хэрэгжүүлэх орон нутгийн онцлогт тохируулан бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх
- Бэлчээрийн тухай хуультай болох, бэлчээр нутгийг малчдын бүлэг, хоршоонд хариуцуулж өгөх
- Бэлчээрт тархсан үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх шаардлагатай байна.
- Малын хөлийн татвартай болгох
- Бэлчээрийг хамгаалах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байгаа учир зарим заалтуудыг хэрэгжүүлэхд бэрхшээл тулгарч байна.
- Бэлчээрт тархсан үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх шаардлагатай байна.
- Бэлчээрийн талбай бага. Малчид өөр аймгийн нутаг дэвсгэрт өвөлждөг. Нэг гэр бүл 2 аймагт харьяатай болдог. Бэлчээрийн хуулийг гаргах хэрэгтэй.
- Улсын төсвөөр хийгддэг боловч орон нутгийг бүрэн хамруулж чаддаггүй. Төсөв тутагддаг

### **4. Ус, худаг шинээр гаргах, хуучин сэргээн засварлах**

#### ***Алдаа дутагдал:***

- Улсын төсвийн хөрөнгөөр шинээр гаргаж буй худгийн тендерт шалгарсан компани ажлаа оройтож эхэлдэг, олон ажил давхар авснаас тухайн жилдээ ажлаа гүйцэтгэж амждаггүй.
- Өндөр уулын бүс, алаг цог цэвдэгтэй тул хайгуулын ажлыг үнэн зөв хийх. Зарим устай гэсэн газраас ус гарахгүй байна, цэвдэгтэй газарт устай гэж заасан учир худаг хөлдөх асуудал гарч байна.
- Шинээр худаг гаргах, засварлах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах зэрэгт улс, орон нутгийн төсвөөс хөрөнгө мөнгө гаргахгүй байна.
- Бэлчээрт худаг гаргахад уст цэгийн хайгуул хийлгэх хэрэгтэй байна.
- Тендер зарласан тохиолдолд чанартай худаг гаргадаг компаниудыг шалгаруулах
- Газар нутгийн онцлогоос шалтгаалан усны хомсдолтой хуурайшилт ихтэй байдаг тул худаг гаргахад багадаа 120 м өрөмдөж ус гаргаж байна. Бэлчээрийн усан хангамж 50.4 хувьтай байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч жил бүр тодорхой хэмжээний бэлчээр усжуулалтанд улс, аймаг, сумын дэмжлэгтэйгээр хөрөнгө тусгаж ажилладаг.
- Бэлчээрт худаг гаргахад уст цэгийн хайгуул хийлгэх хэрэгтэй байна.
- Худгийн мотор, насос эвдрэх, усны ундарга багасах зэрэг дутагдал гардаг.
- Отрын бэлчээрийг усжуулах, усны хайгуул хийх чиглэлээр улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. 2012 оноос хойш аймгийн

хэмжээнд энэ чиглэлээр аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалт хийгдээгүй байна. Орон нутгийн төсвөөс дээрх ажлыг хийж байгаа ч ахиц муу байна.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрчимжсэн аж ахуй эрхлэх бүс нутагт санхүүжилт төсөвлөж байх хэрэгтэй байна.
- Худгийг сум орон нутгийн захиалгаар гаргадаг учир голын ойролцоо болон худаг хоорондын зай ойрхон байдаг дутагдалтай тал бий болж байна.

#### ***Санал шүүмж:***

- Орон нутагт тендерт зарлах эрх шилжүүлэх, орон нутгийн компанийг шалгаруулах
- Жилд сум бүрийн тоогоор худаг ус гаргаж усны хайгуулыг тогтмол хийж байх
- Худгийн захиалгын дагуу худаг гаргах нь зүйтэй
- Монгол мал үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.
- Орон нутгийн мэргэжлийн байгууллагууд (ХХААГ, БОАЖГ), малчдын зүгээс шинээр гаргаж буй худгуудад хяналт сайн тавьж ажиллах шаардлагатай байдаг.
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжүүлэх шаардлагатай. Сүүлийн жилүүдэд аймгийн хэмжээнд худаг, усан хангамжийг шийдвэрлэх зардал хуваарилагдахгүй байна.
- Уст цэгийн судалгаа хийх шаардлагатай.

#### **5. Хадлан бэлтгэл**

##### ***Алдаа дутагдал:***

- Эдийн засгийн хүндрэлээс болж нөөц бүрдүүлэх санхүүгийн боломж хомс байна
- Аймгийн аюулгүйн нөөцийг хадгалдаг агуулах хамгаалалтын хашаа байхгүй.
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Хадлангийн газар тусгаагүй байж, хадлан хадуулах тохиолдол ихээр гарч байна. Гадны хадлангийн салаа ихээр орж ирж байна.
- Аймгийн аюулгүйн нөөцийг хадгалдаг агуулах хамгаалалтын хашаанууд мууддаг.
- Аймаг, сумын нөөцийн агуулах, саравч байхгүйгээс өвс, тэжээлийн хадгалалтын стандартыг хангаж чадахгүй байна.

#### ***Санал шүүмж:***

- Хадлангийн салаа байгуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах
- Төсөв батлахдаа нөөц бүрдүүлэх орон нутгийн төсөвт тусгаж өгөх
- Эрх бүхий албан тушаалтнууд малчдын нэрээр өрхийн хадлан гэж гэрээ хийчихээд үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг.

- Газар нутаг бага, бэлчээрийн даац хэтэрсэн учир хадлан авахад хүндрэлтэй байдаг
- Тоног төхөөрөмжийн дэмжлэг
- Хадлан бэлтгэх талбайг бусад аймгуудтай тохиролцож шийдүүлэх
- Аймаг, сумын нөөцийн агуулах, саравчтай болох

## **6. Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэл**

### ***Алдаа дутагдал:***

- Техник тоног төхөөрөмжийн хангалт муу, худалдан борлуулах зах зээл бага
- Тэжээл үйлдвэрлэх түүхий эд хомс
- Социализмын үед тэжээл тарьдаг байсан талбайгаа бүрэн ашиглаж чадахгүй, тариаланчдаа дэмжихгүй
- Аймаг орон нутгийн төсвөөс ямар нэгэн дэмжлэг байхгүй.
- Малын тэжээлийн ургамал тариалах ажлыг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Дэрэн суман дахь ЭШТҮОНӨҮГ-т 30 га талбайд туршиж тариалж байсан Гэсэн хэдий ч хөрөнгө санхүү, боловсон хүчнээс хамааран үйл ажиллагаа зогсонги байдалд орсон.
- Аймаг орон нутгийн төсвөөс ямар нэгэн дэмжлэг байхгүй.
- Сумдад болон малчдад дундын болон өөрийн эзэмшлийн техник байхгүй тариалалт хийх үрийн нөөц байхгүй, үрийн будааны үнэ өндөр байна.

### ***Санал шүүмж:***

- Үрийн олдоц бага, үр үржүүлгийн компаниудыг дэмжих
- Улсын төсөв болон төрийн бодлогоор дэмжих
- Тариаланч ногоочдыг бүх талаар дэмжиж бэлтгэсэн өвс, тэжээлийг нь аймаг, сумын нөөцөд авдаг байх
- Техник үрийн хангамжид дэмжлэг үзүүлж хөрөнгө оруулалт хийх
- Материаллаг баз суурийг ашиглан аймгийн хэмжээний тэжээлийг хангаж, нийлүүлэх үйлдвэр, цех болгох, боломж нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах шаардлагатай байна.
- Техник үрийн хангамжид дэмжлэг үзүүлж хөрөнгө оруулалт хийх
- Газар нутаг бага, бэлчээрийн даац хэтэрсэн учир хадлан авахад хүндрэлтэй байдаг
- Тоног төхөөрөмжийн дэмжлэг
- Тэжээлийн ургамал тариалалтад урамшууллын бодлогоор дэмжлэг үзүүлэх
- Сумдад тэжээлийн ургамал тариалах дундын техниктэй болгох, үрийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай

## **7. Малчдын эрүүл мэнд**

### ***Алдаа дутагдал:***

- Ажил үйлчилгээ тогтмол хийгдэж чадахгүй, зорилтот хэсгийг бүрэн хамруулж чадахгүй байна.



- Малын эрүүл мэндийн дэвтэр бөглүүлсэн ч сар бүр эмчлүүлэхэд төлбөр төлж байна.
- малынхаа төлөө яваад эрүүл мэндээ хайхрахгүй байна. сүүлийн жилүүдэд хятад мотоцикл их унаж эрүүл мэндээрээ хохирох үзэгдэл их гарч байна. эрүүл мэндийн нарийссан үзлэг шинжилгээнд хамрагдалт бага байдаг.

#### ***Санал шүүмж:***

- Малчдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулдаг байх, эмчилгээ сувилалд явуулах
- Эрүүл мэндийн дэвтрээ бүрэн ашигладаггүй.
- эрүүл мэндийн төлөвлөгөөт ажил үйлчилгээнд малчдыг өргөнөөр хамруулах хэрэгтэй байна. малчдын цаг зав бага байдаг тул өрхөөр үзлэг шинжилгээнд хамруулах ажлууд зохион байгуулах хуучин таван хошуу малаа уналга эдэлгээнд ашиглах арга барилыг нэвтрүүлэх чухал байна.
- Малчдыг хавар, намрын улиралд эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулж байх

### **8. Малчдын боловсрол**

#### ***Алдаа дутагдал:***

- Малчдыг хариуцлагажуулах шаардлагатай
- Малчдыг бүрэн хамруулж чадахгүй байгаагийн дээр сургалтын чанар сайнгүй
- Малчин олдохгүй болж байна.
- Малчдын эдийн засгийн ухаан бага байна.
- Төсөв санхүүгийн хүрэлцээ муу байна.

#### ***Санал шүүмж:***

- Малчдыг сургах, үр хүүхдийг нь сургуульд бүрэн хамруулах, төсөл хөтөлбөртэй хамтрах
- Мэргэжлийн багш нараар хичээл заалгах
- Уламжлалт өв, соёлоо авч үлдэхийн тулд Малчдыг урамшуулах
- Эдийн засгийн ухаанд сургах мал махаа хэзээ яаж бэлдэх вэ гэх мэт менежментийн ухаан хэрэгтэй байна.
- Малчдын боловсролыг дээшлүүлэх талаар төр, засгийн бодлого хэрэгтэй байн
- Шаталсан сургалт зохион байгуулж малчдыг хамруулах.
- Алслагдсан хороодын иргэдийн хүүхдүүдийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулахад анхаарах.

### **9. Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ**

#### ***Алдаа дутагдал:***

- Амьжиргаа муутай малчин бүр хамрагдаж чадахгүй байна. Залуу малчдад хөнгөлөлттэй зээл, тусламж олдохгүй байна.

- Малжуулахаар чанар муутай мал олгогддог.
- Малчдын малаас гарч буй бүтээгдэхүүний үнэ бага байгаагаас малчид олон малтай болж амьжиргаагаа хангаж байна. Малаас гарч буй бүтээгдэхүүний үнэ хангалттай өндөр түвшинд хүрвэл малчид олон мал маллах шаардлагагүй болно.

#### ***Санал шүүмж:***

- Амьжиргаа дэмжих, малжуулах зэрэг хөтөлбөр арга хэмжээнд хамрагдах малчдын тоог нэмэгдүүлэх, ЖДҮ-ийн зээлийн 10 –с доошгүй хувийг малчдад зориулах
- Монгол мал үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.
- Малжуулах төслийн журамд заагдсан шалгуур үзүүлэлтийн малын тоо өндөр 50 толгой байж болохгүй юу.
- Мал, мах, малаас гарч буй бүтээгдэхүүний үнийг өндөр байлгах
- Малчин өрхүүдийг төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдуулах
- Эрчимжсэн бүс нутгийн фермер эрхлэгчдэд бодит дэмжлэг болох сүүний урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх

#### **10. Дэд бүтэц (Зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт)**

##### ***Алдаа дутагдал:***

- Ноос, арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийгдэхгүй, мах сүүний үйлдвэр цех цөөн хүчин чадал муу байна.

#### ***Санал шүүмж:***

- Малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн тоог нэмэгдүүлэх, борлуулалтын шат дамжлагыг цөөрүүлэх
- Дорноговь аймгийн хувьд Монгол мал үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагын төсөвт заалт тус бүрээр тусгах саналтай байна.
- Орон нутагт түүхий эд боловсруулах үйлдвэр цехийг бодлогоор дэмжиж өгөх
- Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлснээр хүн амын хүнсний хангамж, хүрэлцээ, эрүүл ахуйг цогц байдлаар шийдэхэд дэмжлэг хүсэж байна.

#### **11. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид**

##### ***Алдаа дутагдал:***

- Хөрөнгө санхүүгийн дутагдалтай
- Фермерүүд байр, хашаа хороогоо өөрийн нөөц бололцоог ашиглан барьж, үйл ажиллагаагаа тогтмол явуулдаг, малын чанар, ашиг шимийн гарцыг

нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч эхэлсэн боловч малын тэжээл тариалах талбайгүй байна.

- Байгаль цаг уурын эрсдэлтэй нөхцөл, өвс тэжээлийн хангамж зэргээс шалтгаалж иргэн аж ахуйн нэгж эрчимжсэн болон туслах аж ахуй эрхлэх хүсэл, сонирхол туу байна
- Бодлого, хөтөлбөрт тусгасан заалтыг хэрэгжүүлж бүсчилсэн байдлаар адуу, үхэр, хонь, ямааг төслөөр өгөх хэрэгтэй. Зүс таарахгүй малыг ХХААХҮЯамнаас төслөөр ирүүлдэг нь их учир дутагдалтай.
- Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдгээрээ бусад аймгаас ялгагдах нэг онцлогтой өөрийн орон нутгаасаа хадлан тэжээл авах боломжгүй байдаг тул эрчимжсэн аж ахуй эрхлэхэд хүнд байдаг.
- Малын үржлийн ажлын чиглэлд тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байгаагаас дур зоргын хээлтүүлэг хийгдэж, ашиг шимийн чиглэл үүлдэрлэг байдал алдагдахад хүрээд байна.

### **Санал шүүмж:**

- Эрчимжсэн мал аж ахуй өсгөн үржүүлэн гэсэн иргэдэд бүх талын дэмжлэг үзүүлэн хөнгөлөлттэй зээлэнд хамруулах
- Аж ахуй эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдан авах
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулсан бүсчилсэн улсын санхүүжилт дутмаг.
- Өөрийн орон нутгийн онцлогт тохирсон мал сүргийг өсгөн үржүүлж ашиг шимийг нэмэгдүүлэх нь илүү үр дүнтэй байна.
- Малын тоо толгойг багасган фермерийн аж ахуйг банкны бодлогоор дэмжих хэрэгтэй байна.
- Төрийн бодлогоор дэмжих
- Малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөнд эрчимжсэн нутагт үржүүлэх малын төрөл, ашиг шимийн чиглэл, үүлдэрлэг байдалд тохируулан өсгөн үржүүлэх, бүс нутгийн газар бэлчээр ашиглалтанд хяналт тавих.

## **3.3 МАЛЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ҮР ДҮН**

### **3.3.1 Ерөнхий мэдээлэл**

Судалгаанд нийт санамсаргүй сонгогдсон 41 малчин өрх хамрагдсан ба 43.9%-ийг 41-55 насны малчид, 36.6%-ийг 26-40 насны малчид, үлдсэн хувийг 25 хүртэл болон 56, түүнээс дээш насны малчид эзэлж байна. Мөн нийт малчдыг боловсролын түвшингээр авч үзвэл 57.7%-ийг бүрэн бус дунд боловсролтой малчид, 26.2%-ийг бүрэн дунд боловсролтой малчид, үлдсэн хувийг бусад боловсролын түвшинтэй малчид эзэлж байна.

Мөн судалгаанд хамрагдсан малчин өрхийг малын тоогоор нь авч үзэхэд нэг малчин өрх дунджаар 619 толгой малтай байна. Энэхүү үзүүлэлтийг насны бүлгээр авч үзвэл 25 хүртэл насны нэг малчин өрх дунджаар 314 толгой малтай, 26-40 насны нэг малчин өрх 627 толгой малтай, 41-55 насны нэг малчин өрх 653 толгой малтай, 56-



70 насны нэг малчин өрх 543 толгой малтай, 71 болон түүнээс настай малчин өрх 713 толгой малтай байна.

### 3.3.2 Хөтөлбөрийн талаар малчдын ойлголт, үнэлгээ

Судалгаанд хамрагдсан нийт малчдын 22 хувь нь “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг мэддэг, үлдсэн 78 хувь мэдэхгүй гэж хариулсан байна.

**Зураг 10.** “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн талаар малчдын ойлголт, насны бүлгээр



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Мөн хөтөлбөрийн баримт бичгийн малчин өрхөд үзүүлж буй нөлөөллийг авч үзэхэд хөтөлбөрийн баримт бичиг мэддэг малчдын 9 өрхийн хувьд өөрчлөлт гарсан гэж хариулсан ба ямар өөрчлөлт гарсныг дараах зургаар харуулав.

## Зураг 11. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн малчдад үзүүлж буй нөлөө



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд малчдын өгсөн үнэлгээг насны бүлгээр авч үзвэл 26-40 насны малчид л 2.5 оноо (буюу “дунд”)-ны үнэлгээ өгсөн, бусад насны бүлгийн малчдын хувьд хөтөлбөрт үнэлгээ өгөөгүй байна.

### Хүснэгт 11. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд малчдын өгсөн үнэлгээ

Насны Ангилал	Малчдын тоо	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Үнэлгээ өгөөгүй
25 хүртэл	2						2
26-40	15	1			1		13
41-55	18						18
56-70	4						4
71 болон түүнээс дээш	2						2
<b>Нийт</b>	<b>41</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>39</b>

Эх сурвалж: Судалгааны үр дүн

### 3.3.3 Малчдын санал

Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой малчдаас өгөх санал, зөвлөмжийг авч үзэхэд ихэнх хувь энэ талаар мэдээлэл өгөөгүй ба идэвхтэй оролцсон 2 хүний саналаар дараах зүйлсийг анхаарах ёстой гэж үзсэн байна. Үүнд:

- Малчдын саналыг маш их сонсож, судалгаа хийх хэрэгтэй
- Цаашдаа энэ хөтөлбөрийг улам эрчимжүүлэх хэрэгтэй



## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шат буюу 2016-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн 5 тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт 109 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба үүнээс 24 үйл ажиллагааг 2016-2018 онуудад хэрэгжүүлэхээр тусгасан байна. II үе шатны хэрэгжилтийн түвшин 61% байгаа нь I үе шатны хэрэгжилтийн түвшингээс доогуур байна.

Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл тус бүрээр II шатны хэрэгжилтийг I шатны хэрэгжилттэй харьцуулахад 1,2,4-р тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт доогуур, 3, 5-р тэргүүлэх чиглэлийн биелэлт өндөр байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны явцад буюу 2016-2018 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 24 үйл ажиллагаанаас хэрэгжиж дууссан 7, хэрэгжих шатандаа явж байгаа 12, хэрэгжээгүй 5 үйл ажиллагаа байна. Эдгээр үзүүлэлтийг тэргүүлэх чиглэл тус бүрээр авч үзвэл:

- Нэгдүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн 15 үйл ажиллагааны 33.3% нь хэрэгжиж дууссан, 40% нь хэрэгжих шатандаа яваа, 26.7% нь хэрэгжээгүй үйл ажиллагаа байна.
- Хоёрдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт 2 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба үйл ажиллагаа тус бүр амжилттай хэрэгжиж дууссан байна.
- Гуравдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн 4 үйл ажиллагааны 75% нь хэрэгжих шатандаа яваа, 25% нь хэрэгжээгүй үйл ажиллагаа эзэлж байна.
- “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шат буюу 2016-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 4-р тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2016-2018 онд төлөвлөсөн ямар нэгэн үйл ажиллагаа байхгүй байна.
- Тавдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт 3 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба эдгээр үйл ажиллагаа бүгд хэрэгжих шатандаа явж байна.

Нийт хийгдэхээр төлөвлөгдсөн ажлын 78% буюу 85 арга хэмжээний хяналт-шинжилгээ хийгдэх хугацаа болоогүй байна. Эдгээрийн 67 арга хэмжээ буюу 79% нь 2021 онд дуусах бөгөөд энэ нь тус хөтөлбөр дуусах үетэй давхцаж байна. Эндээс дүгнэвэл “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын цаг хугацааны дараалал алдагдсан, хэт олон ажлыг бөөнөөр нь нэг цаг хугацаанд шахсан, хүлээгдэж байгаа үр дүн нь үе шаттайгаар бус нэгэн зэрэг гарах магадлалтай. Ийм үед бодлогын үр нөлөө аль үйл ажиллагааг хэрэгжүүлсний улмаас бий болж байгаа нь мэдэгдэхгүй, нэг арга хэмжээ нь нөгөө арга хэмжээний үр нөлөөг бууруулах, улмаар хүлээгдэж буй үр дүнд сөргөөр нөлөөлөх боломжтой.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд зориулж, 2010 оноос 2018 оныг дуустал хугацаанд нийт 485.6 тэрбум төгрөг зарцуулсан ба зарцуулалт жилд дунджаар 7.2 тэрбум төгрөгөөр буюу 36.3 хувиар өссөн байна. Сүүлийн 2 жилд мал



аж ахуйн салбарт зарцуулагдаж байгаа хөрөнгө оруулалтын ихэнх хувийг дэд бүтэц, МАА-н гаралтай бүтээгдэхүүний үйлдвэр барьж байгуулахад зарцуулагдаж байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд орон нутагт гарсан гол үр дүнгүүдийг дүгнэн авч үзвэл:

- Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн ажил үйлчилгээний чанарыг сайжруулж, лабораторийн оношлогооны чадавхыг бэхжүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, вакцинжуулалтад хамруулснаар гоц халдварт, халдварт өвчний гаралт орон нутагт 23.3-100 хүртэл хувиар буурсан байна.
- Малчдын зүгээс мал эмнэлгийн үйлчилгээнд хамтран ажиллах идэвх сул байна.
- Малын бүртгэл, мэдээллийн системийг хөгжүүлэхэд санхүүжилт хомсдолтой байгаа нь тус хөтөлбөрийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна.
- Малын ашиг шимийг сайжруулах, омог, үүлдрийг баталгаажуулах, сайн үр дүнтэй үржүүлгийн ажлыг гүйцэтгэхэд зориулан орон нутгийн төсвөөс 2016-2019 онд нийт 95.8 тэрбум төгрөгийг зарцуулсан нь малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд эерэг нөлөө үзүүлсэн.
- Бэлчээрийг сэлгээн өнжөөх, сэргээх, хашиж хамгаалах талаар малчдыг чадавхжуулах үйл ажиллагаа хэрэгжүүлсний үр дүнд улсын хэмжээнд 300 орчим мянган га бэлчээрийн талбайг малчид зохистой ашиглаж байна.
- Хадлан тэжээл бэлтгэл, нөөц бүрдүүлэлтийг аймгууд өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан гүйцэтгэж байгаа хэдий ч байгаль, уур амьсгал, техник тоног төхөөрөмж, санхүүгийн хомсдлоос шалтгаалан зарим жилүүдэд хангалттай хэмжээнд бэлтгэж чадахгүй байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөр болон “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг хооронд давхцал ихтэй. Тиймээс орон нутгийн түвшинд Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ Монгол мал хөтөлбөрийн хэрэгжилтэд оруулсан ажлаа давхардуулж оруулах хандлагатай. Үүнийг ХШҮ-ний жил жилийн тайланд бас дурдаж байсан.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт малчдад эерэг үр нөлөө үзүүлсэн хэдий ч хамрах цар хүрээ хязгаарлагдмал байгаа нь малчдаас авсан судалгааны үр дүнгээс харагдаж байна.



## ТАВ. ЗӨВЛӨМЖ

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ хийсний дүнд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн цаашдын хэрэгжилтэд дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй. Үүнд:
  - 1.1. Хөтөлбөрийн 4-р тэргүүлэх чиглэл болох уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхтай мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд төлөвлөсөн үйл ажиллагаануудын хэрэгжилтийг хангах, мөн удаашралтай явагдаж байгаа ажлын гүйцэтгэлийг цаг тухайд нь хэрэгжүүлэх хэрэгтэй. Тухайлбал бэлчээрийн даацтай уялдуулан малын тооны дээд хязгаарыг тогтоох, сүргийн бүтцийг оновчтой болгох, мал аж ахуйн эрсдэлийг бууруулах зорилгоор малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг ажлуудыг эрчимжүүлэх хэрэгтэй.
  - 1.2. Хөтөлбөрийн 2-р тэргүүлэх чиглэл буюу малын үржлийн ажил, үйлчилгээг боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд малын тоо биш чанар, ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор үржил, селекцийн ажлыг өргөн цар хүрээтэй гүйцэтгэх шаардлагатай байна. Түүнчлэн дотооддоо үйлдвэрлэх үрийн хэмжээг нэмэгдүүлэх, малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг хөгжүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй.
  - 1.3. Мөн хэрэгжиж эхлээгүй үйл ажиллагаануудыг яаралтай хэрэгжүүлж эхлүүлэх шаардлагатай. Тухайлбал хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Мал хамгаалах сангийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах, хэлэлцүүлэг хийх, Бэлчээрийг хамгаалах тухай хуулийг хэлэлцүүлж, батлуулах, Мал, амьтны эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, мөн мал, амьтны тэжээлийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх шаардлагатай байна. Бэлчээрийн тухай хуулийн нэг чухал хэсэг нь “бэлчээрийн төлбөр” бөгөөд тухайн төлбөрөөс олсон орлогыг орон нутгийн бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх, бэлчээрийн экосистемийг хамгаалах, бэлчээрийг зохистой ашиглах боломж бүрдэнэ.
2. 2021 онд “Монгол мал” үндэсний хөтөлбөр хэрэгжиж дуусна, тиймээс энэ баримт бичгийн залгамж бодлогын баримт бичиг боловсруулах бэлтгэл ажлыг ХХААХҮЯ хэрэгжүүлэх шаардлагатай. Учир нь малын эрүүл мэнд, үржил селекц, ашиг шимийн үзүүлэлтийг дээшлүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний тогтолцоог хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд тус баримт бичиг чухал ач холбогдолтой байна. Тус хөтөлбөрийн залгамж болох бодлогын баримт бичиг боловсруулахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

- 2.1. Тэргүүлэх чиглэл тус бүрийг хоорондоо уялдаа холбоотой, давхцал багатай, тодорхой болгох шаардлагатай ба бусад бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, авч хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондоо маш нягт уялдаатай байх шаардлагатай, цаашлаад мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай алхмуудыг хийх ёстой. Тухайлбал, бэлчээр, усны нөөцийг зохистой ашигласан, хөдөөгийн ард иргэдийн амьжиргааг тэтгэсэн, орон нутагт сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай.
- 2.2. Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн тоо хэт олон, зарим тохиолдолд хэрхэн хэмжих нь ойлгомжгүй байна. Тодорхой, оновчтой шалгуур үзүүлэлт тогтоож, түүнийг тогтмол хэмжих арга зүйг боловсруулж мөрдүүлэх нь зүйтэй. Нэг шалгуур үзүүлэлтэд олон үр дүнг хэмжих олон үзүүлэлт оруулахгүй байх, тоон үзүүлэлтээр хэмжигдэх шалгуур үзүүлэлтийн хувьд зорилтот түвшинг бодлого хэрэгжих үе шат тус бүрт тодорхой тавьж өгөх хэрэгтэй. Орон нутгаас тоо мэдээ цуглуулж байхад ажиглагдсан зүйл нь аймаг, сум, багийн түвшинд хийгдсэн ажил тус бүрийг бүх бодлогын үр дүн болгож яам болон дээд шатны байгууллагад илгээж байна. Ингэснээр яг ямар бодлого хэрэгжүүлсний улмаас тухайн үр дүн гарсан нь тодорхойгүй байсаар, бодлогын хийдэл, давхцал бий болж байна. Үүний нэг тод жишээ нь “Монгол мал” үндэсний хөтөлбөр болон “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” юм. “Төрөөс малчдын талаар баримтлах” бодлого нь МАА-н салбарт ажиллаж, амьдарч байгаа хүнийн нөөц, хүний хөгжил, хөдөөгийн хөгжлийн асуудлыг түлхүү оруулахаар боловсруулагдсан боловч түүний үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нь харахад “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгддэг ажлууд давхардан орсон байх тохиолдол бий.
- 2.3. Бодлогын баримт бичигт малчдын боловсрол, соёл, нийгмийн үйлчилгээг нэмэгдүүлэх зэрэг бодлогын арга хэрэгслийг түлхүү оруулах, мөн хөдөөгийн ядуурлыг бууруулах, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, малчид нэмэлт орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэх чадавхыг бэхжүүлэх асуудлыг түлхүү тусгах шаардлагатай.
3. Цаашид батлагдсан бодлогын баримт бичгийг орон нутагт хэрхэн хэрэгжүүлэх, хүлээгдэж буй үр дүнд хэрхэн хүрэх, явцын болон эцсийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хэрхэн хийх талаар нэгдсэн ойлголт бий болгох уулзалт семинарыг ХХААХҮЯ-ны ХШҮДАГ тодорхой давтамжтайгаар, эсвэл бодлого хэрэгжихээс өмнө зохион байгуулах шаардлагатай. Ингэснээр орон нутгийн мэргэжилтнүүдийн тус бодлогын талаар мэдлэг, мэдээлэл сайжирч бодлогын хүлээгдэж буй үр дүнд эерэг



нөлөө үзүүлж, шалгуур үзүүлэлтийг хангах боломж нэмэгдэнэ. Одоогийн байдлаар бодлогын баримт бичиг хоорондын ялгааг орон нутгийн төрийн албан хаагчид тэр бүр сайн мэдэхгүй байх тохиолдол байна.

4. Мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангахад дараах зүйлсийг төрийн бодлого, шийдвэрт тусгах нь зүйтэй. Үүнд:
  - 4.1. Бэлчээрийн тухай хуулийг батлуулах ажлыг эрчимжүүлэх, бэлчээрийн төлбөр, түүний орлогыг эргүүлээд бэлчээрийн оновчтой менежментэд зарцуулах механизмыг хууль эрх зүйн орчноор тэтгэх,
  - 4.2. Мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа иргэдэд очих эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, даатгалд хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэх,
  - 4.3. Залуу малчид, тэр дундаа залуу малчин гэр бүлийг урамшуулах, дэмжих, тэдэнд 1-3 жилийн хугацаатай хямд хүүтэй зээл олгож, өрхийн аж ахуй эрхлэх ур чадварт сургах системтэй сургалтыг төрийн байгууллага зохион байгуулах,
  - 4.4. Малчин хүүхдүүдийн сургууль завсардалтыг бууруулах, чанартай боловсрол, сургалтын эрүүл орчныг орон нутагт бий болгох,
  - 4.5. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн системийг хөгжүүлж, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ олгох замаар хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах, чанарын ялгамжтай байдлаар зах зээлд үнэ тогтох боломжийг бүрдүүлэх, өөрөөр хэлбэл өндөр ашиг шимтэй, зах зээлийн үнэ нь бусад төрлийн бүтээгдэхүүнээс өндөр байж чадвал малчид малын тоонд биш чанарт анхаарч эхэлнэ,



## ЗУРГАА. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ҮСХ (2019) Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, Улаанбаатар, Монгол Улс,  
[http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=XAA%202018\\_last.pdf&ln=Mn](http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=XAA%202018_last.pdf&ln=Mn)

УИХ (2010) Монгол мал үндэсний хөтөлбөр, 23-р тогтоол,  
<https://www.legalinfo.mn/law/details/7039>

ХХААХҮЯ (2019) Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товч танилцуулга: 2018 оны жилийн эцсийн байдлаар,  
<http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/huuli2018.pdf>

ХХААХҮЯ (2019) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт (2018 оны жилийн эцсийн байдлаар),  
[http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tailany20181\(1\).pdf](http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tailany20181(1).pdf)

ХХААХҮЯ (2019) Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга (2018 оны жилийн эцсийн байдлаар),  
<http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/zghot20184.pdf>

ХХААХҮЯ (2019) “Аймгуудын хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн ХШҮ-ний ажлын товч танилцуулга”,  
<http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/AimagUnelgee20190221.pdf>

МУЗГ (2017) Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам,  
<https://www.legalinfo.mn/annex/details/7750?lawid=12578>

ХХААХҮЯ (2016) “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны буюу 2016-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/61 дүгээр тушаалын хавсралт,

ХХААХҮЯ (2017) “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны ажлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн товчоо (2016 оны жилийн эцсийн байдлаар), Улаанбаатар, ХХААХҮЯ

ХХААХҮЯ (2018) “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны ажлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан (2017 оны жилийн эцсийн байдлаар) Улаанбаатар, ХХААХҮЯ


ХХААХҮЯ (2019) “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны ажлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан (2018 оны жилийн эцсийн байдлаар) Улаанбаатар, ХХААХҮЯ





## ДОЛОО. ХАВСРАЛТ

### 7.1 ХАВСРАЛТ 1. БҮХ АЙМГУУДЫН ХХААГ-Т ХҮРГҮҮЛСЭН АЛБАН БИЧИГ



**МОНГОЛ УЛСЫН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,  
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,  
И-мэйл: mofa@mofa.gov.mn, Вэбсайт: www.mofa.gov.mn

2019.09.18 № 01/3581  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хамтран ажиллах тухай

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ-тай ажил гүйцэтгэх 190820/10-304, 190820/10-303 тоот гэрээг тус тус байгуулан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг гүйцэтгүүлж байна.

Иймээс үнэлгээний ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг хавсралт хүснэгтийн дагуу үнэн зөв бөглөж 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор [tumee\\_0329@yahoo.com](mailto:tumee_0329@yahoo.com), [batnaran@mul.s.edu.mn](mailto:batnaran@mul.s.edu.mn) имэйл хаяг болон эх хувиар ирүүлнэ үү.


Холбоо барих утас: 99032932, 99839839

Хавсралтын мэдээллийн файлыг дараах линкээс татаж авна уу.

<https://www.dropbox.com/s/x09zu3dkbubnhvm/havsralt.xlsx?dl=0>

Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА



Т.ЖАМБАЛЦЭРЭН

00006289

Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны  
09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/384  
1 дүгээр хавсралт

1. “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилттэй холбоотой тоо, мэдээ  
1.1 “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтэд төсөвлөсөн төсөв,  
төсвийн зарцуулалт, огноо

№	Үзүүлэлт	2016	2017	2018	2019
1	Монгол мал үндэсний хөтөлбөрийн II үе шатыг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн орон нутгийн төсөв (Аймгийн хэмжээнд) (Төгрөг)				
1.1	Орон нутгийн төсвөөс зарцуулсан зарцуулалт (ТӨГРӨГ)	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулсан байдал (Төгрөг)s			
1.2		Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд (Төгрөг)			
1.3		Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалтад зориулан зарцуулсан зардал (Төгрөг)			
1.4		Ус, худаг шинээр гаргах, хуучин худаг сэргээн засварлахад зарцуулсан зардал (Төгрөг)			
1.5		Хадлан бэлтгэлтэй холбоотой зардал (Төгрөг)			
1.6		Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэлд зарцуулсан зардал (Төгрөг)			
1.7		Малчдын эрүүл мэндэд зарцуулсан зардал (Төгрөг)			
1.8		Малчдын боловсролд зарцуулсан зардал (Төгрөг)			
1.9		Малчдын амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардал (Төгрөг)			
1.10		Дэд бүтцийн зардал (зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт) (Төгрөг)			
1.11		Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулан зарцуулсан зардал (Төгрөг)			
	Нийт				

- 1.2 “Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтийн үр дүн, алдаа дутагдал, санал, шүүмж

№	Үзүүлэлт	Монгол мал үндэсний хөтөлбөрийн II үе шат хэрэгжиснээр		
		Гарсан үр дүн	Алдаа дутагдал	Санал, шүүмж
2.1	Малын эрүүл мэндийн үйлчилгээ			
2.2	Малын генетик нөөц, үржил селекц			
2.3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалт			
2.4	Ус, худаг шинээр гаргах, хуучин худаг сэргээн засварлах			
2.5	Хадлан бэлтгэл			
2.6	Тэжээлийн ургамал тариалалт, бэлтгэл			
2.7	Малчдын эрүүл мэнд			
2.8	Малчдын боловсрол			
2.9	Малчдын амьжиргааг дээшлүүлэх			
2.10	Дэд бүтэц ( зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт)			
2.11	Эрчимжсэн мал аж ахуй			



Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны  
09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/337/ албан тоотын  
2 дугаар хавсралт

2. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-той холбоотой тоо мэдээ  
2.1 “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д төсөвлөсөн орон нутгийн төсөв,  
төсвийн зарцуулалт, огноо

№	Үзүүлэлт	2016	2017	2018	2019
1	Төрөөс малчдын талаар баримтлах бодлогод төсөвлөсөн орон нутгийн төсөв (Аймгийн хэмжээнд) (Төгрөг)				
1.1	Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулсан байдал (Төгрөг)				
1.2	Малын генетик нөөц, үржил селекцийн арга хэмжээнд (Төгрөг)				
1.3	Бэлчээр хамгаалах, бэлчээр сэргээх, бэлчээрийн зохистой ашиглалтад зориулан зарцуулсан зардал (Төгрөг)				
1.4	Ус, худаг шинээр гаргах, хуучин худаг сэргээн засварлахад зарцуулсан зардал (Төгрөг)				
1.5	Хадлан бэлтгэлтэй холбоотой зардал (Төгрөг)				
